

«ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ» СЭТГҮҮЛЭЭ ЗАХИАЛААРЫН

«Төрийн мэдээлэл» сэтгүүлд Улсын Их Хурлаас батлан гаргаж байгаа хууль тогтоомжууд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг захирамжууд, Үндсэн хуулийн Цэцгийн шийдвэр, Засгийн газрын чухал тогтоолууд болон Монгол Улсын хуулиудын талаарх Улсын Дээд Шүүхийн хуулийн тайлбарууд бүрэн эхээрээ хамгийн түргэн шуурхай нийтлэгддэг билээ.

«Төрийн мэдээлэл» сэтгүүл нь тус улсын үйлдвэр, аж ахуйн газар, хууль хяналт, санхүүгийн байгууллага, улсын болоод хувийн компани, ХЭАА, нүүс хоршооллын удирдах хүмүүс, санхүү-эдийн засгийн ажилтнуудын өдөр тутмын ажлын хэрэгцээнд зориулагдсан ширээний ном юм.

Сэтгүүлийн нэг бүрийн үнэ 500 төгрөг бөгөөд II улирлын нийт захиалгын үнэ 2500 төгрөг болно.

Таны найдвартай туслагч, хууль зүйн үнэнч зөвлөгч «Төрийн мэдээлэл» сэтгүүлээ өргөнөөр захиалан уншигцаана уу.

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№ 1996 оны 2-р сар № 2 / 45 /

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | |
|-----------------------------------------------------------------------------------------------------|-----|
| 1. Онц байдлын тухай | 124 |
| 2. Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 138 |
| 3. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай | 138 |
| 4. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай | 151 |
| 5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай | 152 |
| 6. Хуулийн зарим бүлэг, зүйл болон зарлиг хүчингүй болсонд тооцох тухай | 152 |
| 7. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 153 |
| 8. Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 154 |
| 9. Гэрээ соёрхон батлах тухай | 154 |
| 10. Гэрээ соёрхон батлах тухай | 155 |

II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | |
|------------------------------------------------------------------|-----|
| 11. Г.Нямдоог Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай №82 | 156 |
| 12. Ж.Бямбажавыг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай №83 | 156 |

13. Ц.Балжжүүг Төрийн хянан шалгах хорооны гишүүнээр
томилгох тухай №85

157

III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

14. Батаагийн Жавзандулам, Бадамсүрэнгийн Цэцэг нарт
Монгол Улсын гавьяат жүжигчин цол олгох тухай №223 158
15. Хоролдаваагийн Гэрэлчимэгт Монгол Улсын гавьяат
жүжигчин цол олгох тухай №224 158
16. Шүүгчийн өмсгөлийн загвар, хэрэглэх журмыг
батлах тухай № 250 159
17. Ц.Цолмонг элчин сайдаар томилгох тухай №252 160
18. Д.Пунцагийг элчин сайдаар томилгох тухай №06 161
19. Л.Эрдэнэчулуунд дипломат цол олгох тухай №09 161
20. Л.Баяртад дипломат цол олгох тухай №10 162

IV. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭН

21. Монгол Улсын Засгийн газраас Айбекс групптэй
1993 оны 4 дүгээр сарын 17-нд байгуулсан
Түнцтэлийн гэрээ Үндсэн хууль зөрчсөнтэй
холбогдуулан Ерөнхий сайд П.Жасрайг огцруулах эсэх
тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай №07 163

V. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

22. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийг хэрэг-
жүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай № 101 175
23. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай №102 177
24. Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай №104 178
25. Үнэт цаасны хоёр дахь зах зээл, бэлэн мөнгөний
арилжаа эхлүүлэхтэй холбогдуулан авах зарим арга
хэмжээний тухай №106 181
26. Журам батлах тухай №111 182
27. Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим
арга хэмжээний тухай №143 185
28. Төрийн захиргааны болон үйлчилгээний албаны албан
хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг шинэчлэн
батлах тухай №145 242

VI. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

29. ЭБШ хуулийн хэргийг давж заалдах журмаар хянан
хэлэлцэх талаарх зарим зүйл, хэсэг, заалтыг
тайлбарлах тухай №372 245

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 11 дүгээр
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь онц байдал зарлах үндэслэл, журам, онц байдлын үед хэрэгжүүлэх онцгой арга хэмжээ, онц байдлыг хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрхийг тогтоож, онц байдал зарласантай холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Онц байдлын тухай хууль тогтоомж

Онц байдлын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Онц байдал

Монгол улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор энэ хуульд заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэмийг онц байдал гэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Онц байдал зарлах үндэслэл, журам

4 дүгээр зүйл. Онц байдал зарлах үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуульд заасан ёсоор дор дурасан онцгой нөхцөл бий болсон үед онц байдал зарлаж болно:

1/ улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нэс, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг,

гэнэтийн бусад аюул /газар хөдлөлт, хүчтэй салхи, ган, зуд, үер, гүймэр, цацраг идэвхт болон химийн хорт бодисын хордуулалт, хүн, малын гоц халдварт өвчин зэрэг/ тохиолдсон;

2/ Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон.

5 дугаар зүйл. Онц байдал зарлах

1. Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулган чуулж байх үед бий болсон бол Улсын Их Хурал онц байдал зарлах тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл Улсын Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний нэгтээс доошгүйн санаачилгаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

2. Онц байдал зарлах тухай Улсын Их Хурлын шийдвэрийн чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар батална.

3. Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт бий болсон бөгөөд үй; явцын өрнөлт нь онц байдал нэн даруй зарлахын шаардаж байгаа хойшлуулшгүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч Онц байдал зарлах тухай зарлиг гаргана.

4. Ерөнхийлөгч энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу онц байдал зарласан бол Улсын Их Хурал уул зарлигийг гарсан өдрөөс хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал онц байдал тогтоох шаардлагагүй гэж үзвэл уул шийдвэр гарсан өдрөөс эхлэн Ерөнхийлөгчийн зарли хүчингүй болно.

5. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2-г заасан үндэслэлээр онц байдал зарлахын өмнө Улсын Их Хурал, түүний чөлөөт цаг Монгол Улсын Ерөнхийлөгч нийтийн эмх замбараагүй байдал бий болгосон, түүнд оролцсон байгууллага, хүмүүст уг үйлдлээ 12 цагийн дотор таслан зогсоохгүй бол онц байдал тогтоож болохыг урьдчилан сануулна. Хэрэв заасан хугацаанд уул онцгой нөхцөл хэвээр үргэлжилбэл энэ зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасны дагуу онц байдал зарлана.

6. Онцгой нөхцөлийн үйл явцын өрнөлт нь онц байдал нэн даруй зарлахыг шаардаж байгаа хойшлуулшгүй тохиолдолд энэ зүйлийн 1 дахь хэсэгт заасан урьдчилан сануулах арга хэмжээг авалгүйгээр онц байдал зарлана.

7. Онц байдал зарлах тухай санаачлагчийн төсөл Улсын Их Хурлын шийдвэр, эсхүл Ерөнхийлөгчийн зарлигт дор дурдсан зүйлийг заавал тусгана:

1/ онц байдал зарлах үндэслэл болсон онцгой нөхцөл;

2/ онц байдлын зорилго;

3/ онц байдал хамрах нутаг дэвсгэр;

4/ онц байдал үргэлжлэх хугацаа /эхлэх, дуусах он, сар, өдөр, цаг/;

5/ онц байдлын үед энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээний алийг нь хэрэгжүүлэх болон хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрийн, түүний дотор иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлах хүрээ заагийг бий болсон нөхцөлд нийцүүлэн тогтоох;

6/ энэ зүйлийн энэ хэсэгт заасан болон энэ хуулийн холбогдох бусад заалт, түүнчлэн онц байдал зарласантай холбогдуулан авах арга хэмжээг шууд хариуцаж хэрэгжүүлэх төрийн байгууллага, албан тушаалтан, тэдгээрийн энэ талаар эдлэх онцгой бүрэн эрхийг энэ хуульд нийцүүлэн нэг бүрчлэн тогтоох;

7/ онц байдал зарлах тухай Улсын Их Хурлын шийдвэр, эсхүл Ерөнхийлөгчийн зарлиг хүчин төгөлдөр болох он, сар, өдөр, цаг.

6 дугаар зүйл. Онц байдал үргэлжлэх хугацаа, түүнийг сунгах,

онц байдал дуусгавар болох, онц байдлыг цуцлах

1. Онц байдал үргэлжлэх хугацааг Улсын Их Хурал тогтооно.

2. Онц байдал зарлахал хүргэсэн нөхцөл бүрэн арилтагүй тохиолдолд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал онц байдлын үргэлжлэх хугацааг сунгаж болно.

3. Онц байдал тогтооход хүргэсэн онцгой нөхцөл бүрэн арилсан тохиолдолд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал онц байдлыг хугацаанаас нь өмнө цуцална.

7 дугаар зүйл. Онц байдал зарлах, түүний хугацааг сунгах,

онц байдлыг цуцлах тухай шийдвэр

хүчин төгөлдөр болох

1. Онц байдал зарлах, түүний хугацааг сунгах, онц байдлыг цуцлах тухай шийдвэр нь түүнд өөрөөр заагаагүй бол гарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Онц байдал зарлах, түүний хугацааг сунгах, онц байдлыг цуцлах тухай шийдвэрийг түүнийг хэрэгжүүлэх байгууллагад нэн даруй үргүүлд, олон түмний мэдээллийн хэрэгсэл, боломжтой бусад аргаар нийтэд шуурхай мэдээлж, албан ёсоор нийтэлнэ.

3. Онц байдал зарласан тохиолдолд гадаад харилцааны асуудал ирхэлсэн сайд онц байдлын үед Монгол Улс Иргэний болон улс тө-

рийн эрхийн тухай олон улсын пактаар хүтээсэн үүргээс татгалзахад хүргэсэн хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахтай холбогдсон ямар онцгой арга хэмжээг, ямар үндэслэлээр авч хэрэгжүүлэхээр тогтоож байгаа болон түүнийгээ хэдийд шуцлах тухайгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад нэн даруй мэдээлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх

8 дугаар зүйл. Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах байгууллага

1. Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах онцгой чиг үүргийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл/ цаашид "Зөвлөл" гэх/ эрхлэн гүйцэтгэнэ.

2. Улсын Их Хурал Зөвлөлийн тэргүүний сандал болгосноор онц байдал үргэлжлэх хугацаагаар Зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөж болно.

9 дүгээр зүйл. Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх талаархи Зөвлөлийн онцгой бүрэн эрх

1. Зөвлөл онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэхдээ дор дурдсан онцгой бүрэн эрх эдэлнэ:

1/ онц байдал зарлах тухай Улсын Их Хурлын шийдвэр буюу Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, явцад нь хяналт тавьж, биелэлтийг хангуулах шаардлагатай арга хэмжээ авах;

2/ онц байдал зарлах тухай Улсын Их Хурлын шийдвэр буюу Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилтийг холбогдох байгууллагад хянан шалгах, шаардлагатай бол тэдгээрийн удирдлагын илтгэл, мэдээллийг сонсож, үүрэг даалгавар өгөх;

3/ шаардлагатай асуудлыг Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэх;

4/ онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад заавал биелүүлэх үүрэг даалгавар өгөх;

5/ онц байдал тогтоосон шийдвэр түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврыг зохих ёсоор биелүүлээгүй Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурал болон Засгийн газарт ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын удирдах албан тушаалтан, аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийг онц байдлын хугацаагаар түдгэлзүүлж, орны хүнийг томилох, шаардлагатай гэж үзвэл тэдгээрийг огцруулах тухай асуудлыг эрх бүхий байгуулла-

гад оруулж шийдвэрлүүлэх;

6/ онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар холбогдох байгууллагаас мэдээ, судалгаа, шаардлагатай бусад баримт бичиг гаргуулан авах;

7/ онц байдал үргэлжлэх хугацанд Зөвлөлийн ажлын аппаратыг бэхжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

8/ онц байдал тогтоосон нутаг дэвсгэрт Зөвлөлийн бүрэн эрхт төлөөлөгч томилж ажиллуулах;

9/ шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Зэвсэгт хүчний ерөнхий штаб, цагдаа, тагнуул, хил болон иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн төв байгууллагуудын дарга нарын бүрэлдэхүүнтэй шуурхай штаб байгуулж ажиллуулах;

10/ онцгой нөхцөлийн үр дагаварыг арилгах асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай харилцах, хамтран ажиллах, туслалцаа авах;

11/ онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хууднаар олгосон бусад онцгой бүрэн эрх.

2. Зөвлөл хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргана. Зөвлөлийн тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч гарын үсэг зурна. Санал зөрвөл Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд Ерөнхийлөгч зарниг гаргана.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 9-д заасны дагуу байгуулагдсан шуурхай штаб онц байдлын үр дагаварыг арилгахад оролцож байгаа цагдаа, тагнуул, цэргийн анги, салбарын өдөр тутмын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж шуурхай удирдлагаар хангах, нийгмийн болон хүн амын амьдралыг хэвийн болгоход эдгээр байгууллагын хүч хэрэгслийг дайчлах үүрэг хүлээнэ.

4. Онц байдал тогтоосон нутаг дэвсгэрт байгаа төр, нам, олон нийт, хоршооллын төв, орон нутгийн байгууллага аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлж байгаа төрийн байгууллага, албан тушаалтанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж, гаргасан шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг хэлбэрэлтгүй биелүүлэх үүрэгтэй.

5. Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөлөөс оруулсан саналыг Улсын Их Хурал хэлэлцэх асуудлын дараалал харгалзахгүйгээр нэн даруй, тэргүүн ээлжинд шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл. Засаг даргын онцгой бүрэн эрх

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан үндэстэлээр онц байдал тогтоосон бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах-

онцгой бүрэн эрх эдэлнэ:

1/ энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 6-д заасан бүрэн эрхийг тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх;

2/ энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг тухайн нутаг дэвсгэрт удирдан зохион байгуулах;

3/ тухайн болон доод шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаварт харшилж байна гээ үзвэл онц байдлын хугацаанд үйлчлэлийг зогсоох;

4/ онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар тухайн нутаг дэвсгэрийн холбогдох байгууллага, албан тушаалтан, харьяалал харгалзахгүйгээр заавал биелүүлэх үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд нь хяналт тавих;

5/ онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөл, Засаг даргаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалтныг огцруулж, орны хүнийг онц байдлын хугацаагаар томилох;

6/ онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор тухайн нутаг дэвсгэрт тусгай үүрэг гүйцэтгэж байгаа цагдаа, тагнуул, цэргийн болон бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, харилцан ажиллагааг хангах;

7/ онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх зорилгоо тэдгээрт нийцүүлэн захирамж гаргах.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу хууль тогтоомжийн нийцүүлэн гаргасан Засаг даргын захирамжийг тухайн нутаг дэвсгэ дэх аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэл заава биелүүлэх үүрэгтэй.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ Засаг дарга энэ хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлса аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын аливаа шийдвэрийг түүнчлэн дээд шатны Засаг дарга нь доод шатны Засаг даргы аливаа шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох эрхтэй.

11 дүгээр зүйл. Бүрэн эрхт төлөөлөгчийн онцгой бүрэн эрх

1. Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасны дагуу томилогдсон Бүрэн эрхт төлөөлөгч дор дурдсан онцгой бүрэн эрх эдэлнэ:

1/ энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 6-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

2/ нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга Онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхгүй буюу зохих ёсоор биелүүлэхгүй байвал гүйцэтгэлийг шаардаж, тодорхой үүрэг даалгавар өгч, гүйцэтгэлд нь хяналт тавих;

3/ онц байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас гаргасан шийдвэр онц байдал тогтоосон шийдвэр түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаварт харшилж байна гэж үзвэл онц байдлын хугацаанд үйлчлэлийг зогсоох;

4/ онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгавар, Засаг даргын захирамжийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтныг огцруулах саналыг Засаг даргад тавих.

2. Бүрэн эрхт төлөөлөгчөөс энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасны дагуу өгсөн үүрэг даалгаврыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга заавал биелүүлэх үүрэгтэй.

3. Бүрэн эрхт төлөөлөгчөөс энэ зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасны дагуу тавьсан саналыг Засаг дарга хүлээн авснаас хойш 24 цагийн дотор шийдвэртэй, хариу мэдэгдэнэ.

12 дугаар зүйл. Онцгой нөхцөл, түүний үр дагаварыг арилгахад цэргийн зарим анги, байгууллагыг татан оролцуулах

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан онцгой нөхцөл, түүний үр дагаварыг арилгах, нийгмийн амьдралыг хэвийн болгоход нутгийн захиргааны болон цагдаа, дотоодын цэргийн хүч хэрэгсэл хүрэлцэхгүй байгаа тохиолдолд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд зэвсэгт хүчин, хилийн цэргийн зарим анги, байгууллагыг татан оролцуулж болно:

1/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 5, 6, 7, 3 дахь хэсгийн 1, 2, 3, 5, 6, 7, 8, 9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх;

2/ онц байдлын үр дагаварыг арилгах, аврах, хамгаалах, сэргээн босгох ажилд оролцуулах.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу онц байдлыг хэрэгжүүлэх арга хэмжээнд зэвсэгт хүчин, хилийн цэргийн зарим анги, байгууллагыг татан оролцуулах шийдвэрийг Зөвлөл гаргана.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцож байгаа зэвсэгт хүчин, хилийн цэргийн анги, байгууллага, тэдгээрийн бие бүрэлдэхүүн үүрэг гүйцэтгэхдээ хууль тогтоомжоор цагдаа, дотоодын цэрэгт зөвшөөрөгдсөн зэвсэг, тусгай сэрэгсэл ашиглаж эрх, үүргийг нь эдэлнэ.

13 дугаар зүйл. Онц байдлын арга хэмжээг санхүүжүүлэх

Онцгой нөхцөл, түүний үр дагаварыг арилгахтай холбогдсон ари хэмжээг Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэх бөгөө шаардлагатай асуудлыг Засгийн газар Улсын Их Хуралд оруул шийдвэрлүүднэ.

14 дүгээр зүйл. Онц байдлын үе дэх шүүхийн үйл ажиллагаа

1. Онц байдал тогтоосон нутаг дэвсгэрт шүүн таслах ажиллагаа зөвхөн Үндсэн хууль, Шүүхийн тухай хуулийн дагуу байгуулагдса шүүх хэрэгжүүднэ. Бүх шатны шүүх шүүн таслах ажиллагааг он байдал зарлах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулийн дагу явуулна.

2. Улсын Дээд шүүх онц байдал тогтоосон нутаг дэвсгэрт эрү иргэний хэргийн нутаг дэвсгэрийн харьяаллыг өөрчилж болно.

15 дугаар зүйл. Онц байдал үргэлжлэх хугацаанд цаазаар авах ял гүйцэтгэхгүй байх

Онц байдал үргэлжлэх хугацаанд үйлдсэн гэмт хэрэгтээ цаазаар авах ял шийтгэгдсэн хүний ялыг онц байдал үргэлжлэх хугацааг болон онц байдал дуусгавар болсон, онц байдлыг цуцласнаг хойшхи 30 хоногт гүйцэтгэж болохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Онц байдлын үед хэрэгжүүлэх онцгой арга хэмжээ

16 дугаар зүйл. Онцгой арга хэмжээ

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан үндэслэлтээр онц байдал тогтоосон бол дор дурдсан онцгой арга хэмжээ тогтоож болно:

1/ онц байдал тогтоосон нутаг дэвсгэрт зорчих, орох, гарч онцгой журам тогтоох;

2/ улсын онц чухал болон хүн амын амьжиргааны хангамжийг объектуудыг хүч нэмэгдүүлэн хамгаалах;

3/ хууль тогтоомж зөрчиж зохион байгуулсан жагсаал, цуглааг олон нийтийн бусад арга хэмжээг хуульд заасан арга, хүч хэрэгслэг шууд албадан тараах;

4/ ажил хаяхыг хориглох;

5/ тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, тэдгээрт үлг хийх;

6/ аж төрөхөд нэн аюул бүхий нутаг дэвсгэрээс хүн, мал, амьтаг эд баялгийг түр нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгчдэд тусламж үзүүлг тэднийг аврах, хамгаалах, орон байр, хүнс тэжээлтээр ханг асуудлыг зохион байгуулах, шаардлагатай гэж үзвэл хүнс тэжээг бусад нэн хэрэгцээт зүйлийг хуваарилан олгох, түүнд хяналт тавг журам тогтоох;

7/ хорио цээр тогтоох, хүн, мал, амьтны халдварт болон гоц алдварт өвчинтэй тэмцэх шаардлагатай бусад арга хэмжээ авах;

8/ онцгой нөхцөлийн улмаас бий болсон хор уршгийг арилгах орилгоор улсын нөөц, төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгж, байгууллагын тээврийн хэрэгсэл, хүнс эжээлийн нөөцийг дайчлах шаардлагатай гэж үзвэл бусад аж ахуйн нэгж, байгууллагын нөөцийг дайчилж нөхөх олговор, үнийг төлөх,

9/ улс орны болон тухайн нутаг дэвсгэрийн эдийн засгийн амьдал хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад нэн чухал үрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагад тусгай дэглэм тогтоож гөрдүүлэх.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 9-д заасны дагуу тогтоох тусгай дэглэм нь дор дурдсан хүрээгээр хязгаарлагдана:

1/ ажлын өдөр, цагийн дэглэм, ээлжийг өөрчлөн тогтоох;

2/ үндсэн ба эргэлтийн хөрөнгө, түүний дотор түүхий эд, материалын нийлүүлэлт, зарцуулалт, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хадгалалт, хуваарилалт, тээвэрлэлт, борлуулалтад тусгай журам тогтоож, яналт тавих;

3/ хөдөлмөр, үйлдвэрлэл, технологийн сахилгыг чанд сахин бэхлүүлэхэд чиглэсэн хөдөлмөрийн сахилга, үйлдвэрлэлийн аюул солгүй ажиллагааны болон олон нийтийн хэв журам сахиулах тусгай журам тогтоож, тэдгээрийг зөрчигчдөд харьяалал харгалзахгүйгээр зохих хариуцлага хүдээлгэх;

4/ шаардлагатай гэж үзвэл төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгж, байгууллагын зохион байгуулалтын үтэц, үүрэг, хөдөлмөрийн норм, цалин хөлсийг шинэчлэн тогтоох, үйлдвэрлэлийн зориулалт, технологийн горимыг өөрчлөх бүх шатны гурдах ажилтныг томилго, чөлөөлөх;

5/ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажилчин албан хаагчдыг өөрсдийнх нь хүсэлтээр ажлаас өөрчлөх, халахыг хориглох,

6/ онцгой нөхцөлийн улмаас бий болсон хор уршгийг арилгах нийцлүүлшгүй тохиолдолд хөдөлмөрийн нийтийн дайчилгаа явуулах;

7/ онц байдлын хугацаанд ажилчин, албан хаагчийг өөрийнх нь өшөөрөлгүйгээр хөдөлмөрийн гэрээнд зааснаас өөр ажилд шилүүлэн ажиллуулах, нөхөх олговортойгоор илүү цагаар ажиллуулах;

8/ тусгай дэглэмтэй аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулахгүй байх шаардлагатай бусад арга хэмжээ авах.

3. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т заасан үндэслэлээр онц ялдал зарласан бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дор дурдсан нэмэлт онцгой арга хэмжээ тогтоож болно:

1/ нийтийн эмх замбараагүй байдал бий болгож хүч хэрэглэсэн үйл ажиллагаа явуулсан буюу явуулж байгаа байгууллагыг тараах бүлэг хүмүүсийг албадан тараах, албадан саатуулах, тэдгээрийн зэвсэг, техник хэрэгслийг хураан авах;

2/ хөл хорих, өөрөөр хэлбэл төрийн эрх бүхий байгууллагын тусгайлан олгосон зөвшөөрлийн болон иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиггүйгээр гудамж, талбай, олон нийтийн бусад газарт хоногийн тодорхой цаг хугацаанд зорчихыг хориглох. Энэ заалтыг зөрчсөн этгээдийг цагдаа буюу цэргийн эрүүд хөл хорих цаг дуустал, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиггүй бол хэн болохыг нь тогтоох хүртэл, гэхдээ 72 цагаас илүүгүй хугацаагаар албадан саатуулах, шаардлагатай гэж үзвэл албадан саатуулагдсан хүний бие, авч яваа эд зүйлд үзлэг хийх;

3/ шаардлагатай гэж үзвэл иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичгийг шалгах, галт зэвсэг, хүний амь нас, эрүүд мэндэд хохирол учруулж болох бусад зүйлийг хууль бусаар авч явах буюу хадгалж байгаа, эсхүл хэрэглэж болзошгүй гэж үзэх үндэслэл байгаа бол иргэдийн бие, орон сууц, тээврийн хэрэгсэл, эд зүйлд үзлэг хийх;

4/ олшруулах болон дуу авиаг чангаруулах техник хэрэгслийн ашиглалтыг хязгаарлах буюу хориглох, шаардлагатай бол түр хураан авах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох, эсхүл онц байдлыг цуцлах хүртэл үйл ажиллагааг нь зогсоох;

5/ холбооны хэрэгсэл ашиглах тусгай журам тогтоох;

6/ нийтийн эмх замбараагүй байдлыг арилгахад саад учруулж буй улс төрийн нам, эвсэл холбоо, олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг зогсоох;

7/ онц байдал зарласан нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүй оршин сууж байгаа бөгөөд онцгой дэглэм сахиулахад саад учруулсан этгээдийг байнга оршин суух газарт нь, эсхүл онц байдал тогтоогоогүй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж рүү албадан гаргах;

8/ зэвсэг, галт хэрэгсэл, хүчтэй үйлчлэх химийн хорт бодис согтууруулах ундааны зүйл худалдах, тараахыг хориглох;

9/ иргэдийн эзэмшилд байгаа галт болон хүйтэн зэвсэг, галт хэрэгсэл, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэртэлийн технологи, хэрэглэдэг тэсэрч дэлбэрэх, хүчтэй үйлчлэх химийн хорт болон цацраг идэвхт бодис, сургалтын зориулалттай байлдааны зэвсэг техник хэрэгслийн ашиглалтад хяналт тогтоох, шаардлагатай гэж үзвэл ашиглалтыг зогсоох буюу тэдгээрийг түр хураан авах.

ТАВДУГААР БҮЛЭГ

Онц байдлын үед иргэдийн эрх, эрх чөлөөг
хязгаарлах хүрээ

17 дугаар зүйл. Онцгой арга хэмжээг тогтоох, хэрэглэх
хүрээ заагийн хязгаарлалт

1. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээ зааг нь бий болсон онцгой нөхцөлийн шаардлага Монгол улсын олон улсын гэрээгээр хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгт нийцэж байхаас гадна хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байвал зохино.

2. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг онц байдал зарлаагүй нутаг дэвсгэрт хамааруулахыг хориглоно.

18 дугаар зүйл. Онц байдлын үед үл хөндөгдөх
иргэний эрх, эрх чөлөө

Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасны дагуу тогтоох хүний эрх, эрх чөлөөний хязгаарлалт нь хүнийг имд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх, үлөө, түүрхэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий сандахыг хориглосон Үндсэн хуулийн заалтыг үл хөндөнө.

19 дүгээр зүйл. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулахгүй байх

Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу тогтоосон онц байдал үргэлжлэх сугааанд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй.

20 дугаар зүйл. Иргэдийн сонгох, сонгогдох эрх,
эрх чөлөөний хязгаарлалт

1. Улсын нийт нутаг дэвсгэрт онц байдал тогтоосон бол онц байдал дуусгавар болох, эсхүл түүнийг цуцлах хүртэл аливаа сонгууль, ард нийтийн санал асуулга явуулж болохгүй.

2. Улсын нийт нутаг дэвсгэрийн зарим хэсэгт онц байдал тогтоосон бол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгууль явуулах, эсэх тухай асуудлыг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

3. Улсын нийт нутаг дэвсгэрийн зарим хэсэгт онц байдал тогтоосон бол тухайн нутаг дэвсгэрийн өөрөө удирдах байгууллагын өлөөлөгчдийн сонгуулийг онц байдал дуусгавар болох, эсхүл үүнийг цуцлах хүртэл хойшлуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Онц байдлын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

21 дүгээр зүйл. Цагдаагийн ба цэргийн алба хаагч, төрийн албан хаагчийн хүлээх хариуцлага

Онц байдлын үед хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх хууль зөрчсөн, бүрэн эрхээ хэтрүүлсэн, түүнчлэн албан үүргээ зох ёсоор биелүүлээгүй буюу энэ хуулийн 18 дугаар зүйлд заас иргэний эрх, эрх чөлөөний баталгааг зөрчсөн цагдаагийн цэргийн алба хаагч, төрийн албан хаагч нь хууль тогтоомжид заас хариуцлага хүлээнэ.

22 дугаар зүйл. Онц байдлын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Онц байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүги хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтг ногдуулна:

1/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагу тогтоосон журам зөрчсөн иргэнийг 25000-50000, албан тушаалтн 30000-60000 төгрөгөөр торгох;

2/ ажил хаялт зохион байгуулсан байгууллагыг 250000-5000 иргэн, албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр торгох, эс иргэн, албан тушаалтныг 14-30 хоногийн хугацаагаар баривчлах;

3/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д заасны да тогтоосон хүнс, тэжээл, бусад нэн хэрэгцээт зүйлийг хуваарил олгох журам зөрчсөн иргэнийг 25000-50000, албан тушаалтн 50000-100000 төгрөгөөр, уул журмын биелэлтэд хяналт тавих үүр зохих ёсоор биелүүлээгүй албан тушаалтныг 20000-60000 төгрөг торгох, эсхүл 7-14 хоногийн хугацаагаар баривчлах;

4/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагу тогтоосон хорио цээрийн дэглэмийг зөрчсөн этгээдийг 5000 100000 төгрөгөөр торгох;

5/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заас нөөцийн дайчилгаанаас зайлсхийсэн аж ахуйн нэгж, байгууллаг 250000-500000, иргэн албан тушаалтныг 10000-100000 төгрөг торгох, эсхүл иргэн, албан тушаалтныг 14-30 хоногийн хугацааг баривчлах;

6/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3, 4-д заасны дагуу тогтоосон журам зөрчсөн иргэнийг 20000-50000, алб тушаалтныг 25000-100000 төгрөгөөр торгох;

7/ онцгой нөхцөлийн улмаас бий болсон хор уршгийг арилгах өдөлмөрийн нийтийн дайчилгаанд татан оролцуулах, өөр ажилд илгжүүлэх, илүү цагаар ажиллуулах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг биелүүлэхээс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зайлсхийсэн этгээдийг 5000-50000 төгрөгөөр торгох;

8/ онц байдлын үед ажилчин, албан хаагчийг өөрийнх нь үсэлтээр хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаас өөрчилсөн, халсан албан тушаалтныг 10000-50000 төгрөгөөр торгох;

9/ эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 5, 2 дахь хэсгийн 1, 2, 3, 6, 7-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд саад учруулсан, эсэргүүцсэн, хүл хүч хэрэглэн эсэргүүцсэн иргэнийг 10000-50000, албан тушаалтныг 25000-100000 төгрөгөөр торгох, эсхүл 14-30 хоногийн хугацаагаар баривчлах;

10/ холбооны болон олшруулах, дуу авиаг чангаруулах техник эргэлийн ашиглалтын талаар тогтоосон журмыг зөрчсөн байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-250000, албан тушаалтныг 25000-100000, иргэнийг 25000-50000 төгрөгөөр торгох, эсхүл иргэн, албан тушаалтныг 14-30 хоногийн хугацаагаар баривчлах;

11/ олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд тогтоосон хяналтын урмыг зөрчсөн, үйл ажиллагааг нь түр зогсоосон тогтмол хэвлэлийг хэвлэлд бэлтгэсэн, үйлдвэрлэсэн, тараасан, худалдсан, борлуулсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж аж ахуйн нэгж, ийгууллагыг 100000-500000, албан тушаалтныг 50000-100000, иргэнийг 30000-100000 төгрөгөөр торгох, эсхүл иргэн, албан тушаалтныг 1-30 хоногийн хугацаагаар баривчлах;

12/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 8 дахь заалтыг зөрчсөн бол хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хурааж аж ахуйн нэгж, байгууллагыг 250000-500000, албан тушаалтныг 50000-100000, иргэнийг 50000-75000 төгрөгөөр торгох, эсхүл иргэн, албан тушаалтныг 14-30 хоногийн хугацаагаар баривчлах;

13/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 9-д заасан всэг, галт хэрэгсэл, бодис, техник хэрэгслийг зориулалт бусаар рэглэсэн, хэрэглэх бололцоо олгосон аж ахуйн нэгж, байгууллагыг 0000-500000, албан тушаалтныг 50000-100000, иргэнийг 50000-100000 төгрөгөөр торгох, эсхүл иргэн, албан тушаалтныг 14-30 хоногийн хугацаагаар баривчлах;

14/ онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлдэхтэй лбогдуулан, Зөвлөл, Засаг дарга, Бүрэн эрхт төлөөлөгчөөс өгсөн рэг даалгавар, тэдгээрээс энэ хуулийн дагуу гаргасан тогтоол, хирамжийг биелүүлээгүй албан тушаалтныг 25000-50000, иргэнийг

20000-40000 төгрөгөөр торгох, эсхүл 7-14 хоногийн хугацаагаар баривчлах.

2. Энэ хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 6-д заасны дагуу үйл ажиллагаа нь зогссон улс төрийн нам, эвсэл холбоо, олон нийтийн байгууллагын хөрөнгийг улсын орлого болгоно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14-т заасан шийтгэлийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороонь Засаг дарга, 1, 3, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13-т заасан шийтгэлийн цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, 2, 3, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14-т заасан шийтгэлийг аймгийн төв, нийслэлийн дүүрэгт шүүгч, сумын төв, бусад суурин газарт сумын Засаг дарга, 4, 6-д заасан шийтгэлийг хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч, 14-т заасан шийтгэлийг Зөвлөл, түүний Бүрэн эрхт төлөөлөгч тус тус ногдуулж 2 дахь хэсэгт заасан байгууллагын тарааж, хөрөнгийг нь улсын орлого болгох шийдвэрийг Улсын Дээд шүүх гаргана.

23 дугаар зүйл. Бусдад учруулсан гэм хорыг
нөхөн төлүүлэх

Онц байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн бусдад учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус гэм хорыг хууль тогтоомжид заасны дагуу бүрэн нөхөн төлүүлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

24 дүгээр зүйл. Онц байдал дуусгавар болсон, цуцлагдсанаас үүсэх үр дагавар

Онц байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн бүх актыг онц байдал дуусгавар болсон түүнийг цуцалсан үеэс эхлэн хүчингүй болгоно.

25 дугаар зүйл. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн онц байдлын тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөх

Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Онц байдлын тухай хууль тогтоомжийг Монгол Улсын иргэний нэгэн адил дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 11 дүгээр
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 7¹ дүгээр зүйл нэмсүгэй:

"7¹ зүйл. Зөвлөлийн онцгой бүрэн эрх

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсны улмаас онц байдал зарлах тухай шийдвэр буюу Ерөнхийлөгчийн зарлиг хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн онц байдал үргэлжлэх хугацаанд Зөвлөл онц байдлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах онцгой чиг үүрэг гүйцэтгэнэ. Энэ чиг үүргийн дагуу Зөвлөлийн хэрэгжүүлэх онцгой бүрэн эрхийг Онц байдлын тухай хуулиар тогтооно."

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ БОЛОН ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН БУСАД АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр торгох, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах, эд хөрөнгө хураах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг эдлүүлэх, цаазаар авах ялыг гүйцэтгэх, тэнсэгдсэн болон шүүхийн

таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан ялтныг хянан харгалзах, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хууль тогтоомж

1. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг мөрдөнө.

3 дугаар зүйл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн зарчим

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэхэд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хууль шүүхийн шийдвэрт зааснаар хязгаарлах, шүүхийн шийдвэр заавал биелэх, ялтан зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчмыг баримтална.

4 дүгээр зүйл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл нь зөвхөн шүүхийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, магадлал, тогтоол, шүүгчийн захирамж /цаашид "шүүхийн шийдвэр" гэх/ байна.

5 дугаар зүйл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагууд

1. Торгох, эд хөрөнгө хураах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх алыг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба эдлүүлнэ.

2. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах алыг цагдаагийн болон тодорхой албан тушаалд томилсон буюу сонгосон, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон төрийн захиргааны болон бусад байгууллага эдлүүлнэ.

3. Хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял нь тэнсэгдсэн, түүнчлэн хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй ялтанд тавих хяналтыг сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн байгууллага, цэргийн анги, байгууллага тус тус гүйцэтгэнэ.

4. Сэтгэл мэдрэлийн өвчтэй буюу согтуурах мансуурах донтой этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх бөгөөд албадан эмчлэх үүрэг бүхий эмнэлгийн байгууллагын харуул хамгаалалтын үүргийг цагдаагийн байгууллага хүлээнэ.

6 дугаар зүйл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэхэд прокурор хяналт тавих

1. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд Улсын ерөнхий прокурор, түүний харьяа прокурорууд хяналт тавина.

2. Прокурор хорихоос өөр төрлийн ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг эдлүүлж, хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага уг үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянан шалгах, хууль зөрчсөн үйлдлийг илрүүлэх, түүнийг таслан зогсоох болон ялтны зөрчигдсөн эрхийг сэргээх арга хэмжээг цаг алдалгүй авахуулах буюу өөрөө авах үүрэгтэй.

3. Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэрэглэсэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц шүүх шийдвэрийн хувийг прокурорт нэн даруй хүргүүлнэ.

7 дугаар зүйл. Ялтны эрх, үүрэг

1. Ялтан дараахь нийтлэг эрх эдэлнэ:

1/ шүүхээс оногдуулсан ял эдлэх нөхцөл, журам болон өөрийнхөө эрх, үүрэг, хязгаарлалтын талаар тайлбар мэдээлэл авах;

2/ ял эдлүүлэх болон түүнд хяналт тавих үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах;

3/ хууль, шүүхийн шийдвэрээр хязгаарласан буюу хориглосноос бусад эрх, эрх чөлөө.

2. Ялтан дараахь нийтлэг үүрэгтэй байна:

1/ ял эдлүүлэх байгууллагын хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

2/ оршин суугаа газрын цагдаагийн байгууллагад тогтоосон журмын дагуу сард 1 удаа очиж бүртгүүлж байх;

3/ байнга оршин суугаа газраас 7 хоногоос дээш хугацаагаар гадагш явах бол цагдаагийн байгууллагад урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авах;

4/ хууль, шүүхийн шийдвэрээр тогтоосон бусад хязгаарлалт, хүлээлгэсэн үүрэг.

8 дугаар зүйл. Ял эдлүүлэх байгууллагын нийтлэг үүрэг

1. Ял эдлүүлэх байгууллага дараахь нийтлэг үүрэгтэй байна:

1/ энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актад тодорхойлсон ялтны эрх үүрэг, ял эдлүүлэх нөхцөл, журмын талаар ялтанд шаардлагатай тайлбар, мэдээлэл өгөх;

2/ ял эдлүүлэх ажиллагааны талаар ялтан болон бусад этгээдийн гаргасан өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэж харну өгөх;

3/ тэнсэгдсэн болон хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй ялтанд хяналтын хувийн хэрэг хөтөлж ял эдлэлтийн талаар тэмдэглэл хийж байх;

4/ ялтны засрал хүмүүжил, ял эдлэлтийн байдалд хяналт тавьж, хуульд заасан тохиолдолд ялтанд оногдуулсан ялыг тэнсэх, солих, биечлэн эдлүүлэх санал хүсэлтээ ялтны оршин суугаа газрын шүүхэд гаргах;

5/ хуульд заасан бусад үүрэг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх журам

9 дүгээр зүйл. Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1. Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц шүүх шийдвэрийн хувь, гүйцэтгэх хуудсыг ялтны оршин суугаа буюу ажиллаж байгаа, эсхүл эд хөрөнгө нь байгаа газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэгч /цаашид "шийдвэр гүйцэтгэгч" гэх/-д нэн даруй хүргүүлднэ.

2. Шийдвэр гүйцэтгэгч торгуулийн мөнгийг 90 хоногийн дотор шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд тушаах, уг хугацаанд торгууль төлөөгүй буюу бүрэн төлөөгүй бол ялыг албадан гүйцэтгэхийг 7 хоногийн дотор ялтанд мэдэгдэх хуудсаар сануулна.

3. Ялтан торгуулийн мөнгийг зохих банкны байгууллагад бүрэн тушааснаар торгох ялыг бодитой биелүүлсэнд тооцож шийдвэр гүйцэтгэгч энэ тухай шийдвэр гаргасан шүүх болон ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурорт мэдэгдэнэ.

4. Шийдвэр гүйцэтгэлийн дансанд шилжин ирсэн торгуулийн мөнгийг ажлын 2 хоногт багтаан улсын төсвийн орлогод шилжүүлднэ.

10 дугаар зүйл. Торгох ялыг албадан гүйцэтгэх

Ялтан энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд торгуулийг төлөөгүй буюу бүрэн төлөөгүй бол шийдвэр гүйцэтгэгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд

заасан журмын дагуу торгуулийн мөнгийг ялтны эд хөрөнгөөс албадан гаргуулна.

11 дүгээр зүйл. Торгох ялыг хорих ялаар солих санал гаргах

1. Ялтан эд хөрөнгө, цалин орлогоо нуух, бусдад хууль бусаар шилжүүлэх, үрэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэлгүйгээр байнга оршин суугаа газраа дур мэдэн өөрчлөх зэргээр ял эдлэхээс ноцтойгоор зайлсхийвэл шийдвэр гүйцэтгэгч зохих шалгалт явуулж торгох ялыг хорих ялаар солих тухай саналыг шүүхэд гаргана.

2. Шийдвэр гүйцэтгэгчийн санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүтийн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу торгох ялыг хорих ялаар сольж болно.

12 дугаар зүйл. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг үндсэн болон хорихоос өөр төрлийн ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц шүүх шийдвэрийн хувийг уг албан тушаалд томилсон, сонгосон, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон төрийн захиргааны болон бусад байгууллагад хүргүүлж, ялтны оршин суугаа газрын цагдаагийн байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүхийн шийдвэр хүлээн авсан байгууллага ялтныг тухайн албан тушаалд томилсон, сонгосон, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон шийдвэрээ хүчингүй болгож шаардлагатай бол мэргэжлийн үнэмлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон баримт бичгийг хураан авч, энэ тухай шийдвэр гаргасан шүүх болон ялтны оршин суугаа газрын цагдаагийн байгууллагад 10 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

3. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг хорих ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол хорих анги ялтныг суллагдмагц шүүхийн шийдвэрийн хувь, шаардлагатай бол хувийн баримт бичгийг ялтны оршин суух газрын цагдаагийн байгууллагад нэн даруй хүргүүлднэ.

4. Цагдаагийн байгууллага энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн мэдэгдэл, шүүхийн шийдвэр, баримт бичгийг хүлээн авмагц ялтныг дуудан ирүүлж ялын хугацаанд шүүхээс хориглосон албан тушаал эрхлэх буюу үйл ажиллагаа явуулж болохгүйг түүнд анхааруулж ял эдлэлтийн байдалд тавих хяналтыг хэрэгжүүлднэ.

5. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял шийтгүүлсэн этгээд ял эдлэх хугацаанд шинээр

ажил албан тушаалд орох буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх бол цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл авна.

6. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял эдлүүлэхэд хяналт тавих журмыг Монгол Улсын Засгийн газар Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн тогтооно.

13 дугаар зүйл. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага

Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

14 дүгээр зүйл. Эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1. Эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц шүүх шийдвэрийн хувь, гүйцэтгэх хуудас, эд хөрөнгө дансалсан буюу битүүмжилсэн актыг ялсны эд хөрөнгө байгаа газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй хүргүүлнэ.

2. Шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрт заасан эд хөрөнгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар хураана.

3. Шүүхийн шийдвэрт заасан эд хөрөнгийг бүрэн хурааж улсын орлогод оруулснаар эд хөрөнгө хураах ялыг бодитой биелүүлсэнд тооцож шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх хуудсыг хааж, шийдвэр гаргасан шүүхэд мэдэгдэнэ.

4. Хураасан эд хөрөнгийг улсын орлогод оруулах, буцаан олгох журмыг Монгол Улсын Засгийн газар тогтооно.

15 дугаар зүйл. Эд хөрөнгө хураах ялыг биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх

1. Шүүхийн шийдвэрт хураахаар заасан эд хөрөнгийг үрэгдүүлсэн, нуусан, бусдад шилжүүлсэн, завшсан гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас тухайн эд хөрөнгөд учирсан хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлж, улсын орлогод оруулна.

16 дугаар зүйл. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц шүүх шийдвэрийн хувийг шийдвэр гүйцэтгэгч, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг эдлүүлэхээр заасан аж ахуйн нэгж, байгууллагын захиргаанд тус тус хүргүүлнэ.

2. Аж ахуйн нэгж байгууллагын захиргаа дор дурдсан үүрэгтэй байна:

1/ шүүхийн шийдвэр хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор ялтныг эрхэлж байсан ажил, албан тушаалд нь үлдээх, эсхүл аж ахуйн нэгж, байгууллага дотроо өөр ажил албан тушаалд шилжүүлэн ажиллуулах эсэхийг хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэж, хамт олонд мэдээлэх;

2/ ял эдлэх хугацааны турш ялтны цалин хөлснөөс шүүхийн шийдвэрт заасан хэмжээгээр суутгал хийх;

3/ ялтанд хууль тогтоомжийн дагуу оногдуулсан сахилгын шийтгэл болон сайшаал, урамшууллын талаар шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж байх;

4/ ялтны хүсэлтээр хөдөлмөрийн гэрээг цуцлахгүй, ял эдлэх хугацаанд нь ээлжийн амралт олгохгүй байх;

5/ ялантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4-т заасан үндэслэлээр цуцлахад хүрвэл түүнийг ажлаас өөрчилсөн, чөлөөлсөн тухай шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэх.

3. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял эдлүүлэхэд хяналт тавих журмыг Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн тогтооно.

17 дугаар зүйл. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял эдэлж буй ялтны цалин хөлснөөс суутгал хийх

1. Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа ялтны цалин хөлснөөс суутгал хийхдээ дараахь журмыг баримтална:

1/ суутгалыг ажилласан сар бүрийн сүүлтний цалин хөлснөөс, харин ажлаас халах үед тухайн сард ажилласан хугацааны цалин хөлснөөс хийнэ;

2/ ялтан ажил хавсран хийж байгаа бол ажлын газар тус бүр цалин хөлснөөс суутгал хийнэ;

3/ цалин хөлснөөс суутгасан мөнгийг гүйцэтгэх хуудас байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд шилжүүлнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасны дагуу шийдвэр гүйцэтгэлийн дансанд шилжиж ирсэн мөнгийг шийдвэр гүйцэтгэгч ажлын 2 хоногт багтаан улсын төсвийн орлогод шилжүүлнэ.

18 дугаар зүйл. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял эдлэх хугацааг тооцох

1. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял эдлэх хугацааг ялтны цалин хөлснөөс суутгал хийсэн сар, өдрөөр тооцно.

2. Ялтан шүүхээс оногдуулсан ялын хугацаанд ногдох ажлын өдрөөс цөөнгүй өдөр ажилласан байвал зохих бөгөөд ажиллаагүй

өдрийг энэ хуульд зааснаар ял эдэлсэн хугацаанд оруулан тооцох үндэслэлгүй байвал дутуу ажлын өдрийг нөхөн ажиллуулна.

3. Жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцно.

4. Ял эдлэх хугацаанд согтуурах, мансууруулах зүйл хэрэглэх, хуурамчаар өвчлөх, бие эрхтэн эрүүл мэнддээ сандаятайгаар гэмтэл учруулах, захиргааны журмаар баривчлагдах, албадан саатуулагдах, цагдан хоригдох зэрэг шалтгаанаар ажиллаагүй хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцохгүй.

5. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял эдлэх хугацаа дууссан бол тухайн өдрөөс, хуульд заасан бусад үндэслэлээр ялаас чөлөөлсөн бол энэ тухай баримт бичиг ялтны ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад ирсэн өдрөөс эхлэн хуулиар тогтоосон эрхийн хязгаардалтыг зогсооно.

19 дүгээр зүйл. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг өөр төрлийн ялаар солих

1. Шүүхийн шийдвэр гарсны дараа ялтныг хөдөлмөрийн чадвар алдсанд тооцсон, ялтан хөдөлмөрт үнэнч шударга хандаж засарч хүмүүжсэнээ баттай харуулж чадсан, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4-т заасан үндэслэлээр хөдөлмөрийн гэрээг цуцалсан бол засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих буюу уг ялыг хугацааны өмнө тэнсэх тухай саналыг шийдвэр гүйцэтгэгч шүүхэд гаргана.

2. Ялтан хөдөлмөрийн сахилгыг удаа дараа зөрчих, хөдөлмөрийн харилцааг шууд цуцлахаар гэрээнд заасан зөрчил гаргах, ажлаа дур мэдэн орхих зэргээр ял эдлэхээс ноцтой зайлсхийвэл аж ахуйн нэгж, байгууллага энэ тухай шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх бөгөөд шийдвэр гүйцэтгэгч зохих шалгалт хийж засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хорих ялаар солих тухай саналаа холбогдох баримт бичгийн хамт шүүхэд шилжүүлнэ.

3. Шийдвэр гүйцэтгэгчийн санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуулийн 27 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хорих ялаар сольж болно.

4. Шийдвэр гүйцэтгэгчийн санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэнсэх буюу өөр төрлийн хөнгөн ялаар сольж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Цаазаар авах ялыг гүйцэтгэх

20 дугаар зүйл. Цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1. Цаазаар авах-буудан алах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэвээр баталсан бол уг шийдвэрийг ялтанд 10 хоногийн дотор мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор анхан шатны шүүх ялтнаар амь уучлахыг хүссэн өргөдөл гаргуулах буюу хэрэв өргөдөл гаргах хүсэлгүй бол энэ тухай протокол үйлдэж Улсын Дээд шүүхэд ирүүднэ.

2. Улсын Дээд шүүх өргөдөл буюу протоколыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хэргийн хамт Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүднэ.

3. Ерөнхийлөгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор ялтанд уучлал үзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно.

4. Ялтанд уучлал үзүүлсэн эсэх тухай хариуг прокуроор дамжуулан өгнө.

5. Ерөнхийлөгч ялтанд уучлал үзүүлээгүй бол ялыг зохих журмын дагуу гүйцэтгэнэ.

6. Цаазаар авах ялыг гүйцэтгэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батална.

7. Уучлалын асуудлыг шийдвэрлэх хүртэл цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг түдгэлтээүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх

21 дүгээр зүйл. Тэнсэгдсэн ялтныг хянан харгалзах

1. Хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэнсэж хянан харгалзах тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц шийдвэрийн хувийг ялтны оршин суугаа газрын цагдаагийн, эсхүл цэргийн анги байгууллагад хүргүүлж, сум, дүүргийн Засаг дарга, уг этгээдийн ялыг тэнсэх тухай хүсэлт гаргасан буюу хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйг нэгж, байгууллага буюу иргэнд ялыг тэнссэн тухай бичгээр мэдэгдэнэ.

2. Ялыг тэнсэх тухай хүсэлт гаргасан буюу хараа хяналтад байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллаг иргэн тэнсэгдсэн ялтанг хянан харгалзах хугацааны турш уг ялтн хөдөлмөр эрхлэлт, засрал хүмүүжлийн байдлыг хариуцаж, энэ талаг цагдаагийн байгууллагад үнэн зөв мэдээлэл өгч байх үүрэгтэй.

3. Сум, дүүргийн Засаг дарга өөрийн эрх хэмжээнд хамаарч асуудлын хүрээнд тэнсэгдсэн ялтанд туслалцаа үзүүлж, ялтн хүмүүжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, шаардлагатай бс түүний засрал хүмүүжлийн байдал, гаргасан зөрчлийн талаар цагдаагийн байгууллагатай мэдээлэл солилцоно.

4. Тэнсэгдсэн ялтныг хянан харгалзах талаар цагдаагийн байгуулага дараахь үүрэг хүлээнэ:

1/ шийдвэрийн хувийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотс хяналтын хувийн хэрэг нээж, ялтныг тэнсэх тухай хүсэлт гаргасч буюу хараа хяналтаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуй нэгж, байгууллагын төлөөлөгч буюу иргэнийг дуудан уулзаж тэдгэрийн эрх үүрэг, ялтанд хууль шүүхийн шийдвэрээр тогтоосон хягааралт, даалгасан үүргийг танилцуулах;

2/ ялтан, түүнийг тэнсэх тухай хүсэлт гаргасан буюу хараа хяналтаа байлгаж хүмүүжүүлэхийг зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгуулагын захиргаа буюу иргэнд үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж, биелэлтийг хангуулах;

3/ ялтны засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийг талаар сар тутам хяналтын хувийн хэрэгт тэмдэглэл хийх,

4/ хянан харгалзах хугацаа дуусмагц энэ тухай шүүх болс тэнсэгдсэн ялтанд бичгээр мэдэгдэх.

5. Цэргийн албан хаагчид оногдуулсан ялыг тэнссэн бол хянг харгалзах үүргийг цэргийн анги, байгууллага энэ хуульд заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

22 дугаар зүйл. Ял тэнссэнийг хүчингүй болгож ялыг биеллэн эдлүүлэх

1. Ялтан хянан харгалзах хугацаанд хөдөлмөрийн сахилга, ниймийн хэв журмыг зөрчсөн эсхүл захиргааны шийтгэлийн бүж сахилгын арга хэмжээ авалдсан бол ял тэнссэнийг хүчингүй болго шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг биеллэн эдлүүлэх тухай а ахуйн нэгж, байгууллага, иргэн хүсэлт, Засаг дарга, цагдаагийг байгууллага саналаа ялтны оршин суугаа газрын шүүхэд гаргана.

2. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүсэлт, Засаг дарга цагдаагийн байгууллагын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэ шүүх Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэгт заасн дагуу ял тэнссэнийг хүчингүй болгож, шүүхийн шийдвэрээр оно дуулсан ялыг биеллэн эдлүүлэхээр шийдвэрлэж болно.

23 дугаар зүйл. Хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй ялтныг хянан харгалзах

1. Шүүх насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан бол шийдвэрийн хувийг ялтны ршин суугаа газрын цагдаагийн байгууллагад нэн даруй хүргүүлж, ум, дүүргийн Засаг дарга, ялтныг хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэнд энэ ухай бичгээр мэдэгдэнэ.

2. Насанд хүрээгүй этгээдийг хянан харгалзах талаар цагдаагийн айгууллага дараахь үүрэг хүлээнэ:

1/ шийдвэрийн хувийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногт багтаан аналтын хувийн хэрэг нээж ялтан, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн ялтныг хараа хяналтдаа байлгаж үмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч уюу иргэнийг дуудан уулзаж тэдгээрийн эрх, үүрэг, ялтанд хууль, шүүхийн шийдвэрээр тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг илгцүүлэх;

2/ ялтны эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэнд үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж биелтийг хангуулах;

3/ ялтны сахилга, засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүргийн төлөлтийн талаар сар тутам хяналтын хувийн хэрэгт тэмдэглэл өгөх;

4/ шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагч гэ тухай шүүх болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэх.

3. Засаг дарга ялтанд боловсрол, мэргэжил эзэмшихэд зохих елалцаа үзүүлж, ялтны сахилга, шүүхээс даалгасан үүргийн биеллт, засрал хүмүүжлийн байдлыг шалган танилцаж, шаардлагатай ял цагдаагийн байгууллагатай мэдээлэл солилцоно.

4. Ялтны эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэн түүний засрал хүмүүжлийн байдлыг хариуцан эх зүйн хүмүүжил олгох, иргэнийхээ үүргийг шударгаар биелүүлэг болгон хүмүүжүүлэх, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх нөхцөлөөр хангах арга хэмжээ авах үүрэгтэй.

24 дүгээр зүйл. Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгох, ялаас чөлөөлөх

1. Хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд ялтан өөрийн засарт хүмүүжсэнээ үлгэр жишээ

зан төлөв, сурлага, хөдөлмөрт үнэнч шударга ханддагаараа харуулбал түүнийг ялаас чөлөөлөх тухай саналыг зохих шатны Засаг дарга, эсхүл цагдаагийн байгууллага шүүхэд гаргаж болно.

2. Ялтан шүүхээс даалгасан болон энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй, хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэний итгэл найдварыг хөсөрдүүлсэн, эсхүл нийгмийн хэв журам зөрчиж захиргааны шийтгэлийн арга хэмжээ авагдсан бол хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгож хорих ялыг биеллэн эдлүүлэх тухай Засаг дарга, цагдаагийн байгууллага санал, аж ахуйн нэгж, байгууллага буюу иргэн хүсэлтээ шүүхэд гаргана.

3. Хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүсэлт, цагдаагийн байгууллага, Засаг даргын санал прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх насанд хүрээгүй ялтныг ялаас чөлөөлөх, эсхүл хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгож, шүүхийн шийдвэрээр оногдуулсан хорих ялыг биеллэн эдлүүлэхээр шийдвэрлэж болно.

25 дугаар зүйл. Тэнсэгдсэн болон хорих ялыг нь биелүүлэхийг хойшлуулсан ялтанд хяналт тавих

Хорих, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэнсэж хянан харгалзсан болон хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан ялтны засрал хүмүүжилд хяналт тавих журмыг цагдаагийн төв байгууллага Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн батална.

26 дугаар зүйл. Сэтгэл мэдрэлийн өвчтэй буюу согтуурах мансуурах донтой этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1. Хэрэг хариуцах чадваргүй үедээ нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн, эсхүл хэрэг хариуцах чадвартай байхдаа тийм хэрэг үйлдсэн боловч шүүхийн шийдвэр гарахын өмнө буюу ял эдэлж байх үедээ сэтгэл мэдрэлийн өвчнөөр өвчилж, өөрийн үйлдлийг хариуцаж буюу жолоодож чадахгүй болсон этгээд, түүрчлэн гэмт хэрэг үйлдсэн согтуурах, мансуурах донтой этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх уг этгээдийг сэтгэл мэдрэлийн ердийн буюу тусгай эмнэлгийн алинд байлгахыг шийдвэртээ заана.

2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц уг этгээдийг албадан эмчлэх байгууллагад хүргэх үүргийг цагдаагийн, хэргэв уг этгээд хорих ял эдэлж байсан бол хорих ял эдлүүлэх байгууллага тус тус хүлээх бө-

гөөд шүүхийн шийдвэр, шүүхийн сэтгэл-гэм судлалын шинжилгээний дүгнэлт холбогдох бичиг баримтыг хамтад нь хүргүүлнэ.

3. Шүүхийн шийдвэрээр албадан эмчлүүлж байгаа этгээдийн эмчилгээний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

4. Албадан эмчлүүлж байгаа этгээд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эмнэлгийн болон цагдаагийн байгууллага хамтран авна.

5. Албадан эмчлэх байгууллага дор дурасан үүрэг хүлээнэ:

1/ албадан эмчлүүлж байгаа этгээдэд зайлшгүй шаардлагатай шинжилгээ, эмчилгээг цаг тухайд нь хийж, эмчилгээний явцыг өвчний түүхэнд үнэн зөв, тодорхой бичих;

2/ эмчилгээний үр дүн, өвчний шинж байдлыг харгалзан уг этгээдийг цаашид албадан эмчлэх шаардлагатай эсэхийг сэтгэл-гэм судлалын болон холбогдох мэргэжлийн эмч нарын зөвлөлгөөнөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулах, хэрэв уг арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй гэж үзвэл энэ тухайгаа шүүхэд нэн даруй мэдэгдэх;

3/ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхийг зогсоох тухай шүүхийн шийдвэр хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор албадан эмчлүүлсэн этгээдийг шүүхийн шийдвэрт заасан байгууллага, хууль ёсны төлөөлөгчид хүлээлгэн өгөх.

6. Албадан эмчлүүлж байгаа этгээдийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлт, прокурорын саналаар энэ зүйлийн 5 дахь хэсгийн 2-т заасан дүгнэлтийг албадан эмчлэх хугацаа дуусахаас өмнө гаргуулж болно.

7. Албадан эмчлэх нөхцөл, журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, албадан эмчлэх эмнэлгийн хамгаалалтын журмыг цагдаагийн төв байгууллага тус тус Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн батлана.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

27 дугаар зүйл. Тоо бүртгэл

1. Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, хорих, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэнссэн болон насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан, түүнчлэн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээд болон эдгээр ял, арга хэмжээний хэрэгжилтийн талаархи нэгдсэн тоо бүртгэлийг цагдаагийн байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

2. Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан, хорих, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэнссэн болон насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан, түүнчлэн эмнэлгийн чанартай албадагын арга хэмжээ хэрэглэсэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 хоногийн дотор шүүх энэ тухай бичгээр цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

28 дугаар зүйл. Ялтны цалин хөлснөөс хийсэн суутгал,
торгуулийн мөнгө, хураасан эд хөрөнгийг
буцааж олгох

Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, торгох, эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож ял шийтгэгдсэн этгээдийг цагаатгах шийдвэр гарсан бол цалин хөлснөөс хийсэн суутгал, торгуулийн мөнгө, хураасан эд хөрөнгө буюу түүний үнийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар улсын төвлөрсөн төсвөөс уг этгээдэд буцааж олгоно.

29 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 356 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"356 дугаар зүйл. Торгох буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хорих ялаар солих, хорих ял тэнссэнийг буюу насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгож хорих ялыг биелтэн эдлүүлэх

Торгох буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хорих ялаар солих, хорих ял тэнссэнийг буюу насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсныг

хүчингүй болгож хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай асуудлыг тухайн төрлийн ялыг эдлүүлэх буюу уг ажиллагаанд хяналт тавьж байгаа байгууллагын хүсэлт, санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүгч захирамж гаргаж шийдвэртэнэ. Шүүгчийн энэ захирамжилд ердийн журмаар давж элалдах гомдол гаргах буюу эсэргүүцэл бичиж болно”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар бүлгийн 191 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "торгох" гэсний дараа "засан хүмүүжүүлэх ажил хийлгэх" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛИЙН ЗАРИМ БҮЛЭГ, ЗҮЙЛ БОЛОН ЗАРЛИГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын хууль батлагдсантай холбогдуулан 1981 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн "БНМАУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль"-ийн 17 дугаар

бүлэг, 104 дүгээр зүйлийг, мөн Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1987 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 159 дүгээр зарлигаар батлагдсан "БНМАУ-д хорихоос өөр төрлийн зарим ял эдлүүлэх журам, нөхцөлийн тухай дүрэм"-ийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болгонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн "удаа дараа" гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 210 дугаар зүйлийн "Дансалсан буюу битүүмжилсэн эд хөрөнгийг" гэсний дараа "эд хөрөнгө хураах ял шийтгүүлсэн ялтан буюу", 216 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "биелүүлээгүй бол" гэсний дараа "1 жил хүртэл хугацаагаар хорих буюу" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйлийг хүчингүй болгосугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд дор дурдсан агуулгатай 5, 6 дугаар зүйл нэмсүгэй:

"5 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагч болсон иргэний 1990 оны 3 дугаар сарын 23-наас өмнө нам, олон нийтийн төв, орон нутгийн байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан хугацааг төрийн алба хаасан хугацаатай адилтган тооцно.

6 дугаар зүйл. Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан иргэн төрийн албанд шилжин ажиллавал намын байгууллагад ажилласан дээрх хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцно."

2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийг 7 дугаар зүйл болгон өөрчилсүгэй.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. Бүгд Найрамдах Казахстан Улсын Алматы хотноо 1994 оны 12 дугаар сарын 2-ны өдөр байгуулсан "Сайн дураараа шилжин суурьших болон хөдөлмөрийн гэрээгээр Бүгд Найрамдах Казахстан Улсад ирсэн хүмүүсийн иргэний харьяаллын асуудлыг зо-

хицуулах тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын хоорондын Гэрээ"-г соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. 1995 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Вашингтон хотноо гарын үсэг зурсан Монгол Улс, Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан Хөгжлийн зээлийн гэрээг соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 12 дугаар
сарын 8-ны өдөр

Дугаар 82

Улаанбаатар
хот

**Г. Нямдоог Үндсэн хуулийн цэцийн
 гишүүнээс чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Өөр ажилд томилогдсонтой холбогдуулан Гэндэнгийн Нямдоог
Үндсэн хуулийн цэцийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 12 дугаар
сарын 8-ны өдөр

Дугаар 83

Улаанбаатар
хот

**Ж. Бямбажавыг Улсын Их Хурлын
 гишүүнээс чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх
хэсгийн 2-т заасныг үндэслэн Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:
Улсын Их Хурлын гишүүн Жанлавын Бямбажавын гаргасан хүсэл-
тийг харгалзан Монгол Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 12 дугаар
сарын 8-ны өдөр

Дугаар 85

Улаанбаатар
хот

**Ц. Балжхүүг Төрийн хянан шалгах хорооны
гишүүнээр томилдох тухай**

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дээ
хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Цэвэрэн овогтой Балжхүүг Төрийн хянан шалгах хорооны
гишүүнээр томилсугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 11 дүгээр
сарын 8-ны өдөр

Дугаар 223

Улаанбаатар
хот

**Батаагийн Жавзандулам, Бадамсүрэнгийн
Цэцэг нарт Монгол Улсын гавьяат
жүжигчин цол олгох тухай**

Дэлхийн сонгодог болон үндэсний дуурийн гол дүрүүдэд мэргэжлийн өндөр ур чадвар гарган амжилттай тоглоон үзэгч олны талархал хүлээж, дуурийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сонгодог урлагийн академик театрын гоцлол дуучин Батаагийн Жавзандулам, Бадамсүрэнгийн Цэцэг нарт Монгол Улсын Гавьяат жүжигчин цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 11 дүгээр
сарын 8-ны өдөр

Дугаар 224

Улаанбаатар
хот

**Хоролдаваагийн Гэрэлчимэгт Монгол Улсын
гавьяат жүжигчин цол олгох тухай**

Дэлхийн сонгодог болон үндэсний бүжгийн жүжгийн олон гол дүрийг амжилттай бүтээн тоглож бүжгийн жүжгийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сонгодог урлагийн академик театрын гоцлол бүжигчин Хоролдаваагийн Гэрэлчимэгт Монгол Улсын гавьяат жүжигчин цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 12 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 250

Улаабаатар
хот

Шүүгчийн өмсгөлийн загвар, хэрэглэх журмыг батлах тухай

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын шүүхийн шүүгчийн өмсгөлийн загвар, шүүгчийн өмсгөлийг хэрэглэх журмыг хавсралтын ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАГ

Монгол улсын Ерөнхийлөгчөө 1995
оны 250 дугаар зарлигийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ӨМСГӨЛИЙН ЗАГВАР, ШҮҮГЧИЙН ӨМСГӨЛИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Шүүгчийн өмсгөлийн загвар

1. Монгол Улсын шүүхийн шүүгчийн өмсгөл /цаашид "шүүгчийн өмсгөл" гэх/ нь шүүгчийн хараат бус байдлын бэлгэдэл, шүүхийн нэр төр, сур хүчний илэрхийлэл мөн.

2. Шүүгчийн өмсгөл нь шүүгчийн ажлын онцлогийг харгалзсан, дэлхийн улс орны шүүхийн шүүгчийн албаны өмсгөлийн нийтлэг жишигт үндэслэсэн, монгол үндэсний хувцасны шинжийг тусгасан, хар өнгөтэй байна.

3. Шүүгчийн өмсгөл нь сул чөлөөтэй хэлбэртэй, авирсан захтай, энгэр нь уулзсан зөрлөгтэй, зангидмал таван товчтой, дотортой байна.

4. Мөрний оёлын энгэр талд нугалаас гаргаж хувцсыг өргөн чөлөөтэй болгоно.

5. Шүүгчийн өмсгөлийн зах, бартааны ирмэгүүдийг 5 см-ийн өргөнтэй, хар өнгийн торгомсог даавуугаар эмжинэ.

6. Шүүгчийн өмсгөлийн энгэрийн товч, шилбийг хар өнгийн торгомсог даавуугаар хийнэ.

7. Шүүгчийн өмсгөлийн ханцуй нь үзүүр рүүгээ өргөн хэлбэртэй, нударга маяг гарган залгасан хэсэгт 0,1 см-ийн өргөнтэй хавчуургатай байна.

Хоёр. Шүүгчийн өмсгөлийг хэрэглэх журам

8. Шүүгчийн өмсгөлийг шүүх хуралдааны үед өмсөнө.

9. Шүүгч өмсгөлдөө гүн хүндэтгэлтэй хандаж, түүнийг хайрлан хямгадаж, цэвэр үзэмжтэй байлгана.

10. Шүүгчийг томилогдсоноос хойш 30 хоногийн дотор түүнд шүүгчийн өмсгөлийг олгох бөгөөд шүүгч албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, огцруулагдсан тохиолдолд буцааж авна.

11. Эдэлгээний хугацаа нь дуусаагүй шүүгчийн өмсгөлийг үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд түүний эдэлгээний элэгдлийг хассан үнийг гэм буруутай этгээдээр төлүүднэ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 252

Улаанбаатар
хот

Ц. Цолмонг элчин сайдаар томилж тухай

Цэрэндашийн Цолмонг Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

**Д. Пунцагийг элчин сайдаар томилж
тухай**

Дарийн Пунцагийг Монгол Улсаас Мексикийн Нэгдсэн Улсад
суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 1 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

**Л. Эрдэнэчулуунд дипломат цол олгох
тухай**

Монгол улсаас НҮБ-ын дэргэд суутга Байнгын төлөөлөгч
Лувсангийн Эрдэнэчулуун Монгол, НҮБ-ын харилцааны салбарт
олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж ирэн.

Тэрээр Монгол Улсын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж, НҮБ-ын
Ерөнхий Ассамблейн 20 гаруй чуулганы ажиллагаанд оролцсоны
дотор 5 удаа Монголын төлөөлөгчдийн дэд тэргүүнээр ажиллажээ.

Сүүлийн жилүүдэд Монгол, НҮБ-ын харилцаанд гарч буй нааштай
хандлагууд Л. Эрдэнэчулууны үйл ажиллагаатай холбоотой.

Л. Эрдэнэчулуун НҮБ-ын ойн жилийн Ерөнхий Ассамблейн I
хорооны даргаар сонгогдон ажиллаж, үүргээ сайн биелүүллэв.

Монгол, НҮБ-ын хамтын ажиллагааг өргөтгөх, НҮБ-ын хүрээнд
Монгол Улсын нэр хүндийг бэхжүүлэх, НҮБ-ын үйл ажиллагаанд
манай улсаас хувь нэмэр оруулахад чухал үүрэг гүйцэтгэж байгааг нь
үнэлж, Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суутга Байнгын төлөөлөгч
Лувсангийн Эрдэнэчулуунд "Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд"
дипломат цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 1 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

**Л. Баяртал дипломат цол олгох
тухай**

Монгол Улсын Гадаад харилцааны яамны Олон улсын байгууллагын хэлтсийн дарга Лувсандоржийн Баярт гадаад харилцааны салбарт 20 гаруй жил ажиллахдаа Гадаад харилцааны яамны хэлтсийн дарга, Монгол Улсаас НҮБ-ын Женев дэх салбарын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх зэрэг албыг хашиж, Монгол, НҮБ-ын харилцааг өргөжүүлэх, Монгол улсын гадаад бодлогын салбарт баримтлах чиглэл, үйл ажиллагааг шинэчлэхэд чухал хувь оруулж иржээ.

Л. Баярт ГХЯ-ны Олон улсын байгууллагын хэлтсийн даргаар ажиллах хугацаандаа Монгол Улсаас НҮБ болон түүний системийн байгууллагуудтай харилцах чиг бодлого, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнтэй харилцах талаар баримтлах бодлогын үндсийг боловсруулсан байна. Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48, 49, 50 дугаар чуулганд манай улсын төлөөлөгчийн дэд тэргүүнээр оролцож үүргээ сайн биелүүлдээ.

Гадаад харилцааны салбарын удирдах ажилд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгааг үнэлж, Монгол Улсын Гадаад харилцааны яамны Олон улсын байгууллагын хэлтсийн дарга Лувсандоржийн Баяртал "Онц бөгөөд Бүрэн эрхт элчин" дипломат цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1995 оны 12 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас Айбеке групптэй
1993 оны 4 дүгээр сарын 17-нд байгуулсан
Түншлэлийн гэрээ Үндсэн хууль зөрчсөнтэй
холбогдуулан Ерөнхий сайд П. Жасрайг
огцруулах эсэх тухай маргааныг хянан
шийдвэрлэсэн тухай

Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Цэцийн дарга Г. Совд даргалж гишүүдэд Ц. Цолмон, Н. Жанцан, С. Жанцан, /илтгэгч/ Д. Чидхаажав, хуралдааны нарийн бичгийн даргаар Б. Цэндээхүүг оролцуулж хийв.

Хуралдаанд өргөдөл гаргагч иргэн Д. Ламжав, С. Зориг, А. Ганбаатар, Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч. Пүрэвдорж, Д. Сутар нар оролцов.

Иргэн С. Зориг, А. Ганбаатар, Д. Ламжав нар Монгол Улсын Засгийн газраас Айбеке групптэй 1993 оны 4 дүгээр сарын 17-нд байгуулсан Түншлэлийн гэрээ Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөнтэй холбогдуулан Ерөнхий сайд П. Жасрайг огцруулах үндэслэл байгаа эсэхийг хүсч 1995 оны 6 дугаар сарын 12-нд Үндсэн хуулийн цэцэд өргөдөл өгсөн байна.

Уг өргөдлийг цэцийн гишүүн Ц. Цолмон шалгаад 1995 оны 7 дугаар сарын 21-ний өдөр маргаан үүсгэж Үндсэн хуулийн цэцээр хэлэлцүүлэх үндэслэл байхгүй гэж нэхэмжлэгч нарт хариу өгсөн.

Нэхэмжлэгчид 1995 оны 7 дугаар сарын 28-нд Түншлэлийн гэрээтэй холбогдсон өргөдлийн дагуу хэрэг үүсгэхээс татгалзсан цэцийн гишүүний хариуг хянан үзэхийг хүсч дахин ирүүлсэн өргөдөлдөө "Энэ түншлэлийн гэрээг Ерөнхий сайд анхнаас нь мэдэж байсан. Засгийн газар нуун дарж байсан. Түншлэлийн гэрээгээ илчлэгдсэний дараа өөрийн мэдэлд байдаг төрийн мэдээллийн бүх хэрэгслийг ашиглан улс орон даяар явуулсан сөрөг сурталчилгаандаа гэрээг мушгин гуйвуулж оруулсан, гэрээг шинээр хийх гэж байгаа гэрээний төслөөр орлуулан олон нийтэд мэдээлсээр ирсэн билээ. Ийнхүү цэцийн гишүүн Ц. Цолмонгийн Түншлэлийн гэрээ хүчин төгөлдөр бус байсан" гэсэн дүгнэлт нь баримтаар няцаагдаж байна. Түншлэлийн гэрээ нь Монгол Улсын нэрийн өмнөөс Монголын болон олон улсын эрх зүйн хэм хэмжээг бүдүүлгээр зөрчин байгуу-

лагдсан олон улсын гэрээ мөн болохыг өргөдөл дурдсан албан баримт, Улсын Их Хурлын 1995 оны 7 дугаар сарын 4-ний хуралдаанд Төрийн байгуулалтын байнгын хорооноос оруулсан санал, дүгнэлт зэрэгт дурдсан баримтууд ч давхар нотолж байна. Энэ гэрээний улмаас бизнесийн хүрээнд Монгол Улсын нэр хүндэд хохирол учирч, хувь хүмүүс хууль бус аргаар ашиг хонжоо олсон байна.

Цэцийн гишүүн Ц. Цолмонгийн дурдсан "УАБЗ-ийн зөвлөмжийг үндэслэн уг гэрээг цуцалсан гэснээс ч Түншлэлийн гэрээ хүчин төгөлдөр бус байсан" гэх үндэслэлгүй болох нь харагдаж байна.

Үндсэн хууль болон бусад хуулийг үндэсний аюулгүй байдал, эрх ашигт ноцтой хохирол учруулан өөрчлөхгүйгээр дагаж мөрдөх боломжгүй гэрээ байгуулсан, түүнийг нуун далдалснаараа Ерөнхий сайд Үндсэн хууль зөрчсөн байна. Энэ нь түүнийг огцруулах үндэслэл болж байна.

Засгийн газрын танилцуулгыг хэлэлцсэн тухай Улсын Их Хурлын 1995 оны 7 дугаар сарын 4-ний 64 дүгээр тогтоол нь Улсын Их Хурал өөрийн байгуулсан Засгийн газрыг хяналтаасаа гаргасан, түүнийг хууль бус аргаар хаацайлж байдгийн нэг баримт юм. Одоогийн дагаж мөрдөж байгаа Үндсэн хууль ёсоор Ерөнхий сайдыг санал хураалтын дүнг баримтлан огцруулах, чөлөөлөх тухай шийдвэр гаргаснаас бусад Улсын Их Хурлын ямар ч шийдвэр Ерөнхий сайдыг огцруулах үндэслэл байгаа эсэх тухай хэрэг үүсгэхгүй байхын хууль зүйн үндэслэл болох ёсгүй гэж үзэж байна.

Өргөдөл шалгасан Цэцийн гишүүн, нэхэмжлэгч нарын хэнтэй ч уулзаж тодруулах, давлах санаачилга гаргаагүй атлаа мөн чанартаа маргааны нөгөө талын сонирхлыг хамгаалсан бодитой бус дүгнэлтүүдийг шүүрч авч тэдгээрийг хэрэг үүсгэхгүй байх хууль зүйн үндэслэл гэж үзсэн байна" гэж дурдаад Үндсэн хууль хэрэгжүүлэх, хууль дээдлэх уур амьсгалыг сайжруулах, шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг баталгаажуулах нийтлэг эрх ашгийн үүднээс Цэцийн гишүүний дээрх тогтоолыг хянан магадлаж, хэрэг үүсгэж өгөхийг цэцийн эрхэм гишүүдээс гүнээ хүсье" гэжээ.

Үндсэн хуулийн цэцийн даргын 1995 оны 8 дугаар сарын 2-ны 07 тоот тогтоолоор томилогдсон цэцийн гишүүн Л. Баасан даргатай гишүүдэд Г. Нямдоо, Д. Чилхаажав нар оролцсон 1995 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцээд гаргасан 03 тоот магадлалаар нэхэмжлэгчдийн гомдлыг үндэслэн маргаан хянан шалгах ажиллагаа үүсгэсэн байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл 1995 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс АНУ-ын Айбекс групптэй байгуулсан гэрээ,

хэлцлүүд нь Монгол Улсын ашиг сонирхол, эдийн засгийн аюулгүй байдал, хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх тухай асуудлыг хэлэлцэж энэ түншлэлийн хэлэлцээр болон бусад гэрээ хэлцэл нь тэдгээр компани, корпорацийг Монгол Улсын эдийн засгийн стратегийн ач холбогдолтой салбарт дангаар нь удаан хутагаагаар ноёрхох сөрөг үр дагавартай бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжуудыг зөрчиж, үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаа болсон байна" гэсэн дүгнэлт хийжээ.

Асуудлыг хэлэлцэх явцад Айбекстэй байгуулсан хэлэлцээрт хавсралт протокол байгуулагдсан нь баримтаар тогтоогджээ. Түүнд зааснаар талууд хамтын ажиллагааны тодорхой нэг төсөл хэрэгжтэл хэлэлцээрийг төсөл хэмээн үзэж, анхны төслийг хэрэгжсэний дараа уг хэлэлцээрийг Монгол Улсын Их Хуралд мэдүүлж соёрхон батлуулахаар тохирсон байна" гэж тэмдэглээд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Засгийн газарт Түншлэлийн хэлэлцээрийг даруй хүчингүй болгож, түүний оронд байгуулахаар хэлэлцэж буй эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн төслийг хянан үзэж, хууль тогтоомжид бүрэн нийцүүлж шийдвэрлүүлэх ... Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн гуравны нэгд заасны дагуу авсан арга хэмжээ, түүнчлэн их хэмжээний хөрөнгө оруулахтай холбогдсон бусад гэрээ, хэлцлүүд Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянан үзэж Монгол Улсын Их Хуралд мэдээлэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд мэдээлэл өгч байхыг анхаарахыг даалгасан байна.

Энэ зөвлөмжийг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Засгийн газар уг асуудлыг хуралдаанаараа авч хэлэлцээд Улсын Их Хуралд өгсөн танилцуулгадаа "Монгол Улсын шалар сайд Ч. Пүрэвдорж АНУ-ын Айбекс групптэй 1993 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр "Түншлэлийн гэрээ"-нд тус группийн Зөвлөлийн дарга Халед Ахмед Хоссайнтай Сан-Франциско хотноо гарын үсэг зурсан байна.

Энэхүү "Түншлэлийн гэрээ"-г монгол хэлэнд орчуулалгүйгээр англи хэл дээр байгуулжээ. "Түншлэлийн гэрээ"-нд тусгагдсан асуудлуудад эхнийх нь амжилттай хэрэгжих хүртэл уг гэрээг төсөл гэж үзэх, аль нэг салбарт анхны төсөл хэрэгжиж эхэлсний дараа түүнийг Улсын Их Хуралд оруулж соёрхон батлуулахаар тохиролцож энэ тухай Протокол байгуулсан нь нотлогдов.

Түмэн голын бүсийн хөгжлийн хөтөлбөрийн зөвлөл АНУ-ын иргэн Ааге Холмын зөвлөснөөр хөрөнгө оруулалтын асуудлаар зуучлах саналаа илэрхийлсэн АНУ дахь Айбекс групптэй холбоо тогтоож, түүгээр зуучлуулан Монголд гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар хэрэгжүүлж болох төслүүдийн талаар ярилцаж дээрх баримт бичгийг тохирсон байна.

Уг баримт бичигт "Энэхүү гэрээ байгуулсан өдрөөс хойш 99 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна", "Айбекс"-д хамаарах төслүүдэд олгосон болон энэ гэрээнд тусгасан бүх нөхцөл, эрх зүйлийг Монгол Улс, Монголын Засгийн газар батлан хангаж гэрээний хугацаанд тэдгээрийг Засгийн газрын тухайн үеийн болон шашдын үйл ажиллагаагаар, түүнчлэн аливаа хууль тогтоомжоор өөрчилж, засаж, буцаахгүй, монголын хувьд хуулийн хүчин төгөлдөр дагаж мөрдөх үүрэг гэсэн Монгол Улсын хууль тогтоомжид нийцэхгүй заалт орсон байв.

Энэ нь зах зээлийн харилцаанд шилжсэн орнуудтай хамтран ажиллах туршлага дутмаг байсан, гадаадын хөрөнгө оруулж улсын эдийн засгийн хүндрэлтэй байдлыг богино хугацаанд гэтлэх гэсэн эрмэлзэлд хөтлөгдөж хэт яарч, гэрээг ч газар дээр нь шууд байгуулсан, уг гэрээг хуульд нийцүүлэх талаар нарийвчлан авч үзээгүй, ийм гэрээ байгуулсан тухайгаа Засгийн газар /танхим/, холбогдох байгууллагуудад шуурхай мэдээлээгүй, улмаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтийн дагуу тодорхой ажиллахгүй хугацаа алдсантай холбоотой болохыг Засгийн газрын хуралдаан тэмдэглэж, шадар сайд Ч. Пүрэвдоржид хатуу анхааруулав.

Айбекс групптэй "Түншлэлийн гэрээ" байгуулсантай холбогдуулан хийсэн хавсралт протоколд уг түншлэлийн гэрээний анхны төсөл амжилттай хэрэгжих хүртэл уг гэрээ нь төслийн хүрээнд байна гэж ойлгогдохын гадна гэрээгээр тодорхойлсон аль нэг салбарт анхны төсөл хэрэгжиж эхэлсний дараа зохих журмын дагуу батлуулахаар тусгагдсан, гэрээ албан ёсоор хүчин төгөлдөр болоогүй учир энэхүү "Түншлэлийн гэрээ"-тэй холбогдож санхүү, мөнгөний ямар ч хохирол учраагүй байна.

АНУ-ын Айбекс групптэй байгуулсан "Түншлэлийн гэрээ"-г цуцлах, хүчингүй болгох тухай протоколыг шадар сайд Ч. Пүрэвдорж, Айбекс группын зөвлөлийн дарга Х. А. Хоссейн нар 1995 оны 3 дугаар сарын 14-нд хийж нотолсон байна. Ийнхүү "Түншлэлийн гэрээ"-нээс ямарваа үр дагавар цаашид гарахгүй нь тодорхой боллоо гэж тэмдэглэсэн байна.

Түншлэлийн гэрээний тухай Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо 1995 оны 3 дугаар сарын 8 болон 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хоёр удаа хэлэлцээд олонхийн саналаар уг асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэцүүлэхээр шийдвэрлэж дүгнэлт санал гаргажээ. Тухайн дүгнэлтэд "түншлэлийн гэрээг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1985 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 95 дугаар зарлигаар батлагдсан "БНМАУ-ын олон улсын

гэрээ байгуулах, биелүүлэх, цушлах журмын тухай" хуулийн 3 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 10 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 25 дугаар зүйл, 26 дугаар зүйлийг баримтлалгүйгээр байгуулжээ.

Тухайлбал: Хуулийн дээрх зүйл, хэсгээр бас гэрээг байгуулах саналыг Засгийн газарт Гадаад харилцааны яам тогтоосон журмын дагуу өргөн мэдүүлэх, Засгийн газраас гэрээ хэлэлцээ хийх, гарын үсэг зурах тухай шийдвэр гаргах, гэрээ хэлэлцээ хийх, гарын үсэг зурах бүрэн эрхийг Засгийн газар, Гадаад харилцааны яамнаас авах, гэрээг монгол хэлээр үйлдэх, гэрээг холбогдох байгууллагаар батлуулах, Засгийн газрын тусгай хэвтэлд нийтлэх, зохих байгууллагад бүртгүүлэх ёстой байтал энэ бүхэн зөрчигджээ.

Энэ гэрээг улс ёсчлон байгуулсан бөгөөд түүний хуулийн хүчин төгөлдөр дагаж мөрдөх үүрэг гэсэн заалтуудыг тусгасан нь Монгол улсын төрийн эрх барих хууль тогтоох дээд байгууллагын бүрэн эрхийг хөндөж хязгаарласан, гэрээ байгуулагч өөрийн эрх мэдлээ хэтрүүлсэн үйл ажиллагаа болжээ" гэж дурдсан байна.

Ерөнхий сайд П. Жасрай Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын танилцуулгын агуулгыг гишүүдэд дэлгэрэнгүй танилцуулаад энэ түншлэлийн гэрээ зохих журмын дагуу хийгдэж батлагдаагүй учир Монгол Улсын олон улсын гэрээ болохгүй" гэж хэлсэн байна.

Улсын Их Хурлын хуралдаан дээр уг Түншлэлийн гэрээг хэлэлцэх үед гишүүд өөр өөр санал дүгнэлт гаргасан байна.

Улсын Их Хурлын гишүүн С. Зориг "Монгол Улсад шууд ба шууд бусаар хохирол учруулсан гэдэг нь тодорхой. Дэмий сан оруулсан шуугиан үүсгэсэн гэж байгаа бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд мөн дүгнэлт гаргасан бүх шинжээч нарт арга хэмжээ авах хэрэгтэй. Зөвлөмж гаргасан Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дарга гурвуулаа шал дэмий шуугиан тарьсан гэдэг нэрийн дор арга хэмжээ авагдах ёстой. Иймэрхүү маягаар яваад байх юм бол ямар ч хариуцлагагүй төр, хариуцлагагүй Засгийн газар, Засгийн газраа хянаж чадаагүй Улсын Их Хурал гарч ирж байна.

Ерөнхий сайд анхнаасаа мэдэж байсан, тийм буруу гэж байсан юм бол хоёр жил юу хийж явсан юм, яагаад гэнэт цуцлах болов. Энэ бүх зүйлүүдэд хариу өгөх хэрэгтэй. Иймд тодорхой хүмүүст арга хэмжээ авах хэрэгтэй.

Улсын Их Хурлын гишүүн М. Зэнээ "Энэ бол гэрээ гэсэн нэртэй протокол л байна. Хэн ч үзсэн үүнийг ингэж ойлгоно. Өнөөдөр ард түмэнд үнэнийг хэлэх цаг болсон. Энэ протоколыг гэрээ болгохын тулд манай нөхдүүд их хүчин зүтгэж байх шиг байна. Пүрэвдоржийн

хувьд энэ хүн хариуцлага алджээ. Улсын Их Хурал энэ талаар шийд гаргах нь зүйтэй" гэжээ.

Улсын Их Хурлын гишүүн Р. Гончигдорж "Гэрээг харсан хэн ч энд ямар нэгэн тайлбар, нэмэлт, протокол байгаа тухай иштлэл болохгүй учраас энэ гэрээг хэн ч хаана ч бариад явсан үнэхээр хүчин төгөлдөр байгуулчихсан, гарын үсэг зурагдсан ийм гэрээ хэн ч итгүүлж чадахаар тийм баримт бичиг байгаа юм. Ерөнхий сайд Улсын Их Хурлын өмнө энэ асуудлаар хариуцлага хүлээх ёстой" гэжээ.

Улсын Их Хурлын гишүүн С. Төмөр "Тусгайлан бүрэн эрх олгохгүйгээр гэрээ, хэлэлцээр байгуулах хүн гэвэл Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Сайд нарын Зөвлөлийн дарга, Гадаад явдлын яамны сайд энэ гурав байгаа. Иймд шадар сайд түүнд тусгайлан эрх олгоогүй байхад шууд гарын үсэг зурах эрх байхгүй.

Шадар сайд Ч. Пүрэвдорж Засгийн газрыг төлөөлж гарын үсэг зурсан бол Засгийн газраар заавал хэлэлцүүлж байж тусгай эрх олж байж гарын үсэг зурах ёстой байсан. Энд хүчингүй болгох тухай асуудал байхгүй, томьёоллын хувьд буруу байж болно. Хамгийн гол нь энд бол төслөөсөө татгалзах тухай асуудал байхгүй юу, гол юм энд байх ёстой" гэжээ.

Ерөнхийлөгч П. Очирбат "Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр гэрээ мөн гэж үзсэн юм. Ингэхдээ Монгол Улс 1988 онд нэгдсэн 1969 оны конвенцийн 3-ын "а"-гийн заалтыг үндэслэсэн юм. Тэр гэрээ, протокол хоёр бол цаг хугацааны хувьд хоёр өөр юм. Хэрэв хоёр тусдаа хийгдсэн баримт бичиг нэг асуудалд хамаарч байгаа бол аль нэгэн дээр нь хоёр дахь нь энэхүү гэрээний гэдэг юмуу, протоколын гэдэг юмуу шилшгүй хэсэг гэж бичдэг юм. Тэгэхээр аль ч учир нь тэгж байхгүй. Тийм учраас энэ хоёр чинь хоёр өөр баримт байхгүй юу. Энэ гэрээ юм бол Монгол Улсын хуулийн юу юу нь зөрчигдсөнийг Улсын Их Хурал хэлж өгөх ёстой.

Тэгэхээр гэрээ бол гэрээ болоод байгаа юм. Гэрээнд бол гарцаагүй бушуухан түүнийг цуцалж авсан явдал амжилт гэж үзэх ёстой."

Улсын Их Хурал Засгийн газрын танилцуулгыг хэлэлцээд

а/ "Монгол Улсын олон улсын гэрээний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд гарч байгаа доголдол, дутагдалд дүгнэлт хийж, түүнийг арилгах, олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах, хэрэгжүүлэхэд тавих хяналт, шаардлагыг бүх шатанд сайжруулах, энэ талаар Засгийн газрын гишүүд, холбогдох удирдах ажилтан, албан тушаалтны үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, алдаа дутагдал гаргасан хүмүүст хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж байх,

б/ гадаадын хөрөнгө оруулахтай холбогдсон гэрээ, хэлцлүүд Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын ашиг сонирхолд хэрхэн нийцэж байгааг хянан үзэж, энэ онд багтаан Улсын Их Хуралд

мэдээлэхийг Засгийн газарт даалгасан заалт бүхий 64 дүгээр тогтоол гаргажээ. Засгийн газраас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч Үндэсний хөгжлийн газрын дарга Улаан, Хууль зүйн дэд сайд Сутар нар Үндсэн хуулийн цэцэд өгсөн тайлбартаа "Дээрх иргэдийн өргөдөлд "Түншлэлийн гэрээ" гэгч нь Монгол Улсын олон улсын гэрээ мөн тохиолдолд л Үндсэн хуулийн цэцээр хянагдан шийдвэрлэгдэх нь зүйн хэрэг юм.

Түншлэлийн гэрээ байгуулагдах үед үйлчилж байсан "БНМАУ-ын Олон улсын гэрээ байгуулах, биелүүлэх, цуцлах журмын тухай хууль"-д БНМАУ-ын Олон улсын гэрээнд талаад улс, олон улсын байгууллагатай тусгайлан олгогдсон гэрээ хэлэлцээр хийх, гарын үсэг зурах бүрэн эрхийн дагуу байгуулна гэж заасан бөгөөд хуулийн 9 дүгээр зүйлд төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн болон Гадаад явдлын яамны сайд нь тусгайлан бүрэн эрх авахгүйгээр олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрхтэй тухай шууд заасан байна.

Өргөдөлд дурдсан Түншлэлийн гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхийг шадар сайд Пүрэвдоржид аль ч байгууллага олгоогүй, ер нь энэ "гэрээ"-ний талаар Засгийн газар, Ерөнхий сайд ямар нэгэн шийдвэр гаргаагүй болно. Гэрээнд гарын үсэг зурсан хоёр дахь этгээд олон улсын гэрээний эрх зүйн харилцааны субъект биш юм.

Манай улсаас АНУ-д суугаа Элчин сайдын яамнаас судалгаа хийж 1993 оны 4 дүгээр сарын 5-нд ирүүлсэн албан бичигтээ "Айбекс" групп нь Ерөнхий худалдаа эрхэлдэг хувийн компани юм. Бүртгэлийн дугаар нь DUNS 62 212 8890 гэж тодорхойлжээ. Энэ групп нь худалдааны эрх зүйн харилцааны жирийн субъект бөгөөд өөрөөр хэлбэл түүний үйл ажиллагааны төлөө ямар ч улсын Засгийн газар, ямар ч олон улсын байгууллага хариуцлага хүлээхгүй нь тодорхой байна.

Манай улс 1988 онд нэгдэн орсон "Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцийн хоёрдугаар зүйлийн 1-ийн "а"-д гэрээ гэж олон улсын эрх зүйгээр зохицуулагдан, улсуудын хооронд бичгээр байгуулсан олон улсын хэлэлцээрийг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Олон улсын гэрээний субъект нь юуны өмнө улс байна гэдэг нь дэлхий нийтэд нэгэнт тодорхой болсон зүйл юм. Мөн конвенцийн 7 дугаар зүйлд "... гэрээг заавал биелүүлэх улс гүрний зөвшөөрлийг илэрхийлэх зорилгоор тухайн этгээд холбогдох бүрэн эрхийн үнэмлэхээ үзүүлэх", наймдугаар зүйлд "улсаа төлөөлж гэрээ байгуулахтай холбогдсон үйлдэл хийх эрхтэй гэдэг нь 7 дугаар зүйлийн үндсэн дээр тогтоогдоогүй этгээд ийм үйлдэл хийсэн бөгөөд уг үйлдлийг дараа нь тухайн улс нотлохгүй бол хуулийн ач холбогдолгүйд тооцно" гэж заасан байна.

Энэ бүгдээс дүгнэлт хийхэд "Түншлэлийн гэрээ" гэгч нь хууль тогтоомжид заасан журмаар байгуулагдсан олон улсын гэрээ биш бөгөөд "Түншлэлийн гэрээ" нь Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-д заасан, ёслол байгуулагдсан олон улсын гэрээ биш, нөгөө талаас "Түншлэлийн гэрээ"-г байгуулахад Ерөнхий сайд оролцоогүй. Засгийн газраас ямар нэг шийдвэр гаргаагүй зэрэг нь Ерөнхий сайд П. Жасрайг огцруулах хуульд заасан үндэслэл алга байгааг нотолж байна" гэжээ.

Ерөнхий сайд П. Жасрай энэ Түншлэлийн гэрээний талаар Үндсэн хуулийн цэцэд өгсөн тодорхойлолтдоо "Ч. Пүрэвдорж 1993 оны эхээр АНУ явахынхда өмнө Монголд гадаадын компаниудын хөрөнгө оруулахад зуучлах компани, пүүс, хүн эрж сурвалжилж байгаа тухайгаа ярьсан. Бололцоо олдолт тэр хүнгэйгээ уулзаж магадгүй гэж хэлж байсан. Би хоёр зүйлд анхаарахыг сануулж байсан. Нэгд зуучлагч, санаачилга гаргаж байгаа хүнээ сайн судлах, хоёрт урьд өмнө манайхыг санаачилга гаргаагүйд итгэж, алдаж байсан тохиолдол байсныг анхаарах, ингэхдээ ерөнхий зүйл ярих хэрэггүй.

Зөвхөн тодорхой төсөл хэрэгжүүлэхэд зуучлуулахыг ярихыг бодоорой гэж зөвлөсөн юм. Пүрэвдорж гэрээ байгуулах гэж ердөө яриагүй. Тэнд очоод л шууд англи дээр зурсан байдаг юм. Энэ үйлдлийг яриа хэлэлцээ хийх бичиг, баримт боловсруулах горим журмыг зөрчсөн алдаа гэж үзэж байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Засгийн газраас танилцуулга шаардсан. Тэгэхэд манайд ямар ч материал байгаагүй тул Пүрэвдоржоос материал авч өгсөн. Энэ асуудлыг Засгийн газарт огт яриагүй байсан учир танилцуулгын тухай яриа байгаагүй. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл бэлтгэл дутуу хэлэлцсэн тал байгаа юм. Энэ бол Монгол Улсын олон улсын гэрээ биш юм.

Засгийн газар шийдвэрлэх аливаа асуудлыг асуудал боловсруулах журмын дагуу хуралдаанаараа хэлэлцэж шийдвэрлэдэг. Харин гаргасан шийдвэрийн тогтоол, захирамжийн хэлбэрээр илэрхийлдэг. Олонхийн саналар шийдсэн асуудлын биелэлтийг Засгийн газрын төлөрхөй гишүүн биеллэн хариуцна. Гаргасан шийдвэрийнхээ талаар Засгийн газар хамтын хариуцлага хүлээнэ. Засгийн газрын тодорхой гишүүд өөрийн үйл ажиллагааны хүрээнд судлах, боловсруулах асуудлыг бие даан хариуцаж шаардлага хангагдлаа гэж үзсэн үедээ Засгийн газарт оруулна. Энэ шат хүртэлх Засгийн газрын тодорхой гишүүд бие даан ажиллах үедээ алдах, онохын аль нь ч байсан Засгийн газрын болон Ерөнхий сайдын хариуцлагын асуудал биш юм" гэжээ.

Шадар сайд Пүрэвдорж Үндсэн хуулийн цэцэд өгсөн тодорхойлолтдоо "Ийм бичиг баримт боловсруулж гэрээ байгуулахдаа шил-

жолтийн үед дан ганц Засгийн газруудын шутамаар орж ирж байсан. Зээл тусламж хүрэлцээтэй бус байсныг харгалзсан юм. Улс орноо эдийн засгийн хүнд байдлаас гаргах бололцоотой бүх арга замыг эрэлхийлж байсантай холбоотой юм. Түншлэлийн гэрээг байгуулахыг НҮБ-ын төслийн зөвлөх Аагс Холм гэдэг АНУ-ын иргэн зөвтөсөн.

1993 оны 4 дүгээр сарын 5-нд АНУ-д суугаа элчин сайдын яамнаас явуулсан судалгаагаар Айбекс групп нь Нью-Жерси хотын Форт Лес гудамжны 07024 гэсэн хаягтай 2016803838 дугаартай утастай ерөнхий худалдаа эрхэлдэг хувийн компани бөгөөд бүртгэлийн дугаар нь "DUNS" 62-2128890. Ерөнхий захирал нь Ахмед Хоссейн 1991 оноос үйл ажиллагаагаа явуулж байгаа хүн юм.

Миний бие энэ бичиг баримтыг хэлцэл, протоколыг урьдчилсан бичиг баримт гэж ойлгож байсан. Тодорхой төсөл хэрэгжүүлэх бэлтгэл шатанд нөгөө талын хэн болохыг таних боломж бүрдэнэ гэж найдаж байсан энэ бичиг баримтыг төсөл, урьдчилсан бичиг баримт гэж ойлгож байсан учраас тийм ач холбогдол өгч гарын үсгээ зурсан.

"Түншлэлийн гэрээ" гэгчийг УАБЗ-ийн зөвлөлийн заалтыг хэрэгжүүлэх үндсэн дээр хүчингүй болгосон юм. Энэ баримт бичиг төсөл учир Ерөнхий сайдыг огцруулах үндэслэл болохгүй юм" гэжээ.

Үндсэн хуулийн цэц Түншлэлийн гэрээ нь хэлбэр, агуулгын хувьд Монгол Улсын олон улсын гэрээ мөн эсэхийг тодруулах зорилгоор Олон улсын Монгол судлалын холбооны нарийн бичгийн дарга нарын зөвлөх, хууль зүйн ухааны дэд доктор Л. Хашбат, Олон улсын эрх зүйн мэргэжилтэн М. Дүгэрсүрэн, Гадаад харилцааны яамны гэрээ, эрх түүх архивын хэлтсийн ажилтан Б. Жамбалдорж нарын бүрэлдэхүүнтэй мэргэжлийн шинжээчийн хэсгийг томилон ажиллуулж дүгнэлт гаргуулсан юм.

Шинжээч нар олон улсын эрх зүйн хэм хэмжээ, Монгол Улсын хууль тогтоомж, бусад нотлох баримтыг шинжилж судлах замаар түншлэлийн гэрээ нь Монгол Улсын олон улсын гэрээ биш гэж үзэх үндэстэй гэсэн дүгнэлтийг санал нэгтэй гаргаж Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн байна.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч Сугар цэцийн хуралдаан дээр "Энэ гэрээний нэг субъект "Айбекс" гэдэг хувийн компани байгаа юм. Олон улсын гэрээний субъект бол улсууд, олон улсын байгууллага байдаг. Энэ утгаар Түншлэлийн гэрээ цэцээр хянагдах монгол улсын олон улсын гэрээ биш юм. Энэ гэрээний талаар Монгол улс, Засгийн газар ямар нэг хариуцлага хүлээхгүй. Энэ гэрээ нь олон улсын гэрээ биш учир П. Жасрайт үүнтэй холбогдуулан огцруулах үндэслэл байхгүй юм" гэжээ.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч Пүрэвдорж цэцийн хуралдаан дээр "Би энэ бичиг баримтыг боловсруулж Айбекс групптэй гэрээ байгуулахдаа шилжилтийн үед дан ганц Засгийн газруудын шугамаар орж ирж байсан зээл тусламж хүрэлцээтэй бус байсан, мөн улс орноо эдийн засгийн хүнд байдлаас гаргах бололцоотой бүх арга замыг эрэлхийлэх бодит шаардлагыг үндэслэсэн юм.

Энэ бичиг баримтыг урьдчилсан бичиг баримт гэж ойлгож, тодорхой төсөл хэрэгжүүлэх бэлтгэл шатанд нөгөө талын хэн болохыг таних боломж бий болно гэдэгт найдаж, ойлгож байсан учраас тийм ач холбогдол өгч гарын үсгээ зурсан. Түншлэлийн гэрээ гэгчийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн заалтыг хэрэгжүүлэх үндсэн дээр цуцалсан юм. Энэ бол гэрээ бус төсөл учир Ерөнхий сайд П. Жасрайг огцруулах шалтгаан болохгүй гэжээ.

Өргөдөл гаргасан иргэн Д. Ламжав, С. Зориг, А. Ганбаатар нар цэцийн хуралдаан дээр бичгээр 12 хуудас бүхий нэмэлт тайлбар, судлагдах материалын жагсаалт гаргаж өгсөн.

Д. Ламжав, С. Зориг нар цэцийн хуралдаан дээр "Маргааны объект бол Монгол Улс болон монголын Засгийн газрыг төлөөлөн шадар сайд Ч. Пүрэвдорж, Айбекс группыг төлөөлөн Ахмед Хоссейн нар хүлээн зөвшөөрч 1993 оны 4 дүгээр сарын 17-нд гарын үсэг зурсан Түншлэлийн гэрээ бөгөөд, энэ баримт бичиг болон түүнтэй холбогдсон асуудлуудад Ерөнхий сайд П. Жасрай үндсэн хуулиар оногдсон үүргээ хөсөрдүүлж хөндсөөр ирсэн баримт нь түүнийг огцруулах үндэслэл болж байна хэмээн бид үзэж байгаа юм.

Анхнаасаа зөвхөн англи хэл дээр үйлдсэн энэхүү баримт бичгийг бид Түншлэлийн гэрээ гэж нэрлэж байгаа бөгөөд энэ нь чухам юу гэсэн нэртэй байх, хүчин төгөлдөр эсэх, олон улсын гэрээ мөн эсэх зэргээс бидний өргөдөл дэх нэхэмжлэл хамаарахгүй юм шүү, өөрөөр хэлбэл аль ч тохиолдолд Үндсэн хуулийн дурдсан заалтууд ёсоор бидний нэхэмжлэлийг цэц хянан шийдвэрлэх хууль зүйн үндэслэл байгаа юм.

Энэ түншлэлийн гэрээ нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн бөгөөд энэхүү зөрчсөн байдал нь түүнийг хэрэгжүүлэхэд Монгол улс оролцох боломжгүй байгаа нь ноцтой юм. Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжид Түншлэлийн гэрээг гэрээ мөн гэж үзсэн.

Улсын Их Хурлын 64 дүгээр тогтоолын 2 дахь заалт бол Айбекс групптэй байгуулсан гэрээнүүдэд байтугай Жасрайн Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд байгуулагдсан Засгийн газарт хамаарах аливаа гэрээ, хэлэлцээрт хамаарахгүй болох нь Засгийн газрын танилцуулга, Байнгын хорооны дүгнэлт, Улсын Их Хурлын хуралдааны тэмдэглэлээс тодорхой байна. Ийнхүү 64 дүгээр тогтоол нь хэлэлцсэн асуудлынхаа талаар мөн чанартаа юу ч хэлээгүй, ингэснээр

Улсын Их Хурал, Засгийн газрын хариуцлагатай байдалтай эвлэрсэн юм.

Өргөдөлд бичсэн Монгол Улсын Үндсэн хуулийн заалтуудыг ноцтой зөрчсөн Түншлэлийн гэрээнд Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс гарин өгөм зурагдал болон нэхүү хууль зөрчсөн үйл ажиллагааг хууль бус аргаар хамгаалж, ийн тэдгэрийн үйл ажиллагааг үргэлжлүүлдэг байгаа Ерөнхий сайд П. Жарсай нь энэ бүх үйлдлээрээ Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэсэн заалтыг, 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна, 2 дахь хэсгийн Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана гэсэн заалтуудыг тус тус ноцтой зөрчсөн тул Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасны дагуу Ерөнхий сайд П. Жарсайг огцруулах үндэслэл хангалттай байна" гэсэн нэмэлт тайлбар гаргажээ.

Хянавал:

1. Монгол Улсын Засгийн газрын нэрийг өмнөөс шадар сайд Ч. Пүрэвдорж АНУ-ын Айбекс групптай байгуулсан түншлэлийн гэрээнд "нэхүү гэрээ байгуулсан өдрөөс хойш 99 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. Айбекст хамаарах төслүүдэд олгосон болон энэ гэрээнд тусгасан бүх нөхцөл, эрх, ашгийг Монгол улс, Монголын Засгийн газар батлан хангаж гэрээний хугацаанд тэдгээрийг Засгийн газрын тухайн үеийн болон цаашдын үйл ажиллагаагаар, түүнчлэн аливаа хууль тогтоомжоор өөрчилж, засаж буцаахгүй, монголын хувьд хуулийн хүчин төгөлдөр дагаж мөрдөх үүрэг гэсэн монголын хууль тогтоомжид нийцэхгүй заалт орсон, түүнчлэн гэрээ байгуулагч гадаадын хөрөнгө оруулж улс орны тухайн үеийн хүндэрлэтэй байдлыг богино хугацаанд гэтлэх гэсэн эрмэлзэлдээ хотлогдон гэрээг хэт яарч газар дээр нь шууд байгуулсан, уг гэрээг хуульд нийцүүлэх талаарх асуудлыг нарийвчлан авч үзэхгүй, ийм гэрээ байгуулсан тухайгаа Засгийн газар, холбогдох байгууллагуудад шуурхай мэдээлээгүй зэрэг нь гадаадын компани, корпорацийг Монгол Улсын эдийн засгийн стратегийн ач холбогдолтой салбарт дангаараа удаан хугацаагаар ноёрхох, Монгол Улсын хууль тогтоомжуудыг зөрчиж, үндэсний аюулгүй байдалд ноцтой хор хохирол учруулахад хүргэж болзошгүй үйл ажиллагаа байжээ.

2. Олон улсын гэрээний эрх зүйн тухай 1969 оны Венийн конвенцид /Монгол улс 1988 онд нэгдэн орсон/ зааснаар олон улсын гэрээ гэж "нэг бузуу хоёр, эсхүл өөр хоорондоо холбоотой хэд хэдэн баримт бичигт агуулагдаж байгаа бөгөөд түүний тодорхой

нэрээ хамаарахгүйгээр улсуудын хооронд бичгээр байгуулсан, олон улсын эрх зүйгээр зохицуулагдаж байгаа олон улсын хэлэлцээрийг хэлнэ". Мөн түүнчлэн БНМАУ-ын Олон улсын гэрээ байгуулах, биелүүлэх, цуцлах журмын тухай 1985 оны хуулийн 2 дугаар зүйлд "БНМАУ-ын олон улсын гэрээг гадаад улс, олон улсын байгууллагатай БНМАУ, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Засгийн газар, яам, улсын хороо, тусгай газрын нэрийн өмнөөс тус тус байгуулна" гэж ямар субъектуудын хооронд байгуулагдах ёстойг заажээ.

Монгол Улсын олон улсын гэрээний тухай 1993 оны шинэ хуульд дээрх тодорхойлолтын үндсийг хадгалж, агуулгыг шинэ Үндсэн хуульд нийцүүлж "Олон улсын гэрээ гэж Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ" гэж тодорхойлсон байна.

Дээр дурдсан олон улсын эрх зүйн тулгуур баримт бичиг, Монгол Улсын хууль тогтоомжийн заалтаас үзэхэд Айбекс групптэй байгуулсан Түншлэлийн гэрээг Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-д заасан Үндсэн хуулийн цэцээр авч хэлэлцвэл зохих Монгол Улсын олон улсын гэрээ гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна. Энэ нь шинжээч нарын дүгнэлтээр давхар нотлогдож байна.

3. Түншлэлийн гэрээг байгуулах болон түүнээс хойшхи үйл ажиллагаанд Ерөнхий сайд П. Жасрай шууд оролцож байсан нь нотлогдохгүй байгаа тул П. Жасрайг Ерөнхий сайдын албан тушаалаас огцруулах талаар маргагч талын тавьж буй гомдлын шаардлагыг хангах үндэслэлгүй байна.

Дүгнэлт:

1. АНУ дахь Айбекс групптэй байгуулсан Түншлэлийн гэрээ нь Монгол Улсын олон улсын гэрээ биш болох нь тэр үед болон одоо үйлчилж байгаа хууль тогтоомж, шинжээч нарын дүгнэлт, маргалдагч талуудын хүлээн зөвшөөрсөн байдал болон бусад нотлох баримтаар тогтоогдож байгаа тул уг гэрээ нь Үндсэн хуулийн цэцэд харьяалагдах маргаан биш байна. Иймд иргэн Д. Ламжав, С. Зориг, А. Ганбаатар нарын өргөмдөдөө бичсэн "Түншлэлийн гэрээ" Монгол Улсын Үндсэн хуулийн заалтуудыг зөрчсөн эсэх гэсэн хүсэлтийг хэрэгсэхгүй болгосутай.

2. Айбекс групптэй байгуулсан Түншлэлийн гэрээтэй холбогдох

Ерөнхий сайд П. Жасрайгийн үйл ажиллагаа Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх нь нотлогдохгүй байгаа тул П. Жасрайг энэ шалтгаанаар Ерөнхий сайдын албан тушаалаас огцруулах үндэслэл болохгүй байна.

3. Энэ дүгнэлтийг Монгол Улсын Их Хуралд оруулсугай.

Хураалдын даргалагч
Гиншүүд

Г. СОВД
Ц. ЦОЛМОН
Н. ЖАНЦАН
С. ЖАНЦАН
Д. ЧИЛХААЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 101

Улаанбаатар
хот

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай
хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим
арга хэмжээний тухай

"Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай" Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Холбогдох нам, газартай хамтран хэмжлийн нэгжийн эталон бий болгох, хэмжих хэрэгслийн загварын туршилтын болон баталгаажуулалт хийх лабораториудыг бэхжүүлэх чиглэлээр дараахь төсөл боловсруулж, түүнийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд тусгуулан, гадаадын эзэл тусламжтай улсуудан ээлж дараатай хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Үндэсний хөгжлийн газар /Ч. УЛААН/-г даалгасугай.

а/ ургын хэмжлийн нэгж метрийн эталоныг бий болгох;

б/ цахилгаан, дулаан, физик-химийн шинж чанар, нягт, зунгааралт, хөдөлгөөний параметр, ионжуулагч, цацрагийн хэмжлийн лабораториудыг ажлын эталонуур шинэчлэн тонсглох;

в/ эм, био бадмэслийн биологийн идэвхийн хэмжлийн нэгжийн эталон, нягтийн эталон, өсгөврийн сан бий болгох;

г/ аймгийн стандартчиллэл, хэмжил зүйн төвүүдийн эхлэхүүн, зарцуулалт, цул, цахилгаан, дулааны хэмжлийн лабораториудыг шалгалтын тоног төхөөрөмж, эталонуур тоноглох.

2. Хүнсний зах, худалдааны цэгүүдэд иргэдийн ашиглаж байгаа ахуйн зориулалтын жингүүдийг солих зорилгоор эрчим хүчний засварын үйлдвэрт хийж байгаа тэнгүүрт гэр жингийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж гэрээний дагуу хангах арга хэмжээг 1995 оны III улиралд багтаан авахыг Эрчим хүч, геологи, уул уурхайн яам /Б. ЖИГЖИД/-д даалгасутай.

3. Цулын хэмжлийн нэгжийн-"килограмм", шахилгааны хөдөлгөгч хүчний нэгж-"вольт", цаг дангамжийн хэмжлийн нэгж-"секунд"-ээр ажлын эталоны иж бүрдлийг хангах, уртын хэмжлийн нэгж-"метр"-ээр эталон бий болгох, бодис, материалын бүтэц, шинж чанарын стандартчилсан зөгвөр зохион бүтээх, эдгээрийн нарийвчлал, хэмжил зүйн бусад үзүүлэлтийг дээшлүүлэх, тогтмолжуулах судалгааны ажлыг шинжлэх ухаан-технологийн төслийн хэлбэрээр гүйцэтгэх арга хэмжээ авахыг Шинжлэх ухаан, боловсролын яам /С. ТӨМӨР-ОЧИР/, Үндэсний хөгжлийн газар /Ч. УЛААН/-т даалгасутай.

4. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу зохиох байгууллагаас эрх авсны үндсэн дээр Монгол Улсын Зэвсэгт хүчин, бусад цэргийн хэмжээнд хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, хэмжил зүйн төвийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Батлан хамгаалах яам /Ш. ЖАДАМБАА/-д даалгасутай.

5. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах техникийн үндсийг бүрлүүдэхэд шаардагдах хэмжих хэрэгслээр хангах, тэдгээрийг баталгаажуулалтад хамруулах нэгдсэн бодлогыг эрхэлсэн ажлын хүрээ, үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу боловсруулж Засгийн газрын хөтөлбөр, төслүүдэд тусгаж байх арга хэмжээ авахыг сайд, тусгай газрын дарга, нийслэл, аймгийн Засаг дарга нарт даалгасутай.

6. Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад дор дурдсан журмыг мөрдүүлэх нь зүйтэй гэж үзсүтэй:

а/ аливаа хэрэглэгчтэй материал баялаг, эрдэс, түүхий эд, бүтээгдэхүүн /уур, ус, шахилгаан, дулааны эрчим хүч, шатахуун, тосолгооны материал, нүүрс, үр тариа, гурил, будаа, мах, сүү, алт, мөнгө, хэсний баяжмал, ноос, ноолуур гэх мэт/-ий тооцоог зөвхөн баталгатай хэмжих хэрэгслээр хийж байх;

б/ хэмжил зүйн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааны хүрээнд хамаарах шинэ загвар, хийнийн хэмжих хэрэгслийг импортоор бөөнөөр оруулахдаа шалгаж баталгаажуулах эталон, шалгалтын тоног төхөөрөмжийн нь хамт нийлүүлд байх.

Монгол Улсын Ерөнхий сайд
Монгол Улсын сайд бөгөөд
Үндэсний хөгжлийн газрын дарга

П. ЖАСРАЙ
Ч. УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 102

Улаанбаатар
хот

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн 15 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт болон Хэмжлийн нэгдмэл байдлын хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3, 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтын ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Монгол Улсын сайд бөгөөд
Үндэсний хөгжлийн газрын дарга

П. ЖАСРАЙ
Ч. УЛААН

Засгийн газрын 1995 оны 102
дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|-----------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Зөвлөлийн дарга | -Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн ерөнхий захирал |
| Орлогч дарга | -Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн дэд захирал |
| Гишүүд: | -Эрүүд мэндийн яамны хүн хүч, анагаах ухааны бодлогын хэлтсийн дарга
-Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны хөдөлмөрийн хяналтын албаны дарга;
-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Эдийн засаг, хамтын ажиллагааны газрын гүшмэл;
-Худалдаа, үйлдвэрийн яамны аж үйлдвэрийн тасгийн дарга;
-Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны Уул уурхайн газрын гүшмэл; |

- Үндэсний хөгжлийн газрын даргын ахлах зөвлөх;
- Шинжлэх ухааны академийн Химийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан;
- Шинжлэх ухааны академийн физик техникийн хүрээлэнгийн дэд захирал;
- Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн Стандартчилалын газрын дарга;
- мөн төвийн Хэмжил зүйн газрын дарга;
- мөн төвийн Хэмжүүр, баталгаажуулалтын газрын дарга;
- мөн төвийн Тамгын газрын дарга;
- мөн төвийн Стандарт, хэмжил зүйн хяналтын газрын дарга;
- мөн төвийн Стандартчилсан загвар, аккредитчиллын газрын дарга;
- мөн төвийн Баталгаажуулалтын газрын дарга;
- Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн (тус нийгэмлэгтэй тохиролцсоноор);
- Монголын хувийн үйлдвэрийн эздийн холбооны хариуцлагатай нарийн бичгийн дарга (тус холбоотой тохиролцсоноор);
- Монголын хэмжүүрийн нийгэмлэгийн ерөнхийлөгч (тус нийгэмлэгтэй тохиролцсоноор).

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 104

Улаанбаатар
хот

Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

"Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 61 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн 1997 онд хүрсэн байвал зохих сарын дундаж хэмжээг хавсралтын ёсоор баталж, энэ хэмжээнд тэтгэврийг хүргэж

нэмэгдүүлэх арга хэмжээг 1997 онд багтаан үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тогтоосугай.

2. Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. Гомбожав, Сангийн сайд Э. Бямбажав нарт даалгах нь:

а/ тэтгэвэр авагчдын одоогийн авч байгаа тэтгэврийг энэ тогтоолын хавсралтад заасан хэмжээнд хүргэхдээ тэтгэвэр авагчийн эрхэлж байсан ажил, нас, хөдөлмөрийн нөхцөл, ажилласан хугацааг харгалзан анх тогтоогдсон үндсэн тэтгэврийн хэмжээнээс хамааруулан нэмэгдүүлэх аргачилсан журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг тусгах үндсэн дээр 1995 оны 7 дугаар сард багтаан баталж мөрдүүлсүгэй;

б/ 1995 оны хувьд одоогийн олгож байгаа тэтгэвэр, нөхвөрийн дүнг дунджаар 20 хувиар 7 дугаар сарын 1-нээс эхлэн нэмэгдүүлэхээр тооцож, тэтгэврийн нэмэгдэх хэсгийг энэ оны 10 дугаар сард багтаан ээлж дараатай олгох арга хэмжээ авсугай;

в/ энэ зүйлийн "б" заалтыг төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төрийн албаны байгууллагад ажиллаж байгаа тэтгэвэр авагчдад хамааруулахгүй байсугай;

г/ энэ тогтоолын хавсралтаар баталсан тэтгэврийн сарын дундаж хэмжээнд хүргэж тэтгэврийг нэмэгдүүлэхэд цаашид шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, хэрэгжүүлэх хугацааны талаархи саналаа жил бүрийн улсын төсөв зохиох, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг төлөвлөхөд тооцон тусгаж Засгийн газарт оруулж байсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд
Сэнгийн сайд

Э. ГОМБОЖАВ
Э. БЯМБАЖАВ

Засгийн газрын 1995 оны 104
дүгээр тогтоолын хавсралт

1995 ОНЫ 1 ДҮТЭЭР САРЫН 1-НЭЭС ӨМНӨ ТЭТГЭВЭР
ТОГТООЛГОСОН ИРГЭДИЙН ТЭТГЭВРИЙН 1997 ОНД
ХҮРСЭН БАЙВАЛ ЗОХИХ САРЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ

Тэтгэврийн төрөл	1995 оноос өмнө мөрдөж байсан хуулийн дагуу тэтгэвэр тогтооход тооцсон сарын дундаж цалингийн хэмжээ /төгрөгөөр/	1997 онд хүрсэн байвал зохих тэтгэврийн сарын дундаж хэмжээ /төгрөгөөр/
1. Өндөр насны тэтгэвэр		
-55-аас дээш насны эмэгтэй,	600 хүртэл	7200
60-аас дээш насны эрэгтэй	601-800	8400
	801-1200	10800
	1201-1600	13200
	1601-ээс дээш	14400
-55-аас доош насны эмэгтэй,	600 хүртэл	7200
60-аас доош насны эрэгтэй	601-800	8400
	801-1200	10800
	1201-1600	13200
	1601-ээс дээш	14400
2. Төмөр дутуу болсны тэтгэвэр		
-I, II хэрэг	600 хүртэл	6600
	601-800	7700
	801-1200	9900
	1201-1600	12100
	1601-ээс дээш	13200
-III хэрэг	600 хүртэл	4800
	601-800	5600
	801-1200	7200
	1201-1600	8800
	1601-ээс дээш	9600
3. Тэжээгсээ алдсаны тэтгэвэр	600 хүртэл	5400
	601-800	6300
	801-1200	8100
	1201-1600	9900
	1601-ээс дээш	10800

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 106

Улаанбаатар
хот

Үнэт цаасны хоёр дахь зах зээл, бэлэн
мөнгөний арилжаа эхлүүлэхтэй
холбогдуулан авах зарим арга
хэмжээний тухай

Монгол Улсын Үнэт цаасны хуулийг хэрэгжүүлэх зорилгоор
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монголын хөрөнгийн биржийг Үнэт цаасны хуулинд заасан
шаардлагад нийцүүлэн энэ оны 7 дугаар сард багтаан өөрчлөн
зохион байгуулж дүрмийг нь батлуулах, төлөөлөн удирдах зөвлөл,
захирлыг нь томилуулахын хамт түүний брокерийн пүүсүүдийг зохих
бэлтгэл хангасны үндсэн дээр энэ онд багтаан хувьчлахыг Засгийн
газрын Өмч хувьчлалын комисс (Л. ЭНЭБИШ)-г даалгасугай.

2. Үнэт цаасны хоёр дахь зах зээлийг эхлүүлэх үед талбөр тооцоог
шуурхай зохицуулах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн
эх үүсвэрийг Сангийн яамтай хамтран тооцож өмч хувьчлалын сан-
гаас түр хугацаагаар олгож, зөхөн талүүлэхийг Засгийн газрын Өмч
хувьчлалын комисс (Л. ЭНЭБИШ)-г зөвшөөрсүгэй.

3. Үнэт цаасны арилжааг тасралтгүй явуулах, иргэд, харилцагч на-
рыг бэлэн мөнгөөр арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэх, ногдол
ашгийн тараалтыг шуурхай гүйцэтгэх үүднээс орон нутгийн брокер-
рийн пүүсүүдийн захиалгаар бэлэн мөнгөний гүйлгээг цаг тухайд нь
хийж байх арга хэмжээ авч ажиллахыг Монгол банк (Д. МОЛОМ-
ЖАМЦ)-д зөвлөсүгэй.

4. Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг болон бэлэн мөнгөөр
арилжаалагдсан хувьцааны үнийг банкны байгууллагаар дамжуулан
түгээх журмыг Монгол банк, Сангийн яамтай тохиролцон гаргаж
1996 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдүүлэхийг Монголын
хөрөнгийн биржийн захиралд даалгасугай.

5. Монголын хөрөнгийн биржийн барилгын засвартай холбогдсон
гадаад, дотоод талбөр тооцооны асуудлыг Монгол банктай хамтран
энэ оны 7 дугаар сард багтаан шийдвэрлэхийн хамт уг барилгыг
төрийн өмчид үлдээж, түрээсийн хэлбэрээр ашиглуулахыг Засгийн
газрын өмч хувьчлалын комисс (Л. ЭНЭБИШ), Сангийн яам
(Э. БЯМБАЖАВ)-д даалгасугай.

6. Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжааг найдвартай явуулах холбооны үйлчилгээгээр ханган, төсвийн байгууллагуудын нэгэн адил үнэ тарифаар тооцож байхыг Дэд бүтцийн хөгжлийн яам (Р. САНДАЛХАН)-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Монгол Улсын Шадар сайд

Л. ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 111

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх ерөнхий журмыг хавсралтын ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хууль зүйн сайд

Н. ЛУВСАНЖАВ

Засгийн газрын 1995 оны 111 дүгээр
тогтоолын хавсралт

ТӨРИЙН ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ТУСГАЙ ЧИГ ҮҮРЭГ БУЮУ ДЭД САЛБАРЫН ТОДОРХОЙ ЧИГ ҮҮР- ГИЙГ ЗАСГИЙН ГАЗРЫН БУС БАЙГУУЛЛАГАД ХА- РИУЦУУЛАН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн зохицуулалт, мэдээлэл, шинжлэл судлалын ээ-

рэг төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдон гарах зардлыг санхүүжүүлэхэд энэ журмыг баримтална.

2. Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг холбогдох сайдын санал болгосноор Засгийн газар гаргана.

3. Засгийн газрын бус байгууллага нь төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг гүйцэтгэхдээ хууль тогтоомж, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээг баримталж, холбогдох хууль тогт омж, Засгийн газрын шийдвэрт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4. Засгийн газрын бус байгууллагаас төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг эрхлэн гүйцэтгэхдээ холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Хоёр. Засгийн газрын бус байгууллагатай гэрээ байгуулах журам

5. Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэхтэй холбогдсон гэрээг Засгийн газрыг төлөөлж тухайн асуудлыг эрхэлсэн сайд буюу түүний эрх олгосноор төрийн захиргааны төв байгууллагын эрх бүхий албан тушаалтан байгуулна.

6. Гэрээг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд, эсхүл тохиролцсон тодорхой хугацаагаар байгуулж болох ба энэ тухай гэрээнд заасан байна.

7. Гэрээг бичгээр байгуулах ба гэрээнд үндсэн болон санхүүжүүлэх нөхцөлийг тодорхой зааж, гэрээ байгуулагч талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулна.

8. Гэрээ байгуулагч талууд нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлдээ дараахь нийтлэг эрх, үүрэгтэй байна. Үүнд:

1/Засгийн газрыг төлөөлж буй байгууллага, албан тушаалтан нь холбогдох санхүүжилтийг цаг тухайд нь олгох гэрээгээр хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газрын бус байгууллагаас тавьж буй санал хүсэлтийг шуурхай судалж, шийдвэрлэх гэрээгээр хариуцсан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд тэдний сонголт, мэдээллийг

Сайдын зөвтөл, улмаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж зохих шийдвэр гаргах;

2/ Засгийн газрын бус байгууллага нь гэрээгээр хүлээсэн үүргээ цаг тухайд нь биелүүлэх, энэ талаар Засгийн газар, түүнийг төлөөлсөн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тодорхой санал хүсэлт тавьж шийдвэрлүүлэх, шаардлагатай мэдээ баримтыг гаргуулж авах, гэрээгээр хариуцсан ажлын хүрээнд төрийн захиргааны төв, орон нутгийн холбогдох байгууллагатай шууд харилцаж ажиллах, төсвөөс олгосон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, түүний зарцуулалтын тайлан болон гэрээний үүргийн биелэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд цаг тухайд нь гаргаж өгөх.

Гурав. Санхүүжүүлэх журам

9. Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэхтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэхдээ Засгийн газрын шийдвэр, гэрээг үндэслэнэ.

10. Засгийн газар, түүнийг төлөөлсөн эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь санхүүжилтийг гэрээний нөхцөлийн дагуу хийж төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хууль тогтоомжид заасан журмын дагуу хяналт тавина.

11. Засгийн газрын бус байгууллагын дарга /захирал, ерөнхийлөгч/ нь гэрээний дагуу төсвөөс олгосон хөрөнгийн шууд захирагч байх ба холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу төсвөөс олгосон хөрөнгийг захиран зарцуулж, Төсвийн тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

12. Засгийн газар, түүнийг төлөөлсөн эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь гэрээний нөхцөлийг өөрчилсөн, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар ашигласан зэрэг үндэслэлээр санхүүжилтийг хууль тогтоомжид заасан журмын дагуу түр буюу бүрмөсөн зогсоож болно.

Дөрөв. Бусад заалт

13. Засгийн газрын бус байгууллага нь төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг хариуцан гүйцэтгэхтэй холбогдуулан төсвөөс олгосон хөрөнгийг ашиг олох зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа явуулахад ашиглахыг хориглоно.

14. Засгийн газрын бус байгууллагаас төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг бужоу дэд салбарын тодорхой чиг үүргийг хариуцан гүйцэтгэхтэй холбогдон үүссэн маргааныг Монгол Улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 8 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 143

Улаанбаатар
хот

Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Газрын тухай Монгол Улсын хууль, "Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 1994 оны 78 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Газар зохион байгуулалтын журам"-ыг 1 дүгээр хавсралтын, "Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам"-ыг 2 дугаар хавсралтын, "Газрын сангийн данс бүртгэл хөтлөх, тайлан гаргах журам"-ыг 3 дугаар хавсралтын, Газрын улсын нэгдсэн тайлангийн маягт (УТ1-УТ7)-ыг 4 дүгээр хавсралтын, "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах журам"-ыг 5 дугаар хавсралтын, "Аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зориулан эзэмшүүлэх газрын дээд хэмжээ"-г 6 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Газрын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг 1995 оны 9 дүгээр сард багтаан авахыг Байгаль орчны яам (З. БАТЖАРГАЛ)-д даалгасугай:

а/ сум, дүүргийн газрын сангийн данс бүртгэлийн болон газрын нэгдсэн тайлангийн маягт, аймаг, нийслэлийн газрын нэгдсэн тайлангийн маягтуудыг Статистикийн төв газартай хамтран баталж мөрдүүлэх;

б/ иргэн аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших, ашиглах гэрчилгээ, газар эзэмшүүлэх, ашиглуулахаар тэдгээртэй байгуулах гэрээний загварыг батлан гаргах.

3. Орон нутаг дахь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шаардагдах тоон мэдээлэл, байр зүйн зургаар шуурхай үйлчлэх, зардал хэмнэх

зорилгоор аймаг, сумын газрын асуудал хариуцсан албан тушаалтныг геодези-зураг зүйн байцаагчийн үүрэгтэйгээр ажиллуулж тэдэнд бүх масштабын байр зүйн зургийн хадгалалт, хамгаалалт болон тэдгээр зургийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нууцлалын зэргэлтээр ашиглуулах асуудлыг хариуцуулах арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд З. Батжаргал, Дэд бүтцийн хөгжлийн сайд Р. Сандагхан нарт даалгасугай.

4. Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрхлэн зохион байгуулах, энэ талаархи үйл ажиллагааг зохицуулах, газрын харилцаа, менежментийг өндөр түвшинд гүйцэтгэх үүрэг бүхий газрын алба байгуулах, ажилтнуудыг томилох асуудлыг тэдгээрийн гүйцэтгэх ажлын чиглэл, нутаг дэвсгэр, үйлдвэрлэл үйлчилгээний онцлогийг харгалзан шийдвэрлэхийг Монгол Улсын Шадар сайд Л. Энэбиш, Байгаль орчны сайд З. Батжаргал, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц. Өөлд, холбогдох яам, газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Газрын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийж, дүгнэлт гаргах ажлыг хариуцах мэргэжлийн байгууллагын жагсаалт гаргаж тэдгээрийн ажиллах журмыг баталж мөрдүүлэхийг Байгаль орчны яам (З. БАТЖАРГАЛ), Хүнс, хөдөө аж ахуйн яам (Ц. ӨӨЛД), Шинжлэх ухаан, боловсролын яам (С. ТӨМӨРӨЧИР)-д даалгасугай.

6. Газрын менежментийн чиглэлээр Хөдөө аж ахуйн үндэсний их сургууль болон бусад сургуульд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажлыг 1995-1996 оны хичээлийн жилээс эхлэн зохион байгуулахыг Шинжлэх ухаан, боловсролын сайд С. Төмөр-очир, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц. Өөлд нарт даалгасугай.

7. Улсын хөрөнгө, захиалгаар хийгдсэн 1:100000-тай газрын зураг 10 хувийг аймаг, сумдын газар зохион байгуулалтын ажилд зориулан үнэ төлбөргүйгээр Байгаль орчны яаманд шилжүүлэхийг Дэд бүтцийн хөгжлийн яам (Р. САНДАГХАН)-д даалгасугай.

8. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц. Өөлдөд даалгах нь:

а/ Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрийн газрыг гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллагад бэлчээр, хадлангийн зориулалтаар түр хугацаагаар ашиглуулах асуудлыг хил зэргэлдээ улс, мужуудтай байгуулсан протокол, тухайн жилийн зуншлагын байдал, холбогдох аймаг, сумдын саналыг үндэслэн жил тутам зохицуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласугай;

б/ хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг ашиглах, эзэмших журмыг Байгаль орчны яамтай хамтран боловсруулж энэ онд багтаан батлан гаргасугай.

9. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх зэрэгт шаардагдах зардлыг жил бүрийн төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг Байгаль орчны яам (З. БАТЖАРГАЛ), Сангийн яам (Э. БЯМБАЖАВ), аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

10. Газар эзэмших, ашиглах гэрчилгээ, гэрээ, газрын сангийн данс бүртгэлийн маягт хэвлүүлэх, газар зохион байгуулагчдын мэргэшил дээшлүүлэх курс зохион байгуулах зэрэгт шаардагдах зардлыг 1996 оны төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн яам (Э. БЯМБАЖАВ), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

11. Байгаль орчны яам (З. БАТЖАРГАЛ), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулахад шаардагдах бичиг баримт, маягтыг хэвлүүлэх, энэ арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон бэлтгэлийг 1996 оны 1 дүгээр сард багтаан хангасугай;

б/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдэлд байгаа газрыг зохих хууль тогтоомжийн дагуу тэдгээрт эзэмшүүлэх, ашиглуулах тухай асуудлыг 1996 онд багтаан шийдвэрлэж гэрээ байгуулан гэрчилгээжүүлэх, түүнчлэн шинээр газар эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг улс, орон нутгийн хөгжлийн хэтийн төлөв, чиглэл, зорилттой уялдуулан зохион байгуулах арга хэмжээ авсугай;

в/ газрын нэгдмэл сангийн ангиллыг сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын хэмжээнд шинэчлэн тогтоох, газрын сангийн тооллого явуулж, тоо бүртгэлийг нарийвчлан гаргах ажлыг 1998 онд багтаан хийж дуусгах арга хэмжээ авсугай;

г/ газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг сум, дүүрэг бүрээр хийж баталгаажуулах ажлыг 1996-1998 онд хийж дуусгах арга хэмжээ авсугай;

д/ тусгай хэрэгцээний газрын хил, заагийг холбогдох яам, тусгай газартай хамтран зохих хууль тогтоомжийн дагуу 1996 онд багтаан шинэчлэн тогтоож, гэрээ байгуулах, гэрчилгээжүүлэх арга хэмжээ авсугай.

12. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг нарт даалгах нь:

а/ бүх шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 1998 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авсугай;

б/ газрын асуудал хариуцсан алба, албан тушаалтныг газар зохион байгуулах, газрын хянан баталгаа хийх багаж хэрэгсэлээр хангах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлдсүгэй.

13. Газрын тухай Монгол Улсын хууль батлагдсан болон энэ тогтоол гарсантай холбогдуулан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дор дурдсан тогтоолуудыг хүчингүй болсонд тооцсугай:

а/ "Газар эдэлбэрийн хуулийг биелүүлэх заавар батлах тухай" 1972 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 339 дүгээр тогтоол;

б/ "Газар эдэлбэрийн улсын бүртгэл, газрын тоо бүртгэлтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" 1974 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 135 дугаар тогтоол;

в/ "Дүрэм батлах тухай" 1975 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 58 дугаар тогтоол.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Байгаль орчны сайд

З. БАТЖАРГАЛ

Хүнс, хөдөө аж ахуйн сайд

Ц. ӨӨЛД

Засгийн газрын 1995 оны 143 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Газрын харилцааг зохицуулах, газрыг судлан шинжлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, түүний эзэмшил, ашиглалтыг дуусгавар болгох, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, газрын данс бүртгэл хөглөх, тайлан гаргах зэрэг газар зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд энэхүү журмыг дагаж мөрднө.

2. Бүх шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон төрийн өмчийн бус аж ахуйн нэгж, байгууллага (түүний дотор

гадаадын хөрөнгө оруулалттай), иргэн (түүний дотор гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүс) өөрийн мэдэл, эзэмшил, ашиглалтад байгаа буюу эзэмших, ашиглах газартаа энэ журмын дагуу газар зохион байгуулалт хийлгэж баталгаажуулах үүрэгтэй.

3. Газар зохион байгуулалтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага, албан тушаалтан хийнэ. Мэргэжлийн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд газар зохион байгуулалт хийх эрхийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага олгоно.

4. Улсын хэмжээнд газар зохион байгуулалт хийх ажлыг зохион байгуулах, газар зохион байгуулах ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, тэдний мэргэжил, дадлагыг дээшлүүлэх ажлыг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

5. Газар зохион байгуулалтыг мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу, үнэн зөв хийх үүргийг тухайн газар зохион байгуулалтыг эрхлэн гүйцэтгэж байгаа эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хүлээнэ.

6. Газар зохион байгуулалт хийх эрхгүй аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан энэ ажлыг гүйцэтгэхийг хориглоно.

Хоёр. Газар зохион байгуулалтын төрөл, түүнийг гүйцэтгэх

7. Газар зохион байгуулалтын ажил дараахь төрлүүдтэй байна:

а/ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулах, тодотгох;

б/ улсын тусгай хэрэгцээний газар нутгийн хилийн заагийг тогтоох, өөрчлөлт оруулах, тодотгох;

в/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах газрын судалгаа хийж, хэмжилт бүртгэл, зураглал хийх, хилийн заагийг тогтоох, өөрчлөх, тодотгох;

г/ гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд ашиглуулах газрын хил заагийг тогтоох, түүнд өөрчлөлт оруулах, тодотгох;

д/ улс болон бүс нутгийн хэмжээгээр ашиглах, хамгаалах газрын хэтийн төлөвийг тогтоож, бүх шатны Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, газар эзэмшигч, ашиглагчийн газар нутагт газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах;

е/ газрын сангийн данс бүртгэл хөтлөх, зураглал хийж тайлан гаргах, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх;

ж/ газар нутгийн нөхцөл, нөөц, чанарын төлөв байдал, эдийн засгийн чадавхи, үнэ, төлбөрийг тодорхойлох нэгдсэн арга зүй, хувь хэмжээг тогтоох үндэслэл боловсруулах, энэ чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил, боловсруулалт, сорилт туршилт хийх;

з/ газар нутгийн хэмжээ, төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг зохих журмын дагуу хийж дүгнэлт гарган, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээ авах.

8. Газар зохион байгуулалт нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэс, улсын тусгай хэрэгцээний газрын хилийн заагийг тогтоох, аливаа зориулалтаар газар авах, эзэмшүүлэх, ашиглуулах талар эрх бүхий байгууллагаас шийдвэр гаргах, уг шийдвэрийг хэрэгжүүлэх, газрыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хамгаалах, зохистой ашиглах төсөл, чиглэл боловсруулах үндэслэл болно.

9. Газар зохион байгуулалтыг дараахь харьяаллаар эрхлэн гүйцэтгэнэ:

а/ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулах, тодотгох, Газрын тухай Монгол Улсын хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 5-8-д зааснаар газар авах, түүнцлэн тодорхой газар бүс нутгийг хөгжүүлэхтэй холбогдсон чиглэл, төсөл боловсруулахаар газар зохион байгуулалт хийхэд газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас төмилсөн эрх бүхий мэргэжлийн байгууллага;

б/ Газрын тухай Монгол Улсын хуулийн 18 дугаар зүйлийн 3, 4, 9-д заасан тусгай зориулалтаар газар авах, үйлдвэртэлийн аргаар газар тариалан эрхлэх, ашигт малтмал олборлох, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулахтай холбогдсон газар зохион байгуулалтыг тухайн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын алба;

в/ энэ зүйлийн "а", "б"-д зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллага болон иргэний эзэмшил, ашиглалтад олгосон буюу олгох газрын газар зохион байгуулалтыг тэдгээрийн захиалгаар уг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг харьяалдаг сум, дүүргийн газар зохион байгуулалтын ажил хариуцсан албан тушаалтан;

г/ газрын данс бүртгэл хөтлөх, тайлан гаргахтай холбогдсон газар зохион байгуулалтын ажлыг аймаг, нийслэлийн хэмжээнд тухайн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын алба, сум, дүүргийн хэмжээнд тухайн сум, дүүргийн газар зохион байгуулалтын ажил хариуцсан албан тушаалтан.

10. Газар зохион байгуулалтын ажлыг дор дурдсан дарааллаар гүйцэтгэнэ:

- а/ бэлтгэл;
- б/ судалгаа;
- в/ санал боловсруулах;
- г/ шийдвэр гаргуулах;
- д/ гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх.

11. Газар зохион байгуулалтын бэлтгэлд газрын нөхцөл, нөөц, газрын эзэмшилт, ашиглалт, хамгаалалттай холбогдсон мэдээллийг бүрдүүлж газар зохион байгуулалт хийх зураг, багаж, хэрэгсэл бэлтгэх ажил хамаарна.

12. Судалгааны ажилд тухайн газрын төлөв байдал, чанар, байршил, хэмжээ, газрын ангиллыг нарийвчлан тодорхойлж, уг газрын ашиглалтын зориулалтыг тогтоох, хэтийн чиглэл боловсруулах, газрыг эзэмшүүлэх, ашиглуулах үндэслэлийг гаргах газар зохион байгуулалт хамаарна. Судалгаанд холбогдох засаг захиргаа, нутаг дэвсгэрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч, иргэнийг оролцуулж саналыг нь авна.

13. Судалгааны ажлын үр дүнг үндэс болгон сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан тухайн газар нутгийн ашиглалтын зориулалтыг тодорхойлон хэрхэн эзэмшүүлэх, ашиглуулах, газрын харилцааг зохицуулах талаар санал боловсруулна. Боловсруулсан саналд тухайн газрын байршил, хэмжээг тусгасан газрын зургийг хавсаргана. Санал нь хувилбартай байж болно.

14. Боловсруулсан санал нь тухайн газрын зориулалтыг төлөвлөх, ашиглалт, хамгаалалтыг зохицуулах, эзэмшүүлэх, ашиглуулах талаар шийдвэр гаргах үндэслэл болно. Шийдвэрт тухайн газрын ашиглалтын зориулалт, хэтийн чиглэл, эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгох эсэхийг заана. Санал, шийдвэрийн төслийг тухайн шатны Засаг даргад оруулна.

15. Газар зохион байгуулалтын алба, албан тушаалтны боловсруулсан санал, төслийг газрын харилцааг зохицуулах эрх бүхий байгууллага, тухайн шатны Засаг дарга зохих журмын дагуу хэлэлцэж эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргана. Оруулсан санал, төслийг зөвшөөрөхөөс татгалзвал үндэслэл, шалтгааныг тодорхой заана.

16. Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу газар зохион байгуулалтын алба, албан тушаалтан тухайн газрын хил, заагийг газар дээр нь тэмдэгжүүлэн баталгаажуулах, эрхийн гэрчилгээ олгох, гэрээ хийх ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэн, холбогдох мэдээллийг газрын сангийн данс бүртгэлд тусгана.

17. Тогтоосон журмаас гадуур гүйцэтгэсэн, дарааллаар хийгдээгүй газар зохион байгуулалт, зохих үе шатанд шаардагдах баримтыг бүрдүүлээгүй гаргасан шийдвэрийг дээд шатны төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан хүчингүй болгоно.

18. Газар зохион байгуулалтын ажлын дарааллын үед бүрдүүлсэн зураг, мэдээлэл, тооцоо, судалгаа, шийдвэрийн төсөл, шийдвэр, акт, протоколыг нэгтгэн бүрдүүлж нэг хувийг тухайн Засаг даргын ажлын алба байнга хадгална.

19. Газар зохион байгуулалтыг Газрын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу санхүүжүүлнэ.

Гурав. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалт

20. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, тэдгээрт өөрчлөлт оруулах, тодотгох санал боловсруулах зорилгоор хийх газар зохион байгуулалтыг дараахь байдалаар хэрэгжүүлнэ:

а/ сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулах, тодотгох санал боловсруулах мэргэжлийн комиссыг аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр байгуулна. Комиссыг Засаг даргын орлогч ахалж, бүрэлдэхүүнд нь холбогдох сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэлийн болон холбогдох сум, дүүргийн газрын асуудал хариуцсан албан тушаалтан, мэргэжлийн бусад хүмүүс, иргэний төлөөлөгчийг оруулна;

б/ аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоох, нэмэлт өөрчлөлт оруулах, тодотгох санал боловсруулах комиссыг Засгийн газар байгуулна. Комиссын бүрэлдэхүүнд газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, холбогдох аймаг, сумын нийслэлийн удирдлага, мэргэжлийн хүмүүс эрдэмтдийг оруулна.

21. Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулах, тодотгох санал боловсруулах комисс дараахь материалыг бүрдүүлж зохих шатны дээд байгууллагад оруулна:

а/ тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулах, тодотгох шалтгаан, уг газрын эзэмшил, ашиглалтын байдал, комиссоос хийж гүйцэтгэсэн ажлын тухай болон хийсэн дүгнэлт, оруулах саналын дэлгэрэнгүй илтгэх хуудас, хурлын протокол;

б/уг газар зохион байгуулалтад хамаарах сум, дүүргийн болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, эсвэл протокол;

в/ шинээр тогтоох, өөрчлөлт оруулах, тодотгох нутаг дэвсгэрийн хилийн цэсийн тухайн үеийн болон шинэчилсэн 1:500000-ын масштабтай газрын зураг;

г/ хилийн цэсийг тогтоож, өөрчлөлт оруулж, тодотгож байгаа сум, аймаг, нийслэлийн хил залгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн 1:500000-ын масштабтай газрын зураг дээр 1:100000-ын масштабтай зургийн нарийвчлалаар тэмдэглэсэн өөрчлөлт;

д/ шинээр тогтоож, өөрчлөлт оруулах, тодотгох болон түүнтэй хил залгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэст орсон өөрчлөлтийн тооцоо.

22. Шинээр тогтоож, өөрчлөлт оруулах болон түүнтэй хил залгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газрын зураг нь дараахь шаардлагыг хангасан байна:

а/ зураг дээрх хуучин хилийн цэсийг хар өнгөөр, шинэчилсэн хилийн цэсийг улаан өнгөөр ялган тодорхой зурж, хүчингүй болгох хилийн цэсийг улаан өнгөөр чагт тавьж дүрсэлсэн байх;

б/ хилийн цэсийн нэр нь батлагдсан нэртэйгээ тохирч байх шаардлагатай бөгөөд шинээр тогтоож байгаа хилийн цэсийн нэр нь талуудын тохиролцсон, маргаангүй, газрын зурагт тэмдэглэсэн байх;

в/ нутаг дэвсгэрийн хилийн цэсийг баруун хойт талын цэгээс эхлэн цагийн зүүний дагуу нар зөв тойруулан зөвхөн газар усны нэр, газрын өндрийн тэмдгийн тоот зэргээр тэмдэглэсэн уул, даваа, толгодын нэр болон усны түвшний өндөрлөгийн ард байгаа тоотыг хаалтад бичсэн, өндөрлөг нь нэргүй бол тухайн тоотоор тэмдэглэсэн байх;

г/ тоотоор тодорхойлогдож байсан нэргүй өндөрлөгийг тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагатай зөвшилцөн тухайн орон нутагт нэрлэж заншсан нэрээр нэрлэх чиглэл баримталж, уг нэрээр нэрлэх саналыг баталгаажуулсан байх;

д/ хавсралт хүснэгт, тооцоонд орсон тоон үзүүлэлтийг ашиглалтын зориулалт, төрөл (бэлчээр хадлан, тариалан, ой гэх мэт)-өөр ангилан тайлбарласан байх;

е/ шинэчлэн тогтоож, өөрчлөлт орж, тодотгол хийж байгаа нутаг дэвсгэрийн хэмжээг талбай тус бүрээр нь зохих багажаар нарийвчлан тодорхойлсны үндсэн дээр бэлчээр, хадлан, тариалан, ус, ой, хужиртай, намагтай газар гэх мэтээр газрын дэлгэрэнгүй ангиллаар тодорхойлон ялгасан байх;

Талбайн хэмжээг зөв гургахын тулд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн үндэж байгаа талбайг мөн дээрх замаар нарийвчлан тодорхойлж, хуучин талбайтай нь уялдуулан гургасан байх.

23. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг шинээр тогтоох, түүнд өөрчлөлт оруулах, тодотгох тухай дүгнэлт, саналаа комисс сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж гургасан шийдвэрийн хамтаар аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулна. Асуудлыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд авч хэлэлцээд газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад энэ журамд заасан материалыг хүргүүлнэ.

24. Аймаг, нийслэлээс оруулсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулах, тодотгох тухай материалыг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүлээн аваад Зохио хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг 30 хоногийн дотор багтаан хянаад Засгийн газарт оруулна.

25. Комиссоос санал зөрүүтэй, тохироцоогүйгээр ирүүлсэн материалыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж саналаа материалд хавсаргана. Уг санал нь дээд шатанд хэлэлцэх үндэслэл болно.

26. Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас оруулсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, түүнд өөрчлөлт оруулах, тодотгох тухай асуудлыг Засгийн газар авч хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

27. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулах, тодотгох талаар Улсын Их Хурлаас эцсийн шийдвэр гаргана.

**ДОРОВ. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын
эзэмшил, ашиглалтын газарт хийх
газар зохион байгуулалт**

28. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших, ашиглах эрх авах болон эзэмшиж, ашиглаж байгаа газартаа газар зохион байгуулалт хийлгэж баталгаажуулах тухай хүсэлтээ Газрын тухай Монгол Улсын хуулийн 30 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу бүрдүүлж тухайн газрыг харьяалах аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газарт гаргана.

29. Аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын асуудал хариуцсан алба, албан тушаалтан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн хүсэлт, өргөдлийг хүлээн аваад 14 хоногт багтаан судалгаа хийж дараахь материалыг нэмж бүрдүүлэн санал дүгнэлтээ Засаг даргад оруулна:

а/ эзэмшүүлж, ашиглуулах эрх олгох газрын зураг;

б/ газар эзэмшигч, ашиглагчтай хийх гэрээний төсөл;

в/ тухайн газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийсэн материал.

30. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газрын асуудал хариуцсан алба, албан тушаалтны санал, дүгнэлт бүхий материалыг хүлээн аваад 30 хоногт багтаан зохих шийдвэр гаргана.

31. Аймаг, сум, нийслэлийн дүүргийн газрын асуудал хариуцсан алба, албан тушаалтан Засаг даргын гаргасан шийдвэрийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд газар эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ:

а/ олгосон газрын заагийг газар дээр нь хэмжин тэмдэглүүлж эзэмшигч, ашиглагчид хүлээлгэн өгч акт үйлдэх;

б/ газар эзэмших, ашиглах гэрээ байгуулж гэрчилгээ олгох.

32. Нэг газрыг хоёр буюу түүнээс дээш этгээд эзэмших, ашиглахаар хүсэлт гаргавал Газрын тухай Монгол Улсын хуулийн 31 дүгээр зүйлийн 3-д заасны дагуу сонгон шалгаруулах замаар шийдвэрлэнэ.

33. Газар зохион байгуулалтын болон газар олгосон баримт бичиг, материал нь техникийн хувьд засваргүй цэвэр, нямбай хийгэсэн байхлас гадна тамга, тэмдэг дарж гарын үсэг зурсан, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр болж баталгаажсан байвал зохино.

Энэ шаардлагыг хангаагүй материалыг хүчингүйд тооцно.

34. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулахаар хүсэлтийнх нь дагуу газар зохион байгуулалт хийхэд газар зохион байгуулалтын төлөөлөгчөөтэй уялдуулан дараахь болзол, нөхцөлийг харгалзан үзнэ:

а/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хадлан, бэлчээр, тариалалтын зориулалтаар зохион байгуулалт хийлгэхэд тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт дурдсан үйл ажиллагааг эрхэлж байсан уламжлал, газрын хүрэлцээ, хөрсний үржил шим, шинж чанар, ургамлын ургацын байдал, уст цэгийн хангамж зэрэг үзүүлэлт;

б/ аж ахуйн нэгж, байгууллагад энэ зүйлийн "а"-д зааснаас бусад зориулалтаар үйлдэрлэл, үйлчилгээ эрхлэх, тэдгээрийг өргөтгөх эрх олгохоор газар зохион байгуулахад нутаг дэвсгэрийн хүрэлцээ, байрших газар, үйлдвэрлэл үйлчилгээний онцлогтой уялдуулан аль боло-

хоор хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглах боломжгүй газарт тэдгээрийг байршуулах чиглэл баримтлах;

н/ иргэнд гэр бүлийнхээ хэрэгцээнд зориулан сууц, хашаа барих, бусад зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх олгохоор газар зохион байгуулахад тухайн газрын байршил, төлөв байдал, хэмжээ, нутаг дэвсгэрийн хүрэлцээ, тухайн иргэний засаг захиргааны харьяалал;

г/ иргэн төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, тэжээлийн ургамал дангаараа буюу хамтран тариалахаар газар эзэмших, ашиглах эрх авах хүсэлт гаргаж, газар зохион байгуулалт хийхэд хөрсний үржил шим, хуваариа тариалахад тохиромжтой газрын хүрэлцээ, бусад хэрэгцээг харгалзан, хэмжээг Газрын тухай Монгол Улсын хуулийн 28 дугаар зүйлийн 2-т заасныг баримтлах;

д/ ашигт малтмал олборлох, хот, суурин барих, авто болон төмөр зам тавих зэрэгт газар эзэмших, ашиглах эрх олгохоор газар зохион байгуулалт хийхэд тэдгээрийн зураг төсөл нь холбогдох байгууллагуудад зохих журмын дагуу багтагдсан, тухайн сум, дүүргийн Засаг даргаас төсөл зохиохын өмнө газрын зөвшөөрөл авсан эсэх.

35. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тариалан, хадлан эрхлэх, малын өвөлжөө, хяваржаа болон сууц хашаа, барилга, байгууламж барих, өргөтгөн гэлэх, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах зориулалтаар газар олгоход уг газрыг эзэмшүүлэхээр, бусад тохиолдолд газрыг тэдэнд ашиглуулахаар тооцон газар зохион байгуулалт хийнэ.

36. Хот, суурин газрын эдэлбэр газрын хилийн заагийг тэдгээрийн хөгжлийн хэтийн төлөв, газар нутгийн хүрэлцээ, шаардлагыг харгалзан тухайн хот, сууринг харьяалдаг сум, дүүргийн газрын асуудал хариуцсан албан тушаалтан газар зохион байгуулалтын журмаар тогтоож Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батална.

Таа. Тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалт

37. Газрын тухай Монгол Улсын хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4-т заасан газар нутгийг тусгай хэрэгцээнд авах, бусад зориулалтаар хийх газар зохион байгуулалтыг тухайн газар нутгийн ашиглалт, хамгаалалтын асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын захиалгын дагуу эрх бүхий мэргэжлийн байгууллага энэ журамд заасны дагуу хийнэ.

38. Мал тууврийн улсын чанартай замын болон улсын тэжээлийн сангийн талбайн хилийн заагийг тогтоох газар зохион байгуулалтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, газрын асуудал хариуцсан албан тушаалтантай зөвшилцсөний үндсэн дээр хийнэ. Мал тууврын улсын чанартай замын хилийн заагийг Засгийн газар, улсын тэжээлийн сангийн талбайн хилийн заагийг хөдөө аж ахуйн болон газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

39. Аймаг дундын отрын нутгийн хилийн заагийг тогтоох газар зохион байгуулалтыг холбогдох аймгийн газрын асуудал хариуцсан алба хийж хөдөө аж ахуйн болон газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад оруулах бөгөөд уг хилийн заагийг Засгийн газар батална.

40. Сум дундын отрын нутгийн хилийн заагийг тогтоох газар зохион байгуулалтыг холбогдох сумын газрын асуудал хариуцсан албан тушаалтан хийж, сумын Засаг даргын өргөн мэдүүлснээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал батална.

41. Ган, зуд болох, түймэр, хортона нэрвэгдэх, бусад шалтгаанаар ургацгүй болох зэргээр их хэмжээний бэлчээр, хадлангийн талбайг ашиглах боломжгүй болсон тохиолдолд сумын нутаг дотор тухайн сумын Засаг дарга, аймгийн нутаг дотор холбогдох сумдын Засаг даргатай хамтран аймгийн Засаг дарга; Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын шийдвэрээр газар зохион байгуулалт хийж нутаг түр ашиглуулах асуудлыг зохицуулж түүний хугацааг тогтооно.

Зургаа. Бусад асуудал

42. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор багтаан газар зохион байгуулалтыг хийнэ.

43. Газар зохион байгуулалтаар тодорхойлсон газар нутаг, түүний хэмжээг тухайн сум, дүүргийн газрын зурагт холбогдох багажийн тусламжтайгаар уг зургийн масштабын дагуу оруулна. Зохион байгуулсан газар нутаг, талбайн хэмжээг үнэн зөв тодорхойлохын тулд хэмжилтийг хоёроос доошгүй удаа гүйцэтгэж хэмжээг дундаж үзүүлтээр илэрхийлнэ. Газар зохион байгуулалтад хамаараагүй үлдсэн талбайн хэмжээг түүнтэй уялдуулан зурагт тусгана.

44. Газар зохион байгуулалт хийж олгосон газрын талбайн хэмжээг гектар (га), метр квадрат (м²)-аар тодорхойлно.

45. Газар зохион байгуулалтын хил, заагийг уул, нурууны орой, даваа, овоо, дов толгодын орой зэрэг өндөрлөг, ус хуваарилах цэг

болон гол, горхи, уст цэгүүд, нуур, цөөрөм гэх мэтийн байгалийн биет зүйлээр тодорхойлох боломжгүй газар болон тариа, ногоо тариалах, байшин барилга барих зэрэг жижиг хэмжээний газрын хил заагийг шон тэмдэг тавьж тогтооно.

46. Газар зохион байгуулалтын материалыг 3 хувь үйлдэх бөгөөд нэгийг нь газар эзэмшигч, ашиглагчид, нөгөөг нь тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт халгалуулж, үлдэх хувийг шийдвэрийн төсөлд хавсаргана.

47. Сум, дүүргийн газар нутагт хийсэн газар зохион байгуулалтын тухайн жилийн өөрчлөлтийг жишүүрийн газрын зурагт газрын асуудал харнууцсан албан тушлалтан жил бүр тусгаж тайлагнах үүрэгтэй.

Засгийн газрын 1995 оны 143 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН УЛСЫН ХЯНАН БАТАЛГАА ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрийн өмчийн болон аливаа хэлбэрээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгосон газрын төлөв байдал, чанарт улсын хянан баталгаа хийхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа (цаашил "хянан баталгаа" гэнэ) нь төлөвлөгөөт, захиалгат, ээлжит бус гэсэн гөрөлтэй байх бөгөөд тэдгээрийг дараахь тохиолдолд хийнэ:

а/ төлөвлөгөөт хянан баталгааг төрийн хяналт, хамгаалалтыг хэрэгжүүлэх шаардлагаар аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамруулан;

б/ захиалгат хянан баталгааг төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн захиалгаар тэдний эзэмшил, ашиглалтын газарг;

в/ ээлжит бус хянан баталгааг төрийн өмчийн газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулахаар олгоход болон тэдний газар эзэмших, ашиглах эрхийг дуусгавар болгоход.

3. Хянан баталгааг газар эзэмшиж, ашиглаж байгаа болон газар эзэмших, ашиглах иргэн, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага заавал хийлгэх үүрэгтэй.

4. Газрын хянан баталгааг дараахь үзүүлт, нөхцөлийг харгалзан энэ журамд заасны дагуу хийнэ:

а/ төлөвлөгөөт хянан баталгаа хийхэд тухайн газрын ангилал, ашиглалтын зориулалт;

б/ захиалгат хянан баталгаа хийхэд газрын ашиглалтын зориулалт, төрөл, газар эзэмшигч, ашиглагчийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл;

в/ захиалгат болон ээлжит бус хянан баталгаа хийхэд захиалагчийн санал, бусад шаардлагатай үзүүлэлт.

5. Төлөвлөгөөт хянан баталгаанд хамруулах аймаг, нийслэл сум, дүүргийн нутаг дэвсгэр, газрын сангийн ангиллын ээлж дараалал, хугацааны хуваарь, хамрах нутгийн хуваарь, төлөвлөгөөг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

6. Захиалгат болон заввал гүйцэтгэх хянан баталгааны захиалгын маягтын загвар, захиалга хүлээн авах, гүйцэтгэх журмыг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

7. Бүх төрлийн хянан баталгааг Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны байгууллага (цаашид "хянан баталгааны байгууллага" гэнэ) гүйцэтгэнэ. Тармалан, хадлан, бэлчээр, ашигт малтмалтай холбогдуулан хянан баталгаа хийхэд тухайн салбарын зохих аж ахуйн нэгж, байгууллагад эрх олгож хянан баталгаанд оролцуулна.

8. Хянан баталгааны байгууллагын дарга (эрхлэгч) нь улсын хянан баталгааны ерөнхий шинжээч (цаашид "ерөнхий шинжээч" гэнэ) байна.

Ерөнхий шинжээч хянан баталгаатай холбогдол бүхий баримт бичигт өөрийн байгууллагын албан бичгийн хуудас, тамга, тэмдгийг хэрэглэнэ.

9. Ерөнхий шинжээч нь хянан баталгаа хийх шинжээчдийг өөрийн байгууллагаас болон бусад байгууллагатай тохиролцон байнга болон түр томилно.

10. Хянан баталгааны байнгын шинжээчид нь байгаль орчны улсын байцаагч байна.

Хоёр. Хянан баталгааны зардлын санхүүжээлт

11. Төлөвлөгөөт болон газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хариуцан хийлгэх хянан баталгааны зардлыг улсын төвлөрсөн төсвөөс; аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын хариуцан хийлгэх хянан баталгааны зардлыг орон тооны төсвөөс; газар эзэмшигч, ашиглагчийн газрын хянан баталгааны зардлыг тухайн захиалагчийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

12. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгох газрын хянан баталгааны зардлын төсвийг зохих аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн орон нутгийн төсөвт; төлөвлөгөөг болон Засгийн газрын эрх бүхий байгууллагын хариуцах хянан баталгааны захиалга, зардлын төсвийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нэгтгэн улсын төвлөрсөн төсөвт тус тус тусгуулна.

Хянан баталгааны зардлын төсвийг Засгийн газраас баталсан үнэлгээг зохионо.

Гурав. Хянан баталгааны нэгж талбар

13. Газрын төлөв байдал, чанарын тогтвортой үзүүлэлтүүдийг тодорхойлон улсын хяналтад авах, тэдгээрийн өөрчлөлтийг харьцуулан тогтоож байх зорилгоор сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хянан баталгаа-мэдээллийн тогтмол нэгж талбар (цаашид "нэгж талбар" гэнэ)-уудад хуваана.

14. Нэгж талбар бүрт улсын хэмжээгээр нэгдсэн тэмдэглэгээ, дугаар олгож сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын хэмжээний нэгж талбарын сүлжээний зургийг үйлдэнэ.

15. Нэгж талбарын сүлжээний зургийн нэг хувийг зохих сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хадгалан захиалгат болон хавал гүйцэтгэх хянан баталгааны төлөвлөгөө, захиалга, зардлын төсвийн тооцоо хийхэд ашиглана.

16. Нэгж талбарын сүлжээний зургийн нэг хувийг хянан баталгааны байгууллага хадгалан төлөвлөгөөг хянан баталгааны төлөвлөгөө, зардлын төсвийн тооцоо хийх, газрын төлөв байдал, чанарын болон байгаль орчны байдлын мэдээлэл, мониторингийн зорилгод ашиглана.

17. Нэгж талбарын дотор хот, тосгон, бусад суурины дэвсгэр газар эрж байвал уг талбарыг дэд талбаруудад хувааж нэгж талбарын сүлжээг нягтруулна.

18. Нэгж талбарын сүлжээ байгуулах зарчим нь байр зүйн зургийн туудасны олон улсын номенклатурын аргад тулгуурлан талбарын хил цаагийн шугамыг усны ай савын хил, усны хагалбарын шугам, тооцоохон уул нурууны хяр, гол мөрний эргийн шугам, засмал зам, хот, тосгон, суурины гудамж зэрэгтэй давхцаж байхаар тогтооно.

19. Нэгж талбарыг дотор нь газар ашиглалтын зориулалт, төрөл болон байгаль экологийн нөхцөл адил төстэй байх зарчмыг баримтган газрын төлөв байдал, чанарын үзүүлэлтээр тодорхойлно.

Үзүүлдэг бүрийн тодорхойлолтыг нэгж тодорхойлолт гэнэ. Нэгж талбар гүйцэтгэвэл зохих нэгж тодорхойлолтын тоо хэмжээний нормативыг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

20. Нэгж тодорхойлолт авах цэгийг дараахь зарчмаар сонгоно:

а/ М1-100000-1-200000-ын масштабын нарийвчлалтай бэлчээрийн зургийн ургамалжилт (шардлагатай тохиолдолд бэлчээрийг дотор нь улирлын ашиглалтаар болон байгаль экологийн нөхцлийн ялгааг харгалзан хувааж)-ын төрөл тус бүрээс;

тус бүр тодорхойлолтод заавал хамрагдахаар;

б/ тариалан, хадлан, атаржсан газрын талбай (тариалан, хадлангийн талбайн хэмжээ хэт том, хөрс, хөрсний элэгдэл нь жинд бус тохиолдолд дотор нь байгаль-экологийн ялгааг харгалзан хувааж) тус бүрээс;

в/ хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр ба хөдөө аж ахуйн үйлдвэртэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбайн талбар бүрээс;

г/ нийтийн эдэлбэрийн газрыг ашиглалтын зориулалтаар ангилан тус бүрээс төлөөллөөр;

д/ барилга байгууламжийн дэвсгэр болон дагалдах талбарыг тэнд явагдах үйл ажиллагааны болон байгаль орчинд нөлөөлөх хэв шинжээр ангилан, ангилал тус бүрийн төлөөллөөр;

е/ ойн экологи-аж ахуйн бүс бүр, түүний ойн төрөл бүрт төлөөллөөр;

ж/ ашиглалтын ойн бүсийн мод бэлтгэлийн талбайн талбар бүрт төлөөллөөр;

з/ гадаргуугийн ус бүхий газрын усны эх, адаг, эрэг хавийн газрын төлөөллөөр;

и/ нөөц газрын байгаль-экологийн ба газрын бүрхэвчийн хэв шинж бүрийн төлөөллөөр;

к/ улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын горимын бүс, түүний доторхи газрын төрөл, ашиглалтын ангилал бүрийн төлөөллөөр;

л/ улсын тусгай хамгаалалттай газрын зохих бүсэд гэрээгээр ашиглуулж байгаа газар тус бүр тодорхойлолтод заавал хамрагдахаар;

м/ улсын хилийн зурвасын дагуу 15 км-ийн алгасалттай байхаар;

н/ улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон ба гадаад улсын дипломат төлөөлөгчдийн болон консулын

газар, олон улсын байгууллагын төлөөлөгчдийн газарт олгосон газар бүр тодорхойлолтоор;

o/ аялал жуулчлал, рашаан сувилал, амралт зугаалтын бааз (төв), аялал-зугаалга, амралт-агнуур тогтмол хийдэг зам, зурвас, талбар бүр тодорхойлолтоор.

21. Хянан баталгааны үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо газрын төлөв байдал, чанарыг бодитой харуулж чадахуйц ажиглалт, хэмжилт, бичиглэл, задлан шинжилгээний аргуудыг хэрэглэнэ.

Дөрөв. Хянан баталгааны үндсэн үзүүлэлт

22. Газрын хянан баталгааны үзүүлэлт нь тухайн газрын чанар ба төрх байдлын аливаа өөрчлөлтийг бодитой тодорхойлохын зэрэгцээ ашиглалт, хэмжилт, задлан шинжилгээ хийхэд хялбар байхад чиглэнэ.

Хянан баталгаа хийх үзүүлэлтийг газар ашиглалтын үндсэн зориулалт, түүний хэрэгцээг харгалзан дараахь байдлаар тодорхойлно:

1/ бэлчээр:

- ургамлын зүйлийн бүрэлдэхүүн;
- ургамлын тусгац бүрхэвч;
- гадаргын төрх байдал;
- хөрсний элэгдэл, эвдрэл;
- гадаргын ба хөрсний бохирдол.

2/ тариалангийн талбай:

- хөрсний үржил шимт үе давхаргын зузаан;
- хөрсний алэмаг агуулалт;
- хөрсний уусмалын PH;
- нийт азот;
- шингээх багтаамж;
- хөрсний бохирдол;
- галаргын төрх байдал;
- хөрсний элэгдэл, эвдрэл;
- үндэслэг ишээр ба үндэсний хэсгээр үржлэг хог ургамлын тархалт;
- хөрсний хоёрдогч давсжилт, намагжилт (шаардлагатай тохиолдолд усалгаатай талбайд);
- гербицид ба пестицидийн үлдэгдэл.

3/ хадлангийн талбай:

- ургамлын зүйлийн бүрэлдэхүүн;
- ургамлын тусгац бүрхэвч;
- хөрсний элэгдэл, эвдрэл;
- гадаргын төрх байдал;
- гадаргын бохирдол;
- мэрэгчид, хортон шавьжийн хор хөнөөлд нэрвэгдсэн байдал.

4/ атаржсан талбай:

- хөрсний элэгдэл, эвдрэл;
- ургамлын формацийн өөрчлөлт:
 - а) шарилжит үе;
 - б) хиагны үе;
 - в) үетэн ба буурцагтны үе.
- гадаргын хөрсний бохирдол;
- гадаргын төрх байдал.

5/ хөдөө аж ахуйн ба хот, тосгон, бусад суурины барилга байгууламж, үйлдвэр уурхайн дэвсгэр газар:

- гадаргын ба хөрсний бохирдол;
- гадны хүчин зүйлийн үйлчлэлээр бий болсон хөрсний элэгдэл, эвдрэл (зулгаралт)

6. хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар ба нийтийн эдэлбэрийн газар, түүнчлэн зам, шугам, сүлжээний газар:

- гадаргын ба хөрсний бохирдол;
- гадны хүчин зүйлийн үйлчлэлээр бий болсон хөрсний элэгдэл эвдрэл (зулгаралт);
- хөрсний дээжийн бохирдол;
- ургамлын тусгац бүрхэвч.

7/ ойн сан бүхий газар:

- гадаргын төрх байдал;
- хөрсний элэгдэл, эвдрэл;
- ойн өтгөрөл;
- гадаргын ба хөрсний бохирдол;
- хортон шавьжийн тархалт;
- ойн орчны өөрчлөлт.

8. усны сан бүхий газар:

- усны эрдэсжилт;
- усны бохирдолт;
- гадаргын төрх байдал;
- эрэг орчмын хөрсний элэгдэл, эвдрэл;
- эрэг орчмын гадаргын хөрсний бохирдол;

-усны гольдролын өөрчлөлт.

9. нөөц газар:

-тухайн газар нутаг ямар зориулалтаар нөөцөд байгааг харгалзан хянан баталгаа хийх үзүүлэлтийг сонгоно.

10/ улсын тусгай хамгаалалттай газар

-гадаргын төрх байдал;

-ургамлын зүйлийн бүрэлдэхүүн;

-газар нутгийн өвөрмөц тогтоц, үзэсгэлэнт байдал;

-түүх соёлын дурсгалт газрын хадгалалт;

-хөрсний элэгдэл, эвдрэл.

11/ улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газрын ашиглалтын зориулалтад нийцүүлж хянан баталгааны үзүүлэлтийг сонгоно.

12/ хилийн зурвас газар:

-хөрсний элэгдэл, эвдрэл;

-гадаргын төрх байдал;

-ургамлын зүйлийн бүрэлдэхүүн;

-гадаргын хөрсний бохирдол.

13/ гадаад улсын дипломат төлөөлөгчдийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчдийн газарт олгосон газарт хянан баталгаа хийхэд нийтлэг журмыг баримтална.

14/ Аялал жуулчлал, рашаан сувилал, амралт зугаалгын газар:

-гадаргын төрх байдал;

-хөрсний элэгдэл, эвдрэл;

-гадаргын ба хөрсний бохирдол;

-ургамлын тусгац бүрхэвч;

-ургамлын зүйлийн бүрэлдэхүүн;

-рашаан усны орчны газрын ариун цэвэр, эрүүл ахуй;

-газар нутгийн өвөрмөц тогтоц, үзэсгэлэнт байдал;

-түүх, соёлын дурсгалт газрын хадгалалт.

15. Газрын төрх байдал, чанарт гарч болзошгүй өөрчлөлтийг тодорхойлоход дээр дурасанаас өөр үзүүлэлт хэрэглэж болно.

Тав. Хянан баталгаа хийх хугацаа

23. Төлөвлөгөөт хянан баталгааг 5 жилд нэг удаа газрын сангийн бүх ангиллын газар хамаарагдахаар зохион байгуулна.

24. Газрын төлөв байдал, чанарт хүчтэй нөлөөлөхүйц арга, технологи, хэрэглэл ашиглаж байгаа газар (тариалангийн талбай, хот, тосгон, бусад суурины газар, үйлдвэр уурхайн эдэлбэр гэх мэт)-т хянан баталгааг 3 жилд нэг удаа хийнэ.

25. Захиалгат ба ээлжит хянан баталгааг тухайн газарт урьд хийсэн хянан баталгааны хутагцаа харгалзахгүйгээр хийнэ.

26. Захиалгат ба ээлжит бус хянан баталгааны 3 жилийн доторхи дүнг ерөнхий шинжээчийн шийдвэрээр төлөвлөгөөт хянан баталгаанд ашиглаж болно.

Зургаа. Хянан баталгаанд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, газар эзэмшигч, ашиглагчийн оролцоо

27. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж харьяалах нутаг дэвсгэртээ явагдах төлөвлөгөөт болон захиалгат хянан баталгаанд өөрийн төлөөлөгчийг оруулж болно.

28. Сум, дүүргийн газрын асуудал хариуцсан албан тушаалтан бүх төрлийн хянан баталгаанд Засаг даргын төлөөлөгчөөр заавал оролцоно.

29. Хянан баталгаанд Засаг даргын газрын асуудал хариуцсан албан тушаалтнаас өөр хүнийг төлөөлөгчөөр оролцохыг хориглоно.

30. Газар эзэмшигч, ашиглагчийн захиалгат болон ээлжит бус хянан баталгаанд газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, дарга, эрхлэгч, захирал биеэр байлцах үүрэгтэй.

31. Хянан баталгаанд заавал оролцох үүрэг бүхий иргэн, албан тушаалтан хянан баталгаанд оролцоогүй нь хянан баталгаа хийх ажлыг зогсоох, хойшлуулах үндэслэл болохгүй.

Долоо. Хянан баталгааг баталгаажуулах, үр дүнг мэдээлэх

32. Хянан баталгаа нь дараахь баримт бичгээр баталгаажина:
а/ нэгжийн тодорхойлолт баримт;
б/ газрын төлөв байдал, чанарын үзүүлэлтийн паспорт;
в/ сум, дүүрэг, аймаг, нийслэлийн хянан баталгааны дүгнэлт;
г/ газрын нэгдмэл сангийн хянан баталгааны дүгнэлт;
д/ газар болон байгаль орчны хууль тогтоомжийн биелэлтийн үндэс (эс үйлдэхүйц)-ийн талаархи мэдэгдэл.

33. Нэгжийн тодорхойлолт бүрийн ажиглалт, хэмжилт, бичиглэл, задлан шинжилгээ нь нэгжийн тодорхойлолтын баримтад тусгагдана.

34. Нэгжийн тодорхойлолтын баримтад үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж буй газрын хянан батал-

гааны паспортыг хөтөлнө. Хянан баталгааны паспортыг газар эзэмших, ашиглах гэрээнд хавсаргана.

35. Төрийн өмчөөс иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгоогүй газрын хянан баталгааны паспортыг засаг даргын нэр дээр нээж хөтөлнө. Засаг дарга өөрчлөгдвөл хянан баталгааны паспортад энэ тухай тэмдэглэл хийнэ.

36. Ерөнхий шинжээч төлөвлөгөөт болон захиалгат хянан баталгааны тодорхойлолт, актуудыг нэгтгэн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн хянан баталгааны дүгнэлт гаргаж, холбогдох Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдэд хүргүүлнэ.

37. Хянан баталгааны байгууллага бүх төрлийн хянан баталгааны дүнг үндэслэн газрын улсын нэгдмэл сангийн төлөв байдал, чанарын нэгдсэн дүгнэлтийг 5 жилд нэг удаа гаргаж газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад дүгнэлтийг Засгийн газарт танилцуулна.

38. Газрын улсын нэгдмэл сангийн байдлын талаархи мэдээллийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн холбогдох мэдээллийг хянан баталгааны байгууллага хэвтэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна.

39. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газарт хийсэн төлөвлөгөөт хянан баталгааны актын нэг хувийг сум, дүүргийн Засаг даргад хадгална.

40. Газрын хянан баталгааны явцад илэрсэн зөрчил, түүний шинж байдлын талаар газрын асуудал хариуцсан төрийн захиргааны зохих байгууллагад холбогдох хууль хяналтын байгууллага буюу байгаль орчны байцаагч мэдэгдэнэ.

41. Хянан баталгааны бичиг баримтын маягтын загвар, түүнийг хөтлөх, хадгалах, шилжүүлэх журмыг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

Найм. Маргааныг шийдвэрлэх

42. Хянан баталгаатай холбогдон гарсан маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол ерөнхий шинжээч шийдвэрлэнэ.

43. Ерөнхий шинжээчийн шийдвэрийн талаархи гомдлыг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

44. Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр Монгол Улсын хууль тогтоомжид нийцээгүй гэж үзвэл маргалдагч тал гомдлоо шүүхэд гаргаж болно.

Ес. Хариуцлага

45. Хянан баталгаа хийхэд болон түүний явцад зориудаар саад учруулсан аж ахуйн нэгж, байгууллага, түүнчлэн шинжээчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон иргэн болон хянан баталгаанд үүргийн дагуу оролцоогүй иргэн, албан тушаалтан Газрын тухай болон Захиргааны хариуцлагын тухай Монгол Улсын хуулиуд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль эрхийн актын дагуу хариуцлага хүлээнэ.

46. Хянан баталгааны журам зөрчиж ажлын чанарын гологдол гаргасан, баримт бичгийг санаатайгаар засварласан, түүнийг үрэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хянан баталгааны баримт бичгийг хүчингүйд тооцож, гэм буруутай этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэн, хянан баталгааг шинэчлэн хийж зардлыг буруутай этгээдээс гаргуулна.

Засгийн газрын 1995 оны 143 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

ГАЗРЫН САНГИЙН ДАНС БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ТАЙЛАН ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Газрын сангийн данс бүртгэл, газрын сангийн жижүүрийн зураг хөтлөх, газрын сангийн тайлан гаргах, тайлагнах, албажуулах, хүлээн авах үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Газрын сангийн данс бүртгэл нь дараахь төрлөөс бүрдэнэ:

1/ газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй данс бүртгэл;

2/ газрын нэгдмэл сангийн нэгдсэн данс бүртгэл;

3/ газрын мэдээллийн улсын нэгдсэн сан.

3. Газрын сангийн тайлан дараахь төрөлтэй байна:

1/ сум, дүүргийн болон тэдгээрт харьяалагдах тосгон, бусад суурины газрын тайлан;

2/ аймаг, нийслэл, улсын харьяалалтай болон хэд хэдэн сумын нутаг дэвсгэрийг дамжсан эдэлбэртэй хотын газрын нэгдсэн тайлан;

3/ газрын нэгдмэл сангийн улсын тайлан.

4. Газрын мэдээллийн улсын сан нь зохих журмаар зөвшөөрөгдсөн үзүүлэлтээс бүрдэнэ. Сангийн үзүүлэлтийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, шинэчлэх, хэрэглэгчийг үйлчлэх арга ажиллагаа нь газар зүйн мэдээллийн системийн технологид суурилсан байна.

5. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүр, тэдгээрийн харьяалалд байгаа хот, тосгон, суурин бүр газрын сангийн дэлгэрэнгүй данс бүртгэл (цаашид "данс бүртгэл" гэнэ) хөтөлж газрын тайлан гаргана. Хот, тосгоны газрын сангийн данс бүртгэлийн бүрэлдэхүүн хэсэг байна.

6. Хэд хэдэн сумын нутаг дэвсгэрийг дамжсан газар эдэлбэртэй хот болон аймаг, нийслэл газрын сангийн нэгдсэн данс бүртгэл хөтөлж, тайлан гаргана.

7. Улсын хэмжээнд газрын нэгдмэл сангийн улсын тайлан (цаашид "улсын тайлан" гэнэ), газрын мэдээллийн улсын сан (цаашид "мэдээллийн сан" гэнэ)-тай байна.

Хоёр. Газрын сангийн данс бүртгэл, өгөгдөхүүн, газрын бүртгэл-зураглал

8. Газрын нэгдмэл сангийн данс бүртгэлийг Газрын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үзүүлэлтийг үндэслэн ангилж газрын болон статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан газрын данс бүртгэлийн маягтаар хөтөлнө.

Газрын үнэлгээ, чанарын үзүүлэлтийг бүртгэх маягтын загварыг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

9. Данс бүртгэлийн анхдагч үзүүлэлтийг 1995 оны 4 дүгээр сарын 1-нээс хойш гүйцэтгэсэн газар олголтын материал, эрх бүхий мэргэжлийн байгууллагын газрын хэмжилт, бүртгэлийн дүн, газар зохион байгуулалтын зориулалтаар хийсэн хөрс, бэлчээрийн зураглал, газар ашиглалтын судалгаа, газрын үнэлгээ зэрэг албан ёсны ажлын материалд тулгуурлан авна.

Энэ зүйлийн нэг дэх хэсэгт дурдсан албан ёсны суурь материал байхгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, газар эзэмшигч, ашиглагчийн өөрийн нь санаачилгаар газар зохион байгуулалтын мэргэжлийн байгууллага холбогдох судалгаа, бүртгэл, зураглал, үнэлгээг гүйцэтгэнэ.

10. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хотын газрын алба (газрын даамал) газрын эрх зүйн байдал, хуваарилалт, ашиглалтын төрөл, байгалийн бүрхэвч, төрх байдал, чанарт тайлант хугацаанд гарсан өөрчлөлтөд бүртгэл, зураглал үйлдэн тодотгол данс хөтөлж газрын сангийн данс бүртгэлд жилд нэг удаа өөрчлөлт оруулна.

11. Газрын данс бүртгэлд зориулсан газрын бүртгэл зураглал, тодорхойлолтыг гагцхүү газрын кадастрын бүртгэлийн болон газар зохион байгуулалтад хэрэглэх зориулалт бүхий багаж хэрэгслийг ашиглан газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан зааврын дагуу гүйцэтгэнэ.

12. Газрын сангийн данс бүртгэлд газрын хэмжээг га-гаар илэрхийлнэ.

Иргэдийн орон сууцны хашааны газар, барилга байгууламжийн эзэлж буй дэвсгэр газар, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний талбай гоёл чимэглэлийн ургамлын болон мод үржүүлгийн газар, хамгаалалтын ойн зурвасын доорхи газрын хэмжээг таслалаас хойш хоёр оронгийн нарийвчлалтай, бэлчээр, ой, ус, нөөц газарт багтах бусад төрлийн газрын хэмжээг мянган га-гийн нарийвчлалтай бусад төрлийн газрын хэмжээг га-гийн нарийвчлалтай илэрхийлнэ.

Гурав. Газрын нэгдмэл сангийн тайлан, бүтэц агуулга

13. Бүх шатны газрын сангийн нэгдсэн тайлан (цаашид "газрын тайлан" гэнэ) нь нэг маягийн маягтад бөглөсөн тоон мэдээлэл, бичмэл тайлан, жижүүрийн зургаас бүрдэнэ. Сум, дүүрэг, аймаг, нийслэл газрын сангийн нэгдсэн тайланг газрын болон статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан маягтаар, улсын хэмжээний газрын сангийн нэгдсэн тайланг Засгийн газраас баталсан маягтаар тус тус хууль тогтоомжид заасан хугацаанд гаргана.

14. Бичмэл тайлан (цаашид "тайлан" гэнэ)-д газрын сангийн удирдлага, менежмент болон Газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар авсан зохион байгуулалтын арга хэмжээ, байгаль орчин, газрын хууль тогтоомжийн хэрэгжилт, газрын төлөв байдал, чанарт гарсан сөрөг үзэгдэл, түүнд өгөх дүгнэлт, газрыг зохистой ашиглах, хамгаалах талаар төр болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн, энэ талаархи дутагдал, газрын сангийн эрх зүйн байдалд гарсан өөрчлөлт, эзэмшигч, ашиглагчдад хуваарилсан байдал, газрын сангийн үндсэн

ангилал, газар ашиглалтын төрөлд гарсан өөрчлөлт, шилжилтийн үндэслэл, газрын төлбөр ногдуулалт, төлөлт зэргийг дэлгэрэнгүй тусгана.

15. Газрын сангийн үндсэн ангилал, ашиглалтын төрөлд орсон өөрчлөлт, тэдгээрийн хоорондын шилжилт хөдөлгөөний тэнцлийг холбогдох маягтад үзүүлнэ. Газрын шилжилт, хөдөлгөөний тэнцлийн маягтын үзүүлт нь бүх шатны газрын данс бүртгэлийн хөглөлт, тайлангийн үнэмшлийг дээд шатны албадаас шалгаж хүлээн авах, газрын мэдээллийн улсын нэгдсэн сангийн өгөгдөхүүнийг өөрчлөх үндэслэл болно.

Дөрөв. Газрын тайлангийн жижүүрийн зураг

16. Газрын сангийн жижүүрийн зурагт газрын данс бүртгэл, тайланд тусгагдсан бүх өөрчлөлтийн байршил, хил зааг, хэмжээг харуулна.

17. Газрын тайлангийн жижүүрийн зургийг сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан дараахь масштабын нарийвчлалаар үйлдэнэ:

1/ 300000 га-гаас бага нутаг дэвсгэрт 1:100000-ын масштаб;

2/ 300000-500000 га нутаг дэвсгэрт 1:200000-ын масштаб;

3/ 500000 га-гаас дээш нутаг дэвсгэрт 1:500000-ын масштаб.

18. Хот, тосгон, суурины газрын тайлангийн жижүүрийн зургийг газрынх нь хэмжээнээс хамааруулан 1:25000-1:2000-ын масштаб баар үйлдэнэ.

19. Жижүүрийн зургийн масштабаар илэрхийлэх боломжгүй газрын өөрчлөлтийн байршлыг масштабын бус тэмдгээр харуулж, шаардлагыг хангаж чадахуйц нарийвчлалаар хийсэн хэсэгчилсэн зургийг дагалдуулна.

Тав. Газрын сангийн данс бүртгэл, тайланг баталгаажуулах

20. Сум, дүүргийн харьяа хот, тосгон, суурины газрын сангийн дэлгэрэнгүй данс бүртгэл, тайланг сум, дүүргийн газрын асуудал хариуцсан албан тушаалтан эрхлэн үйлдэж, хот, тосгон, суурины захирагч, газрын асуудал хариуцсан албан тушаалтан гарын үсэг

зурна. Хот, тосгон, суурины газрын тайланг тухайн оны 10 дугаар сарын 10-ны дотор сум, дүүргийн Засаг даргад ирүүлнэ.

21. Сум, дүүргийн болон хэд хэдэн сумын нутаг дамжсан газар эдэлбэртэй хотын газрын сангийн данс бүртгэл, тайланг сум, дүүргийн газрын асуудал хариуцсан алба (албан тушаалтан) эрхлэн гүйцэтгэж тухайн Засаг дарга, газрын албаны дарга (албан тушаалтан) гарын үсэг зурна.

22. Аймаг, нийслэлийн данс бүртгэл, газрын тайланг аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан алба эрхлэн гаргаж аймаг, нийслэлийн Засаг дарга, уг газрын албаны дарга (албан тушаалтан) гарын үсэг зурна.

23. Сум, дүүрэг, аймаг, нийслэлийн тухайн оны газрын тайланг зохих шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулсан байна.

24. Газрын сангийн тухайн оны тайланг Газрын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасан хугацаанд дээд шатныхаа Засаг дарга, газрын асуудал хариуцсан албанд тайлагнана.

25. Аймаг, нийслэлийн тухайн оны газрын тайланг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүлээн авна.

Аймаг, нийслэлээс гаргадаг газрын сангийн нэгдсэн тайланд харьяа сум, дүүргийн жижүүрийн зураг, газрын шилжилт хөдөлгөөний тэнцлийн маягтын нэг хувийг газрын мэдээллийн улсын санд хадгалуулахаар хавсаргана.

26. Дээд шатных нь Засаг дарга болон газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага газрын нэгдсэн тайланг хүлээн авахдаа тайлангийн үнэмшил, магадлал, тэнцэл, газрын сангийн дэлгэрэнгүй болон нэгдсэн данс бүртгэлийн хөтлөлт, жижүүрийн зургийн агуулгын бүрэн байдал, нарийвчлал, үйлдэлт нь зохих шаардлага, нөхцөлийг хангаж байгаа эсэхийг хянаж хүлээн авна.

27. Шаардлага хангаагүй газрын сангийн дэлгэрэнгүй болон нэгдсэн данс бүртгэлийг зохих шатны Засаг дарга, газрын асуудал хариуцсан зохих шатны байгууллагын шийдвэрээр хүчингүйд тооцож дахин шинээр гаргуулна.

28. Шаардлага хангаагүй тайлан, жижүүрийн зургийг зохих шатны Засаг дарга, газрын асуудал хариуцсан зохих шатны байгууллагын шийдвэрээр засуулах, дахиж хийлгэхээр буцааж болно.

Зургаа. Маргаан, хариуцлага

29. Данс бүртгэл, жижүүрийн зураг, тайлангийн агуулга, нарийвчлал, техник, технологийн түвшний талаар үүссэн маргааныг шүүх, гомдлыг газрын мэргэжлийн байгууллага шийднэ.

30. Данс бүртгэл, жижүүрийн зураг хөтлөх, тайлан гаргах, тушаах, хүтээн авахтай холбогдон үүссэн эрх, үүрэг, хариуцлагын талаархи маргааныг зохих шатны Засаг дарга, газрын асуудал хариуцсан алба (албан тушаалтан) шийдвэрлэнэ. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.

31. Данс бүртгэл, жижүүрийн зураг, тайлангийн талаар Газрын тухай Монгол Улсын хууль, энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүдээлгэхээргүй бол зохих хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага ногдуулна.

ТАЪЛИМ НАҲМЛАТИ САМАНДРИ ЭРХ СИРИ
 БАЎЛИНИ ТАЪЛИМ

№	Таълим наҳмлати таълимнинг номи	№	Таълим наҳ- матининг номи	Икки таълим	Таълим наҳмлати таълимнинг номи									
					Таълим наҳмлати таълимнинг номи									
					Бир	Икки	Уч	Чо	Беш	Олти	Сеп	Олт	Сеп	Олт
1	Таълим наҳмлати таълимнинг номи	1	1	2	3	4	5	6	7	8	9	10		
2	Таълим наҳмлати таълимнинг номи	2	1	2	3	4	5	6	7	8	9	10		
3	Таълим наҳмлати таълимнинг номи	3	1	2	3	4	5	6	7	8	9	10		
4	Таълим наҳмлати таълимнинг номи	4	1	2	3	4	5	6	7	8	9	10		
5	Таълим наҳмлати таълимнинг номи	5	1	2	3	4	5	6	7	8	9	10		
6	Таълим наҳмлати таълимнинг номи	6	1	2	3	4	5	6	7	8	9	10		
7	Таълим наҳмлати таълимнинг номи	7	1	2	3	4	5	6	7	8	9	10		
8	Таълим наҳмлати таълимнинг номи	8	1	2	3	4	5	6	7	8	9	10		
9	Таълим наҳмлати таълимнинг номи	9	1	2	3	4	5	6	7	8	9	10		
10	Таълим наҳмлати таълимнинг номи	10	1	2	3	4	5	6	7	8	9	10		
11	Таълим наҳмлати таълимнинг номи	11	1	2	3	4	5	6	7	8	9	10		
12	Таълим наҳмлати таълимнинг номи	12	1	2	3	4	5	6	7	8	9	10		
13	Таълим наҳмлати таълимнинг номи	13	1	2	3	4	5	6	7	8	9	10		
14	Таълим наҳмлати таълимнинг номи	14	1	2	3	4	5	6	7	8	9	10		
15	Таълим наҳмлати таълимнинг номи	15	1	2	3	4	5	6	7	8	9	10		
16	Таълим наҳмлати таълимнинг номи	16	1	2	3	4	5	6	7	8	9	10		
17	Таълим наҳмлати таълимнинг номи	17	1	2	3	4	5	6	7	8	9	10		
18	Таълим наҳмлати таълимнинг номи	18	1	2	3	4	5	6	7	8	9	10		
19	Таълим наҳмлати таълимнинг номи	19	1	2	3	4	5	6	7	8	9	10		
20	Таълим наҳмлати таълимнинг номи	20	1	2	3	4	5	6	7	8	9	10		
21	Таълим наҳмлати таълимнинг номи	21	1	2	3	4	5	6	7	8	9	10		
22	Таълим наҳмлати таълимнинг номи	22	1	2	3	4	5	6	7	8	9	10		

Засгийн газрын 1995 оны 143 дугаар
 тулгамдын 4 дүгээр хэсгээр

Мэтр УТ-2

ГАЗРЫН НЭГЛЭЛЭЛ САНГИЙН ҮНДСЭН АНГИУЛЛЫН
 ТАЯЛАН

Үржж : (түгээс анхны үнэ)

№	Анхны үнэ	Нэгж	Үржж													
			Үржж					Үржж								
			1	2	3	4	5	6	7	8	9	10				
1																
2																
3																
4																

Март 17-2-мил гэрээний

Улаан хотын тусгай тусламж		Хөвсгөр хотын тусгай тусламж				Төвийн тусламж				
Бичиг	1933			Бичиг	1933			Бичиг	1933	
	Улаан хотын тусгай тусламж	Хөвсгөр хотын тусгай тусламж	Төвийн тусламж		Улаан хотын тусгай тусламж	Хөвсгөр хотын тусгай тусламж	Төвийн тусламж		Улаан хотын тусгай тусламж	Хөвсгөр хотын тусгай тусламж
27				27				27		
				28				28		
				29				29		
				30				30		
				31				31		
				32				32		
				33				33		
				34				34		
				35				35		
				36				36		
				37				37		
				38				38		
				39				39		
				40				40		

4	Dua	Bait		24						
		1	2							
5	Kata bait	1	Alloh Maha Esa	25						
		2	Alloh Maha Esa	26						
		3	Alloh Maha Esa	27						
6	Kata bait	1	Alloh Maha Esa	28						
		2	Alloh Maha Esa	29						
		3	Alloh Maha Esa	30						
7	Kata bait	1	Alloh Maha Esa	31						
		2	Alloh Maha Esa	32						
		3	Alloh Maha Esa	33						
8	Kata bait	1	Alloh Maha Esa	34						
		2	Alloh Maha Esa	35						
		3	Alloh Maha Esa	36						
9	Kata bait	1	Alloh Maha Esa	37						
		2	Alloh Maha Esa	38						
		3	Alloh Maha Esa	39						
10	Kata bait	1	Alloh Maha Esa	40						
		2	Alloh Maha Esa	41						
		3	Alloh Maha Esa	42						
11	Kata bait	1	Alloh Maha Esa	43						
		2	Alloh Maha Esa	44						
		3	Alloh Maha Esa	45						
12	Kata bait	1	Alloh Maha Esa	46						
		2	Alloh Maha Esa	47						
		3	Alloh Maha Esa	48						
13	Kata bait	1	Alloh Maha Esa	49						
		2	Alloh Maha Esa	50						
		3	Alloh Maha Esa	51						
14	Kata bait	1	Alloh Maha Esa	52						
		2	Alloh Maha Esa	53						
		3	Alloh Maha Esa	54						
15	Kata bait	1	Alloh Maha Esa	55						
		2	Alloh Maha Esa	56						
		3	Alloh Maha Esa	57						
16	Kata bait	1	Alloh Maha Esa	58						
		2	Alloh Maha Esa	59						
		3	Alloh Maha Esa	60						
17	Kata bait	1	Alloh Maha Esa	61						
		2	Alloh Maha Esa	62						
		3	Alloh Maha Esa	63						
18	Kata bait	1	Alloh Maha Esa	64						
		2	Alloh Maha Esa	65						
		3	Alloh Maha Esa	66						
19	Kata bait	1	Alloh Maha Esa	67						
		2	Alloh Maha Esa	68						
		3	Alloh Maha Esa	69						
20	Kata bait	1	Alloh Maha Esa	70						
		2	Alloh Maha Esa	71						
		3	Alloh Maha Esa	72						
21	Kata bait	1	Alloh Maha Esa	73						
		2	Alloh Maha Esa	74						
		3	Alloh Maha Esa	75						
22	Kata bait	1	Alloh Maha Esa	76						
		2	Alloh Maha Esa	77						
		3	Alloh Maha Esa	78						
23	Kata bait	1	Alloh Maha Esa	79						
		2	Alloh Maha Esa	80						
		3	Alloh Maha Esa	81						
24	Kata bait	1	Alloh Maha Esa	82						
		2	Alloh Maha Esa	83						
		3	Alloh Maha Esa	84						
25	Kata bait	1	Alloh Maha Esa	85						
		2	Alloh Maha Esa	86						
		3	Alloh Maha Esa	87						
26	Kata bait	1	Alloh Maha Esa	88						
		2	Alloh Maha Esa	89						
		3	Alloh Maha Esa	90						
27	Kata bait	1	Alloh Maha Esa	91						
		2	Alloh Maha Esa	92						
		3	Alloh Maha Esa	93						
28	Kata bait	1	Alloh Maha Esa	94						
		2	Alloh Maha Esa	95						
		3	Alloh Maha Esa	96						
29	Kata bait	1	Alloh Maha Esa	97						
		2	Alloh Maha Esa	98						
		3	Alloh Maha Esa	99						
30	Kata bait	1	Alloh Maha Esa	100						
		2	Alloh Maha Esa	101						
		3	Alloh Maha Esa	102						

МАРТ УТ-6

ГАЗАР ХАМГААЛАХ ТАЛМАР АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ
НЭГДСЭН ТАЙЛАН (га)

N Аймагийн нэр	Тариалангийн газар		Бэлгээр ба бусад өвжөөр уртгалт газарт		Хор, тохсон, бу- сал сүүрмийн газар		Ойр сан бүхий газар		Усны сан бүхий газар		Бусад газарт		
	Ихэлт талбай	Үүрэг Хамга- алтын эргэ сэмжлэл арга	Ихэлт талбай	Үүрэг Хамга- алтын эргэ сэмжлэл арга	Ихэлт талбай	Үүрэг Хамга- алтын эргэ сэмжлэл арга	Ихэлт талбай	Үүрэг Хамга- алтын эргэ сэмжлэл арга	Ихэлт талбай	Үүрэг Хамга- алтын эргэ сэмжлэл арга	Ихэлт талбай	Үүрэг Хамга- алтын эргэ сэмжлэл арга	
0	А	01	02	03	04	05	06	07	08	09	10	11	12
Дүн													

Зөгийн газрын 1995 оны 143 дугаар
 тогтоолын 4 дүгээр хэсгээр

Март УТ-7

ГАЗРЫН ТӨЛБӨР НӨЛГҮҮЛЭЛТ, ТӨЛӨГТИЙН УЛСЫН
 НЭГДСЭН ТАЙЛАН (МАН ТӨС)

Аймаг, ойдот- нон мөр	Илэр- хийн (саяага)	Нэр төбө- рөөн үүснэгт	Тусламж төр үргэлжлэл төбө	Урьдчилсан үйлчилгээний төлбөр					Холбооноос үлдсэн төлбөр					Энгийн төлбөр төс	Орлог төс	Урлаг төс
				Төлбөр					Төлбөр							
				Бүтэц	Хүч сүлж	Хүн сүлж	Тусламж төс	Бүтэц	Бүтэц төс	Хүч сүлж	Хүн сүлж	Тусламж төс	Урлаг төс			
А	01	02	03	04	05	06	07	08	09	10	11	12	13	14	15	

Засгийн газрын 1995 оны 143 дугаар
тогтоолын 5 дугаар хавсралт

ГАЗРЫГ УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНД АВАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалт байгаа болон бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй газраас тусга хэрэгцээнд зориулан газар авахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Газрыг тусгай хэрэгцээнд авахад Газрын тухай Монгол Улса хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасныг баримтална.

3. Энэ журам нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн захиргааны бүх шатны байгууллага, түүнчлэн иргэн, аж ахуйн нэг байгууллагад хамаарна.

Хоёр. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай санал гаргах

4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, Монгол Улсын төрийн захиргааны төв байгууллагууд (цаашид "Засгийн газрын эрх бүх байгууллага" гэнэ) нь өөрийн үндсэн чиг үүргийг гүйцэтгэх зорилгоор дараахь газрыг тусгай хэрэгцээнд авч болно:

а/ бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй газар;

б/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ашиглалтын газар бүхэлд нь буюу хэсэгчлэн;

в/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн газрыг бүхэлд нь буюу хэсэгчлэн.

5. Газрын тухай Монгол Улсын хуулийн 18 дугаар зүйлийн дагалдах нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай хүсэлтийг дараахь байдалаар гаргана:

а/ 1 дэх хэсгийн 1-д заасан зориулалтаар газар нутгийг тусгай хэрэгцээнд авах хүсэлтийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага;

б/ 1 дэх хэсгийн 5-7-д заасан зориулалтаар газар нутгийг тусгай хэрэгцээнд авах хүсэлтийг хөдөө аж ахуйн болон газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага;

в/ 1 дэх хэсгийн 2-4, 8,9-д заасан зориулалтаар газар нутгийг тусгай хэрэгцээнд авах хүсэлтийг тухайн чиглэлийн асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага.

6. Газар нутгийг тусгай хэрэгцээнд авах хүсэлтэд дараахь зүйлийг тусгана:

а/ тусгай хэрэгцээнд авах зориулалт, зайлшгүй шаардлага, газар нутгийн хөрс ургамал, мал болон аж ахуйн үйл ажиллагааны тухай мэдээлэлгүй танилцуулга;

б/ авах газрын хэмжээ, хилийн заагийг урьдчилан тодорхойлсон цөм зураг;

в/ авах газрын байршлын зураг;

г/ авах газрын эзэмшил, ашиглалтын байдлын талаархи мэдээлэл, эзэмшигч, ашиглагчийн санал;

д/ тусгай хэрэгцээнд авах газрыг харьяалдаг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр буюу зөвшөөрөл.

7. Газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай хүсэлтэд тухайн газар нутгийг харьяалдаг аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг өрсөрсөн байна.

8. Газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай саналыг газрын тусгай зориулалт хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад оруулах нөхцөл тэр нь зохих журмын дагуу газар зохион байгуулалт, газрын тусгай зориулалт, төлөв байдлын үнэлгээ хийсний үндсэн дээр холбогдох аймаг, сум болон нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцүүлэн Засгийн газарт санал дүгнэлтээ оруулна.

9. Газрын тусгай зориулалт хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тусгай зориулалт оруулахын өмнө тухайн сум, дүүргийн газрын тусгай зориулалт хариуцсан албан тушаалтантай нь хамтран дараахь тогтоол хийнэ.

а/ эзэмшил, ашиглалтад олгоогүй төрийн өмчийн газраас авахад асан газрын хил заагийг газар дээр нь судалж зохих масштабын зураг зураг үйлдэн, хэмжээг тодотгох, сум, дүүрэгтэй тохиролцох;

б/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гэрээний дагуу ашиглаж байгаа газрыг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг авахаар санал болгож байгаа бол заасан газрын хил заагийг газар дээр нь тодотгож, зохих масштабын зураг үйлдэн, хэмжээг тодорхойлж, уг газарт хамрагдаж буй газар ашиглагчдад (улсын тусгай хэрэгцээнд авч ашиглах тухай) анхааруулга, сануулга өгсөн байх;

в/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гэрээний дагуу эзэмшиж байгаа газрыг авахаар санал болгож байгаа бол дүгнэлтэд заасан газрын хил заагийг газар дээр нь тодотгож хийж, зохих масштабын зураг үйлдэн, хэмжээг тодорхойлж, уг газарт хамрагдаж буй газар

газар эзэмшигчидтэй газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нөхө олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай урьдчилан тохирол цож газрын харилцааны асуудлуудыг зохицуулсан бичиг баримтыг зохиох журмын дагуу бүрдүүлсэн байх;

Тухайн газрыг эзэмшигчтэй урьдчилан тохиролцоходоо дараахь зүйлийг тохиролцон баталгаажуулна:

а/ нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах газрыг хэмжээ, зааг;

б/ уг газраас салгаж үл болох барилга, байгууламж, бусад эд хөрөнгийн жагсаалт, тэдгээрийг тухайн үеийн ханшаар үнэлсэн үнэ;

в/ газар чөлөөлөхөд гарах тээврийн ажил, түүний зардлыг тооцоо;

г/ уг газрыг тусгай хэрэгцээнд авсан тухай Улсын Их Хурал (Засгийн газар)-ын шийдвэр гарсан өдрөөс хойш газар чөлөөлөх хураана (он, сар, өдөр);

д/ тухайн эзэмшлийн газрыг өөр газраар солих тохиолдолд сүлдүүргийн Засаг даргаас олгохоор төлөөлөж буй газрын хэмжээ, зааг чанарыг зөвшөөрч байгаа эсэх тухай санал.

Урьдчилан тохиролцоонд нөхөх олговортойгоор солих бүх эргүүлэн авах газрын хил зааг, байршил болон газраас салгаж үл болох барилга, байгууламж, бусад эд хөрөнгийн схем зургийг зохиомол масштабаар үйлдэн хавсаргана.

10. Тухайн газар нутгийг дурдсан зориулалтаар тусгай хэрэгцээнд авах шаардлагагүй эсвэл боломжгүй бол газрын асуудал хариуцаа төрийн захиргааны төв байгууллага үндэслэл, шалтгааныг тодорхой заана.

Гурав. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай саналыг шийдвэрлэх

11. Газрын тухай Монгол Улсын хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4-т зааснаар газар нутгийг тусгай хэрэгцээнд авах материалыг 2 хувь, бусад зориулалтаар тусгай хэрэгцээнд авах материалыг 1 хувь бүрдүүлсэн байна.

Газрын тухай Монгол Улсын хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-д заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд газар авч тухай саналд газрын хэмжээ, төлбөрийн хэмжээг тогтоох талаар тухайн улс, олон улсын байгууллагатай урьдчилан тохиролцоо тохиролцоо, шаардлагатай бол газар ашиглуулах нөхцөл, журмыг олон улсын гэрээний төслийг хавсаргана.

12. Засгийн газар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай газрын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас оруулсан дүгнэлт, санал болон авах газрын хил зааг, хэмжээ тэдгээрийг зохих масштабаар харуулсан зураг болон газар эзэмшигчтэй урьдчилан хийсэн тохиролцоо зэрэгтэй уялдуулан авч хэлэлцээд Газрын тухай Монгол Улсын хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4-т заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, үүнээс бусад зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах асуудлаар шийдвэр гаргана.

13. Газар нутгийг тусгай хэрэгцээнд авахаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх саналын төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлнэ.

14. Газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай Засгийн газрын шийдвэрт дараахь асуудлыг тусгана:

а/ бусдын эзэмшил ашиглалтад олгоогүй газраас авч байгаа бол тухайн газрын байршил, хил зааг, хэмжээ;

б/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гэрээний дагуу ашиглаж байгаа газрыг авч байгаа бол авсан газрын байршил, хил зааг, хэмжээ, газар чөлөөлөх хугацаа;

в/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаа газрыг авч байгаа бол авсан газрын байршил, хил зааг, хэмжээ болон газар эзэмшигчтэй урьдчилан хийсэн тохиролцоог харгалзан уг газраас салгаж үл болох барилга, байгууламж, бусад эд хөрөнгийг тухайн үеийн ханшаар үнэлсэн үнэ, газар чөлөөлөхөд гарах зайлшгүй шаардлагатай зардлыг хянаж үзээд газар эзэмшигчдэд олгох нөхөх олговор ба газар чөлөөлөхөд гарах зардлын хэмжээ, уг нөхөх олговор, зардлыг олгох санхүүгийн эх үүсвэр, түүнийг тухайн сум, дүүргийн төсөвт шилжүүлэх болон газар чөлөөлөх хугацаа.

**Дөрөв. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан
тухай шийдвэрийг хэрэгжүүлэх**

15. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гэрээний дагуу ашиглаж байгаа газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан тухай шийдвэрийг дараахь журмаар хэрэгжүүлнэ:

а/ зохих журмын дагуу улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглах эрхийг тухайн сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр дуусгавар болгож, газар чөлөөлөх мэдэгдлийг уг газрыг ашиглагчид өгч, хууль

тогтоомжид заасан журмаар чөлөөлнө;

6/ Газар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага уг газраа өөр газраар солих тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг дарга шинээр газар олгох шийдвэр гарган, гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, гэрээг улсын бүртгэлд бүртгэнэ.

16. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гэрээний дагуу эзэмшиж байгаа газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан тухай шийдвэрийг даарахь журмаар хэрэгжүүлнэ:

1/ Улсын Их Хурал (Засгийн газар)-ын шийдвэр болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай урьдчилан тохиролцсон тохиролцоог үндэслэн уг газрыг улсын тусгай хэрэгцээнд нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай гэрээг дор дурдсанаар тухайн сум, дүүргийн Засаг дарга байгуулна:

а/ аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах гэрээг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягт ТХГ-1-ийн дагуу;

б/ иргэнтэй байгуулах гэрээг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягт ТХГ-2-ын дагуу.

2/ Засгийн газрын шийдвэр болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай тэдэнтэй байгуулсан гэрээг үндэслэн уг газрыг эзэмших эрх дуусгавар болсон тухай тухайн сум, дүүргийн Засаг дарга шийдвэр гаргана.

3/ Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газраа өөр газраар солих тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг дарга урьдчилан тохирсон газрыг эзэмшүүлэх шийдвэр гаргаж, газрын асуудал хариуцсан ажилтнаар дамжуулан газар эзэмших гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, уг гэрээг улсын бүртгэлд бүртгэнэ.

4/ Хувийн гэр, орон сууцны зориулалтаар эзэмшиж буй газрыг чөлөөлөх ажлыг зөвхөн 5 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 15-нд хийнэ.

5/ Газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох нөхөх олговор, газар чөлөөлөх зардлыг улсын тусгай хэрэгцээнд газар авч байгаа Засгийн газрын эрх бүхий байгууллага хариуцан заасан эх үүсвэрээс тухайн сум, дүүргийн Засаг даргын мэдэлд шилжүүлнэ.

6/ Энэ зүйлийн 1-д заасны дагуу байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол сум, дүүргийн Засаг дарга уг гэрээг байгуулсан өдрөөс хойш 60 хоногийн дотор нөхөх олговрыг тухайн газрыг эзэмшиж байсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гаргаж өгнө.

7/ Газар чөлөөлөх зардлыг бодит гүйцэтгэлийг харгалзан олгоно. Шаардлагатай бол тухайн сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр

урьдчилгаа олгож болно.

8/ Энэ зүйлийн 1-д заасны дагуу байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрт нь нөхөх олговрыг бүрэн төлсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор холбогдох газрыг чөлөөлж сум, дүүргийн Засаг даргын мэдэлд шилжүүлэх үүрэгтэй.

9/ Эзэмшил газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авахад олгох нөхөх олговор нь тухайн газар ашиглагчид үл хамаарна.

10/ Байгуулсан гэрээнд заасан хугацаанд газраа чөлөөлөөгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг гэрээнд заасны дагуу зохих арга хэмжээ авч, газрыг хууль тогтоомжид заасан журмаар албадан чөлөөлүүлдэг.

Тав. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан тухай тайлагнах

17. Тусгай хэрэгцээнд авсан газрын хил, зааг, хэмжээ ашиглалтын зориулалт, олгосон нөхөх олговор, зардлын тооцоог тухайн сум, дүүргийн Засаг дарга, газрын асуудал хариуцсан албан тушаалтан газар эзэмшигч, ашиглагч бүрээр гаргаж холбогдох материалын хамтаар газрын болон санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад уг газрыг бүрэн чөлөөлснөөс хойш 14 хоногийн дотор тайлагнана.

Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах журмын I дүгээр хавсралт

Маягт ТХГ-1

Батлав: аймэг (нийслэл)-ийн

..... сум (дүүрэг)-ийн

Засаг дарга (нэр)
(гарын үсэг)

ГАЗРЫГ УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНД НӨХӨХ ОЛГО-
НОРТОЙГООР СОЛИХ БУЮУ ЭРГҮҮДЭН АВАХТАЙ
ХОЛБОГДУУЛАН ГАЗАР ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГАТАЙ ХИЙСЭН ГЭРЭЭ

199__ оны __ дугаар сарын __ ны өдөр Дугаар ____

Газрын тухай Монгол Улсын хууль, газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан тухай Улсын Их Хурал (Засгийн газар)-ын 199__ оны __ дугаар сарын __ ны өдрийн __ дугаар тоот шийдвэрийг үндэслэн:

Газар өмчлөхийг төлөөлж _____ аймэг (нийслэл)-ийн _____ сум (дүүрэг)-ийн газрын зуураал харуусан далан тушаалтан _____ овогтой _____,

Газар эзэмшигчийг төлөөлж _____ аймэг (нийслэл)-ийн _____ сум (дүүрэг)-ийн ____-р бол (хороо)-ийн нутаг дэвсгэрт орших _____ тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, _____ т.о. регистрийн дугаар _____ банканд _____ тоот хариуцах дэнстэй _____-д (аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

_____ ажилтай _____ овогтой _____ нэг (хэблэн тушаалын нэр) доорхи зүйлийг тохиролцон энэ гэрээг байгуулан

НЭГ ГЭНГЭНИЙ НӨХЦӨЛ

1. Газраас салгаж үл болох баримта, байгууламж, бусад эд мөртөлийн хөгсөөлт, тэдгээрийг тухайн үеийн ханшаар үнэлсэн үнэ

2. Нөхөх олгооны хэмжээ

(цацванд эшиглэх боломжгүй, газраас салгаж үл болох баримта байгууламж бусад

_____ 1 _____
эд хөрөнгийг тухайн үеийн ханшаар үнэлсэн үнэ)

3.Газар чөлөөлөх ажлыг гүйцэтгэх хэлбэр, зайлшгүй гаргах зардал:

(Газар чөлөөлөх ажлыг газар эзэмшигч өөрөө, эсвэл аж ахуйн нэгж,

байгууллагаар ямар техникээр хуугүйцэтгэх, чөлөөлсөн газрыг ангони

байдалд оруулахыг зарцуулах эзэн, тэдгээрт шаардлагад төрөнгө)

4.Нөхцөл байдалд олгосон байх эхний хугацаа:

199_ оны _ хугаар сарын __ ны өдөр.

5.Газар чөлөөлсөн байх эхний хугацаа:

199_ оны __ хугаар сарын __ ны өдөр.

6.Газар чөлөөлсөн байх эхний хугацаанд уг газрыг чөлөөлөөгүй байх тохиолдолд газар өмчлөгчийн бүрэн эрх:

(Газар эрх хэмжээг тодорхой хэлж)

7.Газар эзэмшигч уг газрыг өөр газраар сольж тохиолдолд газар өмчлөгчийн хүлээх үүрэг:

(Эхний эрх олгох газрыг тодорхой хэлж өгнө)

8.Талуудын хоорондын бүслэ тохиролцоо:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар	Эхний төлөөлж	Газар эзэмшигч
.....дэмж (нийслэл)-ийн дэмж (нийслэл)-ийн
.....-сум (зүүрэг)-ын-сум (зүүрэг)-ын
Газрын н.хариуцсан албан тушаалтан-р бол (хороо)-ийн нутаг дэвсгэрт
.....(нэр)	оршиж
.....(үсэг)-ын
		(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)
		захирал
	(нэр)
		(гарын үсэг)

Газрыг улсын тусгай хэрэгцээнд авал
журмын 2 дугаар хэсэрт

Макет ТХГ-2

Батлан _____ аймаг (ноёслал)-ийн
_____ сум (дүүрэг)-ийн
Засаг дарга _____ (нэр)

**ГАЗРЫГ УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНД НӨХӨХ
ОЛГОВОРТОЙГООР СОЛИХ БУЖУУ ЭРГҮҮЛЭН
АВАХТАЙ ХОЛБОГДУУДАН ГАЗАР ЭЗЭМШИГЧ
ИРГЭНТЭЙ ХИЙСЭН ГЭРЭЭ**

199_ оны __-р сарын __-ны өдөр Дугаар _____

Газрын тухай Монгол Улсын хууль, газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан
тухай Улсын Их Хурал (Засгийн газар)-ын 199__ оны __ дугаар сарын __-ны өдрийн
_____ дугаар тоот шийдвэрийг үндэслэн:

Газар өмчлөгчийг төлөөлж _____ аймаг (ноёслал)-ийн
_____ сум (дүүрэг)-ын газрын жуузал хариуцсан албан
тушаалтан _____ овогтой _____;

Газар эзэмшигч _____ аймаг (ноёслал)-ийн
_____ сум (дүүрэг)-ын _____-р байрны нутаг дэвсгэрт (хорооны -р
гуламжны _____ тоотод) оршин суугч _____ тоот регистр, _____ тоот
паспортог _____ овогтой _____ нар доорхи
зүйлийг тохиромжон энэ гэрээг байгуулах.

НЭГ.ГЭРЭЭНИЙ НӨХИӨЛ

1.Газраас салгаж үл болох баримт, байгууламж, бусад эд хөрөнгийн жагсаалт
талдгэрийг тухайн үеийн ханшаар үзэлсэн үнэ:

2.Нөхөх өгчөврийн хэмжээ:

(шавшид адрглах боломжгүй, газраас салгаж үл болох баримт байгууламж, бусад
эд хөрөнгийг тухайн үеийн ханшаар үзэлсэн үнэ)

3. Газар чөлөөлөх ажлыг гүйцэтгэх хэлбэр, зайлшгүй гарах зардал:

(газар чөлөөлөх ажлыг газар эзэмшигч өөрөө, эсвэл аж ахуйн нэгж, байгууллагаар

ямар төлөвдөөр хут гүйцэтгэх, чөлөөлсөн газрыг аюулы

байдалд оруулсныг хэлнэвч эхэн, тэдгээрт шаардагдах хөрөнгө)

4. Нөхөх олговор олгосон байх эхсийн хугацаа:

19__ оны __ дугаар сарын __ ны өдөр

5. Газар чөлөөлсөн байх эхсийн хугацаа:

199__ оны __ дугаар сарын __ ны өдөр

6. Газар чөлөөлсөн байх эхсийн хугацаанд уг газрыг чөлөөлөөгүй байх тохиолдолд газар өмчлөгчийн бүрэн эрх:

(давх эргэ хэсгээг тодорхой зааж)

7. Газар эзэмшигч уг газраа өөр газраар сольж тохиолдолд газар өмчлөгчийн хүлээх үүрэг:

(шилжээр олгох газрыг тодорхой зааж өгөх)

8. Талуудын хоорондын бусал тохиролцоо:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар өмчлөгчийг төлөөлж:

Газар эзэмшигч:

_____ аймаг (ноёислэл)-ийн

_____ аймаг (ноёислэл)-ийн

_____ сум (дүүрэг)-ын

_____ сум (дүүрэг)-ын

газрын асуудал хариуцсан албан тушаалтан

-----р баг (хороо)-ийн нутаг дэвсгэрт

_____ (нэр)

оршин суугч иргэн _____ (нэр)

(гарын үсэг)

(гарын үсэг)

Засгийн газрын 1995 оны 143 дугаар
тогтоолын 6 дугаар хавсралт

**АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ҮЙЛДВӨРЛЭЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ЗОРИУЛАН ЭЗЭМШҮҮ-
ЛЭХ ГАЗРЫН ДЭЭД ХЭМЖЭЭ (ГА)**

Газар зориулалтын зориулалт	Бүс нутаг					
	Өмнөд сүр	Х-р	Төв	Ивэ нүүрну-дэл мөсөл	Шийсэл, гурван амгакч 40 км цөмөр-тэй газар	Бусад хот, гурван амгакч 25 км шил цөмөр-тэй газар
1. Газар тариалангийн үйлдвэрлэл дагнан эрхлэхэд						
1.1. Ур сарна, тэжээлийн ургамал	12000	10000	10000	20000	18000	24000
1.2. Төмс, тусламж өндөр, төхөөр-мөөн ургамал	800	1000	500	400	250	300
2. Газар тариалангийн үйлдвэрлэлийг туслах чиглэлээр эрхлэхэд						
2.1. Ур сарна, тэжээлийн ургамал	1200	1500	500	400	400	600
2.2. Төмс, тусламж өндөр, төхөөр-мөөн ургамал	200	250	50	25	25	30
3. Байгалийн хадлан бэлтгэх						
3.1. Байгалийн хадлан бэлтгэлийн дагнан эрхлэл	10000	12000	1500	2000	400	600
3.2. Байгалийн хадлан аж ахуйн зориулалтын зориулалт бэлтгэх	60	100	25	20	20	25
4. Бэлтгэл (жоншны байртай ба бусад хотын орчимд мал аж ахуйн туслах үйлдвэрлэлийн төслүүд эрхлэхэд зориулалт аж ахуйн нэгжид зориуулах)					400	500
* Хотын аж ахуйн үйлдвэрлэлийн төслүүд ба хотын барилга байгуу-лалтын зориулалт					12	18
5. Хот, цогцон, бусад суурин газар						
5.1. Үйлдвэрлэлийн барилга байгууламж, дагалдах үйлдвэрлэлийн хөдөлгөөний зориулалт			100000000		бусад хотын 60	
5.2. Уурхайн зориулалт (бусад хотын хот суурин газар зориулалтаар)					2000	

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 8 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 145

Улаанбаатар
хот

**Төрийн захиргааны болон үйлчилгээний албаны
албан хаагчийн албан тушаалын цалингийн
сүлжээг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралтын, төрийн үйлчилгээний албаны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Төрийн үйлчилгээний албаны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 1995 оны 9 дүгээр сарын 1-ний, төрийн захиргааны албаны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг мөн оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс тус тус дагаж мөрдүүлсүгэй.

3. "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албаны албан хаагчийн цалингийн сүлжээг батлах тухай" Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 95 дугаар тогтоолын 4-ийн "б" заалтыг "б) төрийн захиргааны болон үйлчилгээний албаны албан хаагчийн ажлыг үнэлж дүгнэсний үндсэн дээр батлагдсан цалингийн сандаа багтаан цалингийн сүлжээний дагуу тухайн албан хаагчийн албан тушаалын цалинг нэмэгдүүлэх асуудлыг тэдний ажилласан хугацаанаас хамааралтайгаар эрхэлж байгаа албан ажлынх нь үр дүнтэй холбон шийдвэрлэж байх журам тогтоон мөрдөж ажилласугай" гэж өөрчлөн найруулсугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албаны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг батлах тухай" Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 95 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлээр баталсан 1 дүгээр хавсралтыг энэ оны 10 дугаар сарын 31-нээр, 2 дугаар хавсралтыг мөн оны 8 дугаар сарын 31-нээр тасалбар болгон тус тус хүчингүй болгонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд
Сангийн сайд

П. ЖАСРАЙ
Э. ГОМБОЖАВ
Э. БЯМБАЖАВ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН
ТҮШИАЛЫН ЦАНИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард-төрөлснөр)

Засгийн газар (197) оны 1-д эрхэл

ингэнийн 1 эрхэл өөрчлөл

Ажлын гүйцэтгэлийн үндэсний

Төрлийн ангилал Ажлын гүйцэтгэлийн ингэнийн 1 эрхэл өөрчлөл Төрөл (сүүлцүүл)	ТЭ-1	ТЭ-2	ТЭ-3	ТЭ-4	ТЭ-5	ТЭ-6	ТЭ-7	ТЭ-8	ТЭ-9	ТЭ-10	ТЭ-11	ТЭ-12	ТЭ-13
1	15400	16400	17300	18200	19100	20000	20900	21800	22700	23600	24500	25400	26300
2	15600	16600	17500	18400	19300	20200	21100	22000	22900	23800	24700	25600	26500
3	15800	16800	17700	18600	19500	20400	21300	22200	23100	24000	24900	25800	26700
4	16000	17000	17900	18800	19700	20600	21500	22400	23300	24200	25100	26000	26900
5	16200	17200	18100	19000	19900	20800	21700	22600	23500	24400	25300	26200	27100
6	16400	17400	18300	19200	20100	21000	21900	22800	23700	24600	25500	26400	27300
7	16600	17600	18500	19400	20300	21200	22100	23000	23900	24800	25700	26600	27500
8	16800	17800	18700	19600	20500	21400	22300	23200	24100	25000	25900	26800	27700
9	17000	18000	18900	19800	20700	21600	22500	23400	24300	25200	26100	27000	27900
10	17200	18200	19100	20000	20900	21800	22700	23600	24500	25400	26300	27200	28100
11	17400	18400	19300	20200	21100	22000	22900	23800	24700	25600	26500	27400	28300
12	17600	18600	19500	20400	21300	22200	23100	24000	24900	25800	26700	27600	28500
13	17800	18800	19700	20600	21500	22400	23300	24200	25100	26000	26900	27800	28700
14	18000	19000	19900	20800	21700	22600	23500	24400	25300	26200	27100	28000	28900
15	18200	19200	20100	21000	21900	22800	23700	24600	25500	26400	27300	28200	29100
16	18400	19400	20300	21200	22100	23000	23900	24800	25700	26600	27500	28400	29300
17	18600	19600	20500	21400	22300	23200	24100	25000	25900	26800	27700	28600	29500
18	18800	19800	20700	21600	22500	23400	24300	25200	26100	27000	27900	28800	29700
19	19000	20000	20900	21800	22700	23600	24500	25400	26300	27200	28100	29000	29900
20	19200	20200	21100	22000	22900	23800	24700	25600	26500	27400	28300	29200	30100
21	19400	20400	21300	22200	23100	24000	24900	25800	26700	27600	28500	29400	30300
22	19600	20600	21500	22400	23300	24200	25100	26000	26900	27800	28700	29600	30500
23	19800	20800	21700	22600	23500	24400	25300	26200	27100	28000	28900	29800	30700
24	20000	21000	21900	22800	23700	24600	25500	26400	27300	28200	29100	30000	30900

24 ба 25-р түүхээр оруу

Эхлэлийн газрын 1995 оны 145 дугаар
тогтоолын 2 дугаар хэсгээр

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН
ТҮШААЛЫН ЦАНИНГИЙН СҮЛЖЭЭ

(сая.төг/сая.төг)

Төрийн үйлчилгээний албан хаагчийн үйлчилгээний албаны нэр (сая.төг)	ТҮ-1	ТҮ-2	ТҮ-3	ТҮ-4	ТҮ-5	ТҮ-6	ТҮ-7	ТҮ-8	ТҮ-9	ТҮ-10	ТҮ-11	ТҮ-12	ТҮ-13	ТҮ-14
1-2	11800	12050	13100	14150	15400	18300	19600	21000	23450	24800	26800	28500	31600	35600
3-4	11600	12700	13600	14700	15900	19000	20200	21600	23100	24600	27600	29400	32600	36500
5-6	12100	13200	14200	15300	16500	19700	20800	22200	23600	25100	28100	30200	33600	38100
7-8	12800	13600	14800	15900	17100	20400	21500	22900	24500	26100	29200	31300	34700	39700
9-10	13500	14100	15400	16700	17900	21200	22300	23700	25300	26900	30100	32400	35800	
11-12	14100	14600	16000	17400	18500	22000	23000	24700	26300	27900	30900	33200	37000	
13-16	14700	15200	17000	18100	19100	22600	23600	25400	26800	28400	31500	34700	38200	
15-16	15100	15900	17400	18500	19600	23200	24200	25900	27400	28800	29100	32300		
17-18	15500	16500	17800	18900	20100	23750	24700	26300	28000					
19-20	16000	17000	18200	19300	20600	24050	25100	26600	28300					
21-22	16500	17500	18700	19700	21000	24350	25400	26900	28600					
23-24	17000	18000	19200	20200	21500	24650	25700	27200	28900					
25 ба дараагийн үйлчилгээний албан хаагчийн үйлчилгээний албаны нэр (сая.төг)	17500	18500	19700	20700	22000	24950	26000	27500	29200					

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1995 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 372

Улаанбаатар
хот

**ЭБШ хуулийн хэргийг давж заалдах
журмаар хянан хэлэлцэх талаарх зарим
зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах
тухай**

"Эрүүгийн хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэж байгаа шүүхийн практикийн тухай" Дээд шүүхийн бүгд хурлын, 1984 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 37 дугаар тогтоол одоог хүртэл мөрдөгдөж байгаа билээ. Гэтэл уул тогтоол гарснаас хойш уг асуудлаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулж түүний зарим зүйл, хэсэг, заалтыг тодотгон тайлбарлах шаардлагатай болов.

Иймд эрүүгийн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлээ нэгдсэн практик тогтоох, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1994 оны 3 дугаар сарын 28, 1995 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулийн заалтын нэг мөр эйлгэн, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн цаашид "ЭБШХууль" гэх хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэх ажиллагааг зохицуулсан зарим зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар тайлбарласугай:

1. ЭБШ Хуульд заасан "давж заалдах" гэдэг нь шүүн таслах ажиллагаанд оролцогч талууд Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэг, ЭБШ Хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийг шийдвэр болох таслан шийдвэрлэх тогтоол, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид / цаашид "шүүхийн шийдвэр" гэх/ хуульд заасан хугацаа, үндэслэл, журмын дагуу гомдол гаргах, уул гомдлыг давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагааны цогц мөн Иймд ямар оролцогч шүүхийн ямар шийдвэрт давж заалдах гомдол гаргаж болох, гомдлоо хаана, ямар хугацааны дотор гаргах тухай ЭБШ хуулийн заалтуудыг оролцогч бүрт сайтар тайлбарлан ойлгуулах, хэргийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх талаар хуулийн заалтыг чанд мөрдөн ажиллах нь шүүх, шүүгч бүрийг үүрэг болно.

2. ЭБШ хуулийн 317-р зүйлийн 1 дэх хэсгийн "таслан шийдвэрлэх тогтоол" гэдэгт шүүхээс эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцээд гаргасан таслан шийдвэрлэх шийтгэх болон цагаатгах тогтоол, 323 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж" гэдэгт мөн зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад шүүхийн бүх тогтоол, шүүгчийн бүх захирамжийг хамааруулж ойлгоно. Шүүгдэгч, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, хохирогч, түүний төлөөлөгч, яллагч /эсэргүүцэл бичих замаар/ барын хэн алин нь дээрх бүх шийдвэрт бүтээд нь тэдгээрт тусгагдан аль ч асуудлаар, харин иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, эдний төлөөлөгч, түүнчлэн цагаатгагдсан этгээд зөвхөн өөрт холбогдох асуудлаар түүнтэн иргэдийн төлөөлөгч 49¹-р зүйлд заасан рхийнхээ дагуу галтхүү таслан шийдвэрлэх тогтоолын шүүгдэгч гэм уруутай эсэх тухай асуудлаар тус тус давж заалдах гомдол гаргах рхтэй.

3. ЭБШ хуулийн 318-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар сум буюу ум, дунд, дүүргийн шүүхийн шийдвэрт давж заалдсан гомдол, эсэргүүцлийг/ харьяалах аймаг, нийслэлийн шүүхэд аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэрт давж заалдсан гомдлыг Улсын Дээд шүүхэд аялдан гаргах боловч тухайн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхэд өгч байх нь зүйтэй гэж үзнэ. Гомдол, эсэргүүцлийг хүлээн авсан шүүх түүнийг эрх бүхий оролцогч гаргасан сэх, гомдол, эсэргүүцэл нь бүрдэлбэр, гарсан хугацааны хувьд хуулийн заалтад нийцэж байгаа эсэх, давж заалдаж болох асуудлаар эрсэн эсэхийг хянаж, бусад оролцогчлод мэдэгдэж, танилцах бололцоо олгон, хариу тайлбар, шинэ нотлох баримт гаргавал хүлээн өч хавсарган, хавтаст хэргийн хамтаар давж заалдах шатны шүүхэд суурхай илгээж байвал зохино.

4. ЭБШ хуулийн 318-р зүйлийн 1 дэх хэсгийн 2-д заасанчлан Улсын Дээд шүүхээс гаргасан таслан шийдвэрлэх тогтоолын талаар Улсын Дээд шүүхэд давж заалдах бөгөөд давж заалдах шатны шүүх үрэлдвэнд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Дээд шүүхийн 3 шүүгч оролцоно.

ЭБШ хуулийн 323-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан энэ хуулийн 1, 42, 106, 223, 229, 230, 243, 253, 256, 259 /үүнд торгууль ногдуулах тухай шийтгэвэр хамаарахгүй/, 270, 271, 274, 279, 282-р рил, 300-р зүйлийн 1 дэх хэсэг, 361, 391, 391¹ дүгээр зүйлд заасан хниолдтуудал гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж" гэдэгт "эрүүгийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх, нэг шүүхээс ргөөд шилжүүлэх, шүүх хурлын протокола засвар оруулах, яллаг-

дагчийг шүүхэд шилжүүлэх, энэ үед гарсан хүсэлтийг хянан хэлтэцэх, шүүгдэгч шүүх хурлын ажиллагаанд оролцох асуудлыг шийдвэрлэх хэргийг тэдгээлд, харьяаллын дагуу шүүхэд шилжүүлэх хэрэг хэлэлцэх явлыг хойшлуулах ба эрүүгийн хэргийг тэдгээлд, таслан сэргийлэх арга хэмжээний тухай асуудлыг шийдвэрлэх, шүүх хуралдааны журам зөрчилчдөд хариуцлага хүлээлгэх/ түүгээр торгууль оногдуулах тухай шийтгэвэр хамаарагдахгүй/, шүүх хурал хүсэлт гаргах ба түүнийг шийдвэрлэх, оролцогчдын аль нэгн байхгүйгээр хэргийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх, шүүгдэгч байгаа журмыг тогтоох, насанд хүрээгүй гэрчийг байгаа журмыг тогтоох, шүүх хурлын үед шинэчилсэн байдалтыг сэргээх, шийтгэлгүйд тооцох тухай хүсэлтийг хэлэлцэх, насанд хүрээгүй шүүгдэгчийг шүүх хурлын танхимаас гаргах, түүнд хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахыг холбогдсон ажиллагааг шийдвэрлэх хэрэг асуудлаар гарсан шийдвэр тус тус хамаарах бөгөөд гэдгээрт заалдах гомдол гаргаж болохгүй. Түүнчлэн 60-р зүйлийн 4-д дурдсан шүүгчийг татгалзсан тухай асуудлаар гарсан ерөнхий шүүгчийн шийдвэр, 354-р зүйлийн 6 дурдсан /прокурорын эсэргүүцэлд энэ заалт хамаарахгүй /яла хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих тухай шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргаж болохгүй. Дээд тохиолдолд шүүх эдгээр асуудлаар гарсан давж заалдсан гомдлын хуулийн заалтыг баримтлан хүлээн авахаас татгалзаж байвал зохин.

6. ЭБШ хуулийн 320, 323-р зүйлд зэвсгээр "таслан шийдвэрт тогтоол", "шүүхийн тогтоол", "шүүгчийн захирамж"-д давж заалдсан гомдлыг уг шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор /хэр шүүгдэгч цагдан хоригдож байгаа бол хугацааг шийдвэр гаргуулсан өдрөөс тоолно/ гаргах бөгөөд 10 хоногийг шийдвэр унши сонгосон өдрийн 00 цагаас эхлэн тоолно.

7. ЭБШ хуулийн 320-р зүйлийн "таслан шийдвэртэх тогтоол гомдол, эсэргүүцлийг уг таслан шийдвэртэх тогтоолыг унши сонгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор гаргаж болно" гэсэн заалт нь хуулийн энэ заалтыг уг хууль мөрдөж эхэлсэн 1995 оны дугаар сарын 1-ний өдрөөс өмнө таслан шийдвэртэх тогтоолыг унши сонгосон буюу хуулбарыг нь гардуулаад 10 хоног өнгөрсөн болон уг өдрөөс хойно шийдвэрлэгдсэн нийт хэрэгт хамаарна.

8. ЭБШ хуулийн 322-р зүйлийн "таслан шийдвэртэх тогтоол хэргийн төгөлдөр болоогүй байхад давж заалдах гомдол буюу эсэргүүцэл бичигдсэн байвал таслан шийдвэртэх тогтоол биелүүлэхийг тэдгээлд зүүлдэг" гэсэн заалтыг хэрэглэхэд шүүхээс ямар нэгэн баримт бичиг гаргах шаардлагагүй бөгөөд хуулийн энэ заалтын дагуу таслан

ийдвэрлэх тогтоол биелүүлэх ажиллагаа шууд түдгэлзэгдсэнд шогдоно.

1. Давж заалдах шатны шүүхийн магадлал гярснаар анхан шатны үхийн шийдвэрийг биелүүлэхийг түдгэлзүүлэх ажиллагаа дуусга-
р болох бөгөөд гаргахуу гэм буруутай этгээдэд "шаазаар авах" ял
огдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол /магадлал/-ыг
алүүлэх ажиллагаа хэргийг Шүүхийн тухай хуулийн 24-р зүйлийн
дахь хэсгийн 10-д заасны дагуу Дээд шүүхийн хяналтын шатны
рмаар хянан хэлэлцэх, улмаар ялганд уучлал үзүүлэх эсэх тухай
удмыг Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэрлэх хүртэл "Хорихоос
р төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга
ажээг хэрэгжүүлэх тухай" хуулийн заалтын дагуу түдгэлзэгдсэнд
шогдоно.

О. ЭБШ хуулийн 327-р зүйлд "давж заалдах шатны журмаар
эг хянан хэлэлцэх хуралдаанд прокурор, шийтгэгдсэн букоу
загтгагсан этгээд, түүний өмгөөлөгч, хохирогч, түүнчлэн иргэний
сэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч оролцох эрхтэй"
с тухайлан нэртэж заасан учир тэднээс бусад оролцогч тухайлбал
үхэл шилжээгүй яллагагч, буусан, хойшилсон зэрэг шалтгаанаас
эг нь эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа шүүгдэгч, тэдний өмгөө-
чийг давж заалдах шатны шүүх хуралдаанд заавал оролцуулах
ардлагагүй. Харин шүүх хэргийн бодит байдлыг тогтооход шаард-
атай гэж үзвэл давж заалдах шатны шүүх хуралдаанд гэрч, шин-
энийн оролцуулж мэдүүлэг авч болно.

1. ЭБШ хуулийн 46 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан "сэжиг-
ч, яллагагчийн сонгож авсан өмгөөлөгч уг хэрэгт оролцох бо-
жгүй болсон, түүнчлэн өмгөөлөгчөөсөө татгалзсан бол сэжигтэн,
яллагагч, шүүгдэгч өөр өмгөөлөгч сонгон авна" гэсэн заалтыг тэд
эргээ байцаан шийтгэх ажиллагаа, түүний дотор шүүн таслах
яллагааны аль ч үед хуульд зааснаар эдэлж болох, бөгөөд шүүг-
ч давж заалдах гомдол гаргах үедээ өөр өмгөөлөгч сонгон авах
зу урьд сонгон авсан өмгөөлөгч нь давж заалдах шатны шүүхийн
яллагад оролцох боломжгүй бол өмгөөлөгчийг ЭБШ хуулийн
-р зүйлд зааснаар шүүгдэгчийн зөвшөөрснөөр өөр өмгөөлөгчөөр
аж болно гэж ойлгоно.

2. ЭБШ хуулийн 328-р зүйлд заасан, журмаар давж заалдах шат-
шүүхэд гаргасан нэмэлт нотлох баримт нь энэ хуулийн 69-р
лд заасан аливаа нотлох баримтад тавигдах хэрэгт хамааралтай,
холбогдолтой байх, хуульд заасан журам, арга хэрэгсэлээр цуг-
сан, түүний шардлагад тохирсон байх зэрэг нийтлэг зарчмыг
гасан байвал зохино.

13. ЭБШ хуулийн 244-р зүйлд зааснаар анхан шатны шүүх хурал даанд "яллагч", 327-р зүйлд зааснаар давж заалдах шатны шүүх хуралдаанд "прокурор" оролцох бөгөөд тэд хуульд заасан өөр өөрсдийн чиг үүргийн дагуу тухайн шатны шүүх хуралдаанд бие даасан санал дүгнэлт гаргах үүрэгтэй учраас давж заалдах шатны хуралдаанд оролцож байгаа прокурор бүрэн эрхийнхээ хүрээнд ямар ч дүгнэлт түүний дотор анхан шатны шүүх хуралдаанд оролцсон яллагчийг яллахаас татгалзсан буюу хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх тухай шүүхийн саналыг хүлээн авахаас татгалзсан саналаас өөр дүгнэлт гаргаж болно.

14. Хэрэв яллагч ЭБШХуулийн 254 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх тухай шүүхийн саналыг хүлээн авахаас татгалзсан буюу шүүх ЭБШ хуулийн 196-р зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан "Шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон болох нь батлагдаагүй" гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрт энэ хуульд заасан ердийн журмаар давж заалдах томдолоо гаргах буюу эсэргүүцэл бичиж болно. Уг асуудлаар давж заалдах болон хяналтын шатны шүүхийн магадлал, тогтоол гарсан тохиолдолд хэргийг сэргээн шалгах асуудлыг ЭБШ хуулийн гучин гуравдугаар бүлэгт заасан шинээр илэрсэн нөхцөл байдлаас хэргийг сэргээх журмын дагуу шийдвэрлэнэ.

15. ЭБШ хуулийн 329¹-р зүйлийн 1 дэх хэсгийн "оролцогчид" гэдгийг 327-р зүйлд нэрлэсэн, энэ тогтоолын 10-д дурдсан давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох эрх бүхий хүмүүстэй адилтга ойлгох бөгөөд мөн зүйл, хэсгийн "оролцогчид давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцож байгаа бол" гэдгийг тэдний аль нэг нь давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцохыг ойлгоно.

16. Давж заалдах шатны шүүхийн магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж давж заалдсан томдолоо, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгосон буюу шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон түүнчлэн өөрчилсөн, хэрэгт нэмэлт мөрдөн байцаалта буюу шүүхээр шинэчлэн хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэл, шалтгааныг тодорхой зааж байвал зохино.

17. Давж заалдах шатны шүүх-хуралдаанаар хэрэг хэлэлцэхэд ЭБШ хуулийн 59-р зүйлд заасан "шүүгч оролцож болохгүй", 58-р зүйлд заасан "шүүгч дахин оролцож болохгүй" үндэстэл байгаа эсэхийг давж заалдах шатны шүүхийн хуралдааныг даргалагч сайтар нягтал байх үүрэгтэй.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ТАНХИМЫН ТЭРГҮҮН ШҮҮГЧ**

**Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН
Ч. ГАНБАТ**

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий зөвлөгч Н. Ринчендорж
Нарийн бичгийн дарга Сан. Жаргалсайхан
Гишүүд Т. Баасансүрэн
Ч. Бавуу
Б. Ганбат
Б. Янжинпалам

Техник редактор С. Итгэл
Уншиж хянасан Сан. Жаргалсайхан
Б. Янжинпалам

Үйлдвэрт шилжүүлсэн 1996 оны 1-р сарын 27-нд.
Өрсөлтөд 1996 оны 1-р сарын 29-нд. Хэвлэгдэв
1996 оны 3-р сарын 4-нд. Хэвлэлийн хуудас 8.0.
Хэвлэсэн тоо 4500 ширхэг.

Манай хяг: Улаанбаатар-12
Төрийн ордон. Утас: 322838

Засгийн газрын хэвлэл үйлдвэр